МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЗАРИМ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН”

Судалгааны төрөл: **Тогтоолын хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа**
Судалгааны код: **БГСТ-25/007**
Хугацаа: **2025.3.13-2025.3.27**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: М.Гэрлээ, эрх зүйч, магистр

Улаанбаатар хот, 2025

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БАХ	– Бэлчээр ашиглагчдын хэсэг
БОАЖЯ	– Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОУАӨЯ	– Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ДНБ	– Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮХС	– Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИТХ	– Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАА	– Мал аж ахуй
МААЭЗЭН	– Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл
МУЗГ	– Монгол Улсын засгийн газар
МЭГ	– Мал эмнэлгийн газар
МЭҮТ	– Мал эмнэлэг, үржлийн тасаг
МЭЭСБУЛ	– Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори
МХЕГ	– Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НМЭГ	– Нийслэлийн мал эмнэлгийн газар
ОУБ	– Олон улсын байгууллага
ТББ	– Төрийн бус байгууллага
ТМТББ	– Төрөөс малчдын талаар баримтлах бодлого
УИХ	– Улсын Их Хурал
ҮСХ	– Үндэсний статистикийн хороо
ХХААГ	– Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	– Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХШҮДАГ	– Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЭМГ	– Эрүүл мэндийн газар
УМЭАЦТЛ	– Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төвлөрсөн лабортори

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилгоор хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, газар тариалан, мал аж ахуйн салбарыг дэмжих, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлжээр ирсэн.

Тодруулбал, Монгол Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр үндэсний хэмжээнд “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн өрнүүлэхээр “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол (цаашид “УИХ-ын 36 дугаар тогтоол” гэх), 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Цагаан алт” хөдөлгөөн өрнүүлэхээр "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоол (цаашид “УИХ-ын 63 дугаар тогтоол” гэх), мөн Монгол Улсын Засгийн Газар 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоол (цаашид “ЗГ-ын 166 дугаар тогтоол” гэх)-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

УИХ-ын даргын захирамжаар дээр дурдсан хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хяналт тавих, холбогдох арга хэмжээний болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хүрээнд УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг үнэлж, уялдаа холбоо, хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлийг тодорхойлох мөн хөдөө аж ахуйн салбарын хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах талаар олон улсын туршлага судлан санал, дүгнэлт боловсруулах зорилгоор энэхүү тайланг боловсруулсан болно.

Тогтоолуудын хэрэгжилтийн үнэлгээг Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн бөгөөд үнэлгээний үр дүнгээр сонгогдсон нийт 16 арга хэмжээний 3 арга хэмжээ томьёологдсон шалгуур үзүүлжлтийн хүрээнд зорилгодоо хүрсэн, 5 арга хэмжээ зорилгодоо хүрээгүй, 8 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

Мөн олон улсын туршлагыг судлан үзэхэд илүү төвлөрсөн, ил тод, үр дүнтэй хяналтын тогтолцоо бүрдүүлэх нь салбарын хөгжлийг дэмжих гол арга зам болохыг энэ тайлан харуулсан.

НЭГ. ОРШИЛ

1.1. Судалгааны зорилго

Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар чухал байр суурь эзэлдэг бөгөөд тус салбарын нэмэгдэл өртөг нь 2023 оны байдлаар ДНБ-д 9.8 хувийг, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын орлогын 6.4 хувийг тус тус бүрдүүлж, нийт ажиллах хүчний 24.2 хувь нь тус салбарт ажиллаж байна.[1] Энэ салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хүн амын хүнсний хэрэгцээг хангахаас гадна боловсруулах үйлдвэрлэлийн салбарын гол түүхий эд болдог.

Ийм учраас хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр төрөөс их хэмжээний нөөц, хөрөнгө, цаг хугацаа зарцуулан тодорхой үндэсний хөдөлгөөнүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг тогтмол хянаж, үнэлэх нь зарцуулсан нөөц, хөрөнгийн үр ашигтай байдлыг хадгалах, хэрэгжилтийн явцад гарсан хүндрэл бэрхшээлийг цаг тухайд нь илрүүлж, засаж залруулах, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжийг олгох юм.

Мөн аливаа бодлогын арга хэмжээний үр дүнтэй байдалд дан ганц салбарын яам гэхээс илүүтэй төрийн бусад байгууллагууд, хувийн хэвшил, түүний төлөөллүүд зэрэг олон талын оролцоо нөлөөлдөг бөгөөд эдгээр талуудын хоорондын уялдааг хангах, зохицуулах тодорхой механизмүүд, хяналтын тогтолцоог бий болгох, сайжруулах нь чухал юм.

Иймд, УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх замаар уялдаа холбоо, хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлийг тодорхойлох, хөдөө аж ахуйн салбарын хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах талаар олон улсын туршлага судлан санал, дүгнэлт боловсруулах боловсруулахад энэ судалгааны зорилго оршино.

1.2. Тогтоолын товч танилцуулга

УИХ-ын 36 дугаар тогтоолын зорилго нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, газар тариалан, мал аж ахуй, хүнсний боловруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахад оршиж байх бөгөөд нийт 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр 2026 он хүртэл хэрэгжихээр арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Үүний дараа хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг шат ахиулах, тэр дундаа малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байр бий болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор УИХ-ын 63 дугаар тогтоолыг баталж, 682.4 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 2028 он хүртэл хэрэгжихээр арга хэмжээний төлөвлөгөөг баталжээ.

Мөн Засгийн Газрын 166 дугаар тогтоолоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор

[1] Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2023 он, Үндэсний статистикийн хороо

"Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэхээр тогтоож, 5 их наядын арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар боловсруулсан дүгнэлтээр УИХ-ын 36-р тогтоолын биелэлтийн дундаж 61.2 хувь, УИХ-ын 63-р тогтоолын биелэлт 54.6 хувь, ЗГ-ын 166-р тогтоолын биелэлт 91.4 хувьтай байна.

1.3. Тайлан боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 42 дугаар тоот захирамжаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хяналт тавих, холбогдох арга хэмжээний болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.

Мөн “Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб” ТББ-иас боловсруулсан “Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол болон мал аж ахуйн салбарын зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-гээр “УИХ-ын 36 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээг хүрэх түвшинд харьцуулж дүгнэхэд эрх зүйн орчныг сайжруулах нийт 18 арга хэмжээнээс 3 арга хэмжээ нь хүрэх түвшиндээ хүрч, 15 арга хэмжээ хүрэх зорилтод түвшиндээ хүрээгүй” тухай дүгнэж, “УИХ-ын 36 дугаар тогтоолын арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, холбогдох асуудал хариуцсан яамдын хоорондын уялдаа холбоог хангах замаар хугацаа хоцорсон арга хэмжээнүүдийг нөхөж хийж гүйцэтгэх зорилгын хүрээнд Үндэсний хөтөлбөр батлах үүргийг Монгол Улсын Засгийн газарт даалгах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах”-ыг зөвлөсөн байна.

2. УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолууд нь “**мал аж ахуйн үйлдвэрлэл дэмжих, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх”** зорилтын хүрээнд оногдолцож байна. Тухайлбал, УИХ-ын 36 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн е-д заасан “мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх” ажлын хүрээнд “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан бол бол УИХ-ын 63 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн д-д заасан “түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлохыг дэмжих” ажлын хүрээнд “түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал, үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн түүнчлэн, УИХ-ын 36 дугаар тогтоолын 4 дэх хэсгийн е-д заасан “мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг

чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах” ажлын хүрээнд “Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх”, мөн “Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бол УИХ-ын 63 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн а-д “малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;” ажлын хүрээнд “Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх мөн “Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байна.

Эдгээр ажлуудыг давхардуулан тусгаж зарим тохиолдолд арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь тус тус өөр байгаа нь тухайн ажлыг хариуцан гүйцэтгэх байгууллагыг тодорхойгүй болгож, шалгуур үзүүлэлт, суурь түвшин зөрчилдөх ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх зорилго бүхий “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийг баталсан.

Энэхүү хуулиар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тавих зарчмыг сайжруулж, үндэслэл бүхий, судалгаанд суурилсан, харилцан уялдаатай баримт бичиг батлахаар хуульчилсан.

УИХ-ын 36, 63, ЗГ-ын 116 дугаар тогтоолууд нь зорилго, зорилтын хувьд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хамаарч байх боловч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн аль ч төрөлд хамаарахгүй байна.

Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.11 дэх хэсэгт “Бусад хууль тогтоомжид заасан “төрөөс баримтлах бодлого” гэснийг энэ хуулийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд, “үндэсний хөтөлбөр” гэснийг энэ хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно” гэж заасан боловч эдгээр 3 тогтоол нь нэршлийн хувьд “Хөдөлгөөн” хэлбэрээр өрнөж байгаа тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд хамаарна гэж үзэх үндэслэлгүй байна.

Гэсэн хэдий ч эдгээр тогтоолууд нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох "Алсын хараа-2050", Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван

жилийн үндсэн чиглэл” болон Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсын хөгжлийн 2022, 2024 оны төлөвлөгөө”-нд туссан зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нарийвчилсан төлөвлөгөө байдлаар батлагдсан гэж үзэхээр байна.

Жишээлбэл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 8.3 дугаар зорилтод “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8.3 дугаар зорилтод “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 3.3 дугаар зорилгод “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.” гэж тус тус туссан.

Мөн эдгээр тогтоолын хэрэгжилтэд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан зохицуулалтын дагуу ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХХААХҮЯ-наас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Үүнээс үзэхэд, УИХ-ын 36, 63, ЗГ-ын 116 дугаар тогтоолууд нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүйгээс шалтгаалан хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнг үндэслэн холбогдох арга хэмжээ авахтай холбоотой харилцаа зохицуулалтгүй орхигдсон, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан тохиолдолд эрх зүйн үр дагавар үүсэхгүй байх эрсдэлтэй, тодорхойгүй нөхцөл байдалд байна.

ХОЁР. ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. Үнэлгээ хийсэн аргачлал

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан бөгөөд Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү тайлангийн хүрээнд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх 36 болон 63 дугаар тогтоолыг УИХ-аас баталсан бол 166 дугаар тогтоолыг Засгийн газраас баталсан. Өөрөөр хэлбэл, 166 дугаар тогтоол нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжид хамаарахгүй байна. Гэсэн хэдий ч тайлангийн нэгдмэл, цогц, үр дүнтэй байдлыг хангах зорилгоор Иргэний хуулийн “тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх” зарчмын дагуу 166 дугаар тогтоолыг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-йн дагуу үнэлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Иймд, эдгээр тогтоолын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шатын хүрээнд хийж гүйцэтгэв.

2.1.1. Төлөвлөх үе шат

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх үе шатанд 1)үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох, 2)үнэлгээ хийх хүрээг тогтоох, 3)шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох, 4)харьцуулах хэлбэрийг сонгох, 5)шалгуур үзүүлэлтийг томьёолох, 6)мэдээлэл цуглуулах аргыг сонгох гэсэн 6 арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох: Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлийг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлдог.

Дээр дурдсанчлан УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолууд нь “мал аж ахуйн үйлдвэрлэл дэмжих, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд орголцдог бөгөөд тогтоолын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээ нь давхардсан, суурь болон зорилтод түвшин уялдаа холбоогүй, хэрэгжүүлэх байгууллага нь зөрчилдөж тусгагдсан.

Мөн түүнчлэн эдгээр тогтоолуудын зорилго, зорилт нь заршмын хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичиг мөн боловч уг хуулийн үйлчлэх хүрээнд шууд хамаарахгүйгээс улбаалан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үндэслэн холбогдох арга хэмжээ авах эрх зүйн орчин, хяналтын тогтолцоо нь тодорхойгүй байна.

Эдгээр нөхцөл байдал нь “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.3-т “Захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол” гэж заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шалтгаан болж байна.

Үнэлгээ хийх хүрээг тогтоох: Үнэлгээ хийх хүрээг тогтоох арга хэмжээ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгын гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

УИХ-ын 36-р тогтоолын хувьд “Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб” ТББ-аас боловсруулсан судалгаагаар тогтоолын хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн 18 арга хэмжээнд

үнэлгээ хийсэн байх тул энэхүү тайлангаар эдгээр 18 арга хэмжээнд үнэлгээг давхцуулан хийгээгүй болно.

УИХ-ын 63 дугаар тогтоол нь цаг хугацааны хувьд харьцангуй шинэ, 2024 онд батлагдсан тул тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хоёроос дээш жилийн хугацаанд хэрэгжих эсхүл хэрэгжих хугацаа болоогүй байгаа арга хэмжээг сонгон авч үнэлэх нь үндэслэлгүй юм. Иймд салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг хамгийн чухал ач холбогдолтой гол зохицуулалт гэж үзэн энэ хүрээнд 2024 онд хэрэгжүүлж дуусгасан байх зарим арга хэмжээнүүдийг сонгон авав.

Харин ЗГ-ын 166 дугаар тогтоолын хувьд “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа тусгаагүй байна. Иймд тогтоолын үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсхүл төлөвлөгөөнд заасан хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхой хүрэх түвшинтэй, гүйцэтгэх хугацааг илэрхийлсэн арга хэмжээнүүдийг сонгон үнэлэхийг зорив.

Тогтоолуудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдуулан дараах байдлаар тогтоолоо.

Тогтоолын заалт	Үйл ажиллагааны чиглэл	Үнэлэх тогтоолын заалт/ төлөвлөгөөнд туссан арга хэмжээ
УИХ-ын 36 дугаар тогтоол		
1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:	е/мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх;	1.4.1Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх
4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:	е/ мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах	4.6.1Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, **"**Биокомбинат**"** ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх
		4.6.4Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах

		3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.
УИХ-ын 63 дугаар тогтоол		
1/Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр:	а/хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	1.1.1Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
	б/үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	1.1.5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах
		1.1.5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах
		1.1.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах
		1.1.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах
2/Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэлээр:	д/түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлохыг дэмжих	2.4.1 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх
	а/малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;	2.1.1 Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх

		2.2.1Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах
		4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн /, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.
ЗГ-ын 116 дугаар тогтоол		
	1.Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	1.3.Малжуулах хөтөлбөрт хамруулах
		1.4.Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх
		Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.

Иймд тогтоолын заалтаар даалгасан 3, тогтоолын хавсралтаар батлагдсан төлөвлөгөөнд туссан 13, нийт 16 арга хэмжээг үнэлэхээр сонгов.

Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох: Тогтоолын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан 1) Зорилгод хүрсэн түвшин, 2) Зардлын өсөл-бууралт, 3) Зардал-үр өгөөжийн харьцаа, 4) Хүлээн зөвшөөрөгдсөн байдал, 5) практикт нийцэж байгаа байдал, 6) Бусад үр дагавар гэсэн шалгуур үзүүлэлтээс сонгож тогтоодог.

Шалгуур үзүүлэлт нь үнэлгээ хийх болсон шалтгаантай уялдсан байх бөгөөд оновчтой, бодит, хэмжиж болохуйц байх шаардлагтай тул дараах шалгуур үзүүлэлтийг сонгов.

- Зорилгод хүрсэн байдал
- Практикт нийцэж байгаа байдал
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Үнэлэх тогтоолын заалт/төлөвлөгөөнд туссан арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт
УИХ-ын 36 дугаар тогтоол	
1.4.1Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх	Зорилгод хүрсэн байдал
4.6.1Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, **"**Биокомбинат**"** ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал

4.6.4Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах	Зорилгод хүрсэн байдал
3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал
УИХ-ын 63 дугаар тогтоол	
1.1.1Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Зорилгод хүрсэн байдал
1.1.5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
1.1.5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
1.1.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
1.1.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Зорилгод хүрсэн байдал
2.4.1 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх	Зорилгод хүрсэн байдал
2.1.1 Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал
2.2.1Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах	Зорилгод хүрсэн байдал
4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн /, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал
ЗГ-ын 116 дугаар тогтоол	
1.3.Малжуулах хөтөлбөрт хамруулах	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
1.4.Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх	Зорилгод хүрсэн байдал
10.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.	Зорилгод хүрсэн байдал

Харьцуулах хэлбэрийг сонгох: Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгох шаардлагатай тул “байх ёстой болон одоо байгаа”, “хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж

батлагдсанаас хойш” болон “хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” гэсэн 3 хэлбэрийг тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохируулж сонгов.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох: “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу шалгуур үзүүлэлтийг томьёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавихыг хэлдэг. Иймд 3 тогтоолын бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг томьёолов.

Мэдээлэл цуглуулах аргыг сонгох: Тогтоолын хэрэгжилтийн үнэлгээ хийхдээ түүний хэрэгжилтийн талаар хийсэн бусад судалгааны тайлан, хэрэгжүүлэгч байгууллага, ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан, холбогдох статистик, тоон мэдээлэл зэрэг бэлэн байгаа мэдээллийг цуглуулах замаар дүн шинжилгээ хийв.

2.1.2. Хэрэгжүүлэх үе шат

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Мэдээлэл цуглуулахдаа ямар мэдээлэл, судалгааг хэнээс, хэрхэн, ямар аргаар, хэзээ авахаа оновчтой тодорхойлох шаардлагатай тул мэдээллийг албан ёсны эх сурвалжууд, захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудаснаас зонхилон цуглуулав. Дараах мэдээллийг ашиглан энэхүү тайланг боловсруулав.

- https://lawforum.parliament.mn/, https://d.parliament.mn/ цахим сангуудад байршсан хууль тогтоомжийн төсөл, дагалдан боловсруулсан судалгаанууд,
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” https://legalinfo.mn/mn/detail/15584
- УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311
- УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759684400981
- ЗГ-аас 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр өргөн барьсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан” болон “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан” https://d.parliament.mn/tusul/b9631f9b-c2cf-46b4-af62-3108224f146c
- “Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб” ТББ-аас боловсруулсан “Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол болон мал аж ахуйн салбарын зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” 2024 он
- Сангийн яамнаас 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр нийтэлсэн “Засгийн газраас татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох багц хуулийн төсөл” https://mof.gov.mn/article/entry/tatvar

- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч газраас 2025 оны 4 дүгээр сарын ...-ны өдөр ирүүлсэн УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;
- ХХААХҮЯ-наас боловсруулсан 2022 оны жилийн эцсийн, 2023 оны хагас жилийн, 2024 оны хагас жилийн байдлаарх “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”, https://mofa.gov.mn/activity/assessment
- ХХААХҮЯ-наас боловсруулсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний тайлан” https://mofa.gov.mn/activity/assessment
- ХХААХҮЯ-наас боловсруулсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө”-ний 2021-2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай” https://mofa.gov.mn/activity/assessment
- “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, “Байгаль орчин болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө”, 2024 он https://lcp.mn/page/detail/9
- Бусад эх сурвалжууд.

2.1.3. Үнэлэх үе шат

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу үнэлэх үе шатанд үнэлгээний ажлыг эцэслэн, үр дүнг нэгтгэн дүгнэж зөвлөмж боловсруулах бөгөөд 1. цуглуулсан мэдээллийг үнэлэх болон 2.тогтоосон шалгуур үзүүлэлт болон харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлэх гэсэн дарааллыг баримтлан ажиллав.

УИХ-ын 36 дугаар тогтоол

1)Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх.

Үнэлэгдэх хэсэг	1.4.1Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Журмыг батлуулж, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлсэн эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Тийм

УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд ХХААХҮЯ-наас Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн

тогтоох бүртгэлтэй холбоотой журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлсэн байхаар заасан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/196 дугаар тушаалаар "Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"[2] -ыг баталсан байна. Харин мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам https://legalinfo.mn/ эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийтлэгдээгүй байна.

ХХААХҮ-наас өөрийн цахим хуудаснаа "Мал, амьтны болон ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын төсөлд 2024 оны 11 дүгээр сарын 18-наас 12 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд санал авсан байна.[3] Энэхүү журмын төсөл батлагдсан эсэх талаар мэдээлэл байхгүй байх бөгөөд https://legalinfo.mn/ эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийтлэгдээгүй байна.

Харин ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд "Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг малчны хотноос эхлээд эцсийн хэрэглэгчийн гар дээр тавих хүртэл алхам бүрд хийгдсэн үйл ажиллагааг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн бэлчээрийн төлөв байдал, малын тавлаг байдал, эрүүл мэнд, малын гаралтай түүхий эдийн чанар зэрэг үзүүлэлтүүдийг харуулсан, малчдаас авах түүхий эдийн тогтвортой, хариуцлагатай байдлыг стандартчилснаар малчид, БАХ-үүд бэлчээрийн тогтвортой байдал, бэлчээрийн менежментийн дадлуудыг нэвтрүүлж, хамгийн сайн чанарын малын гаралтай түүхий эдийг (сарлагийн хөөвөр, торомны ноос, ноолуур, арьс, шир, мах) бий болгож, улмаар эдийн засгийн урамшуулал хүртдэг "Хариуцлагатай малчин"-г бий болгох "Хариуцлагатай нүүдэлчид" системийг нэвтрүүлсэн." гэжээ.
Дээрх хэрэгжилтийн тайлан нь ХХААХҮЯ-наас боловсруулсан 2024 оны хагас жилийн "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан"[4]-д мөн туссан байна.

Иймд, журмыг батлуулж, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлсэн байх тул дээрх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжсэн гэж дүгнэж байна.

2)Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, "Биокомбинат" ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх.

Үнэлэгдэх хэсэг	4.6.1Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, **"**Биокомбинат**"** ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал

[2] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530810646881&showType=1
[3] https://mofa.gov.mn/law/tosol
[4] https://mofa.gov.mn/files/pdf-files/28wayibx3vx/67ca56e96ddbd02d08d9b872.pdf

Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэлийн 100 хувь дотоодоос хангадаг болсон эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал
	Үнэлэх боломжгүй	Тийм

УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, **"**Биокомбинат**"** ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь “Био бэлдмэлийн дотоодын үйлдвэрлэлийн хангамж, хувь”, суурь түвшин нь “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэлийн 85 хувийг дотоодоос хангаж байна.” хүрэх түвшин нь “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэлийн 100 хувь дотоодоос хангадаг болсон” байхаар заасан. Мөн тус арга хэмжээг ХХААХҮЯ болон СЯ 2022-2027 оны хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээгээр зөвхөн тогтоолоор даалгасан арга хэмжээний биелэлтийн үнэлгээг хийсэн байх бөгөөд тогтоолын хавсралтаар батлагдсан тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн талаар мэдээлэл байхгүй байна.

Түүнчлэн, ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан[5] 2022 оны жилийн эцсийн, 2023 оны хагас жилийн (2023 оны жилийн эцсийн байдлаар боловсруулсан тайланд хэрэгжилтийн мэдээлэл ороогүй), 2024 оны хагас жилийн байдлаар (2023 оны жилийн эцсийн байдлаар боловсруулсан тайланд хэрэгжилтийн мэдээлэл ороогүй) “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д мөн адил зөвхөн тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар мэдээллийг оруулсан байна.

Үнэлэгдэх хэсэгт заасан арга хэмжээний тогтоолоор даалгасан үйл ажиллагааны чиглэл нь тогтоолын 4 дэх хэсгийн е болох “мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах.” арга хэмжээ юм.

Энэхүү тогтоолоор заасан арга хэмжээний биелэлтийг ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын тайланд “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах ажлын хүрээнд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин 11,6 тэрбум төгрөгөөр 10.5 сая тун, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакциныг 2.8 тэрбум төгрөгөөр 18.2 сая тун, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакциныг 2.4 тэрбум төгрөгөөр 2.2 сая тун, хонины цэцэг

[5] https://mofa.gov.mn/activity/assessment

өвчнөөс сэргийлэх вакциныг дотоодоос 1.3 тэрбум төгрөгөөр 9.5 сая тун тус тус худалдан авалтыг хийж вакцины нөөцийг бүрдүүлсэн. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар нийт 17.441.488 толгой мал хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар 23.209.600 толгой мал хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтанд 4.280.800 толгой мал, намрын нэгдсэн дархлаажуулалт 2.6 сая толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг Дорнод аймгийн эрсдэл бүхий Чулуун хороот, Халх гол сумдын нутаг дэвсгэрт байгаа мэдрэмтгий үхэр сүрэгт 34,650 тун вакцин хуваарилан дархлаажуулсан. Вакцины хөргүүр буюу хүйтэн хэлхээний хувьд 331 сум, 9 дүүргийн МЭТ-т шилэн хаалгатай хөргүүр 88ш, 21 аймгийн Мал эмнэлгийн газарт тус бүрт нэг нэг хөргүүр, 1027 ААН-д зөөврийн хөргүүр 298ш байна. Цаашид зөөврийн хөргүүр 700ш, шилэн хаалгатай хөргүүр 252 шаардлагатай байна. Булган (2) Говь-Алтай (2) Дорноговь (1), Дорнод (1), Дундговь (2)8 Сүхбаатар (1) Увс (2), Өмнөговь (1)8 Улаанбаатар (1) Нийт 9 аймаг, нийслэлийн 13 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 1.1 тэрбум төгрөгийн зээл авсан байна.” гэж тайлагнаж, 100 хувиар үнэлсэн байна.

Өөрөөр хэлбэл, үнэлэгдэх хэсгийн шалгуур үзүүлэлт болох “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэлийн 100 хувь дотоодоос хангадаг болсон байх” хүрэх түвшний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл тусгаагүй байсан тул энэ талаар мэдээллийг хайж үзэхэд:

1. ХХААХҮЯ-наас боловсруулсан 2022 оны “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д “Шүлхийгээс сэргийлэх вакцины технологийг лицензийн гэрээгээр “Биокомбинат” ТӨХХК-д шилжүүлснээр 50 мянган тун вакцин үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Өнөөдрийн байдлаар 50 мянган тун вакцин үйлдвэрлэх түүхий эд бэлэн байна”
2. ХХААХҮЯ-наас боловсруулсан 2023 оны хагас жилийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д “Биокомбинат ТӨХХК-д шүлхий өвчнөөс сэргийлэх 25,0 мянган тун вакциныг савлан 06-р сард хийгдэж үйлдвэрийн дотоод хяналт болон МЭЭСБУЛ-аар шалгах ажил хийгдэж байна.” мөн “Хонины цэцгээс сэргийлэх 5,0 сая тун вакцин Биокомбинатаас худалдан авах гэрээг байгуулж үйлдвэрлэлийн ажил хийгдэж байна.”
3. ХХААХҮЯ-наас боловсруулсан 2023 оны хагас жилийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д “Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин Биокомбинат ТӨХХК-д үйлдвэрлэл эхэлсэн.”
4. ХХААХҮЯ-наас боловсруулсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний тайлан”-д “Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Унгар улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байсан,төлөвлөгөөний

3.3.8.1-д заасан "Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологиийг шинэчлэх" төслийг Ковид- 19 цар тахлын нөлөө, хууль, эрхзүйн өөрчлөлт, тээвэр логистикийн хүндрэл, үнийн өсөлт, хилийн хориг зэргээс шалтгаалж, цаашид төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзэж БНУУ-ын ЗГ-ын саналаар гэрээг цуцалсан."

5. ХХААХҮЯ-наас боловсруулсан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө"-ний 2021-2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай" тайланд "Дэлхийн банкны LCP болон GCAP төслүүдэд шугаман эсийн технологи нэвтрүүлэх, вирусийн гаралтай вакцины шинэ үйлдвэрийн төслийн танилцуулгыг хүргүүлсэн."

6. "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, Шугаман эсийн технологи нэвтрүүлэх төслийн 2024 оны 06 дугаар сард гаргасан "Байгал орчин болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө[6]"-нд "Сүүлийн жилүүдэд хонины цэцэг, бог малын мялзан өвчин, шүлхий зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг гадаадаас импортоор оруулж ирж, бусад бүх вакциныг "Биокомбинат" ТӨХХК дотоод хэрэгцээнд зориулан үйлдвэрлэж байна. Одоогоор тус компани нь мал эмнэлгийн зориулалттай 44 төрлийн вакцин үйлдвэрлэж байгаа бөгөөд үүнд 120,000-140,000 литр шингэн, 40.0-45.0 сая тун хуурай вакцины бүтээгдэхүүн, оношилгооны хамт багтаж байна."

7. ХХААХҮЯ-ны цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр нийтэлсэн "Вакцин үйлдвэрлэлийн Шугаман эсийн технологийн шинэ лабораторитой боллоо"[7] нийтлэлд "Монгол Улсын Их Хурлын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дэлхийн банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх (LCP) төсөл, Биокомбинат ТӨХХК хамтран Шугаман эсийн технологи нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн", "Монгол Улс гадаад улсаас өндөр үнээр импортолдог бог малын мялзан болон үхрийн арьс товруутах зэрэг малын гаралтай өвчлөлийн вакциныг дотооддоо үйлдвэрлэх боломж бүрдэж, оношилгооны лаборатори бүрэн чадавхжаад байна." мөн "Биокомбинат ТӨХХК-ийн Үйлдвэрлэл, технологийн албаны дарга Б.Дуламсүрэн лабораторийн онцлог давуу тал, ажиллах орчин нөхцөл сайжирсан талаар ярьж, орчин үеийн дэвшилтэд технологитой болсноор вакцины дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, малын гаралтай өвчний оношилгоог цаг алдалгүй тодорхойлох боломжтой болсон гэсэн юм."

Үүнээс үзэхэд **"**Биокомбинат**"** ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх" замаар "Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх био бэлдмэлийн 100 хувь дотоодоос хангах" зорилт нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжилт удааширсан байсан ч хэрэгжүүлэгч байгууллагуудаас тодорхой арга хэмжээг авч, үр дүн үзүүлж байх тул практикт нийцтэй байна гэж үзлээ.

Харин Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн

[6] https://lcp.mn/page/detail/9

[7] [3] https://mofa.gov.mn/news/TIME/6762b9bb45076e7ad179bc31

хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХАА салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ХХААХҮЯ-наас өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа үнэлэгдэх хэсгийн хэрэгжилтийн мэдээллийг тусгаагүй, батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүрсэн түвшинг тодорхойлохтой холбоотой мэдээлэл байхгүй байх тул үнэлэх боломжгүй байна.

3)Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах.

Үнэлэгдэх хэсэг	4.6.4.Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Баруун бүс, Хангайн бүс, Зүүн бүс тус бүрд лаборатори байгуулсан эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Тийм

УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах” арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь “өргөтгөсөн лабораторийн тоо”, суурь түвшин нь “0.” хүрэх түвшин нь “Баруун бүс, Хангайн бүс, Зүүн бүс тус бүрд лаборатори байгуулсан” байхаар заасан. Мөн тус арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, болон Олон Улсын байгууллага 2022-2024 оны хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

ХХААХҮЯ-наас боловсруулсан 2022 оны “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д “УМЭАЦТЛ-ийн Биоаюлгүйн 3-р зэрэглэлийн лаборатори, Хэнтий, Ховд Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн лабораторийг засварлах ажлыг МААЭЗЭН төслийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхлээд байна.” мөн “Мал эмнэлгийн лабораторийн засвар, шинэчлэлийн зардлыг МААЭЗЭН төслийн төлөвлөгөөнд тусгасан.” гэж тайлагнасан бол 2023 оны хагас жилийн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-д “Ховд, Хэнтий, Өвөрхангай аймгийн мал эмнэлгийн лаборатори болон УМЭАЦТЛ-ийн барилга, дэд бүтцийг сайжруулах, оношилгоонд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх зэрэг 4,3 тэрбум төгрөгийн санхүүжилттэй ажлууд хийгдэж байна.” гэжээ.

Мөн түүнчлэн, ХХААХҮЯ-наас боловсруулсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай” тайланд “Өвөрхангай аймаг: МААЭЗЭН төслөөс 340,000,000₮ санхүүжилт нь шийдэгдэж: зураг төсвийн ажил барилга хөгжлийн төвөөс батлагдаж бүрэн засвар хийгдэж дууссан.” гэж тусгажээ.
2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд ХХААХҮЯ-ны ТНБД Т.Жамбалцэрэн “мал эмнэлгийн оношилгооны чадавхыг сайжруулах чиглэлээр 3 аймгийн бүсийн оношилгооны лабораторийг чадавхжуулсан.” гэх мэдээллийг өгсөн байна.

Иймд, томьёологдсон шалгуур үзүүлэлтийн хүрээнд зорилгод хүрсэн гэж дүгнэхээр байна.

4)Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо-нд тус тус даалгасугай.

<table>
<tr><td>Үнэлэгдэх хэсэг</td><td colspan="2">3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td colspan="2">Зорилгод хүрсэн байдал
Практикт нийцэж байгаа байдал</td></tr>
<tr><td>Харьцуулах хэлбэр</td><td colspan="2">Байх ёстой болон одоо байгаа</td></tr>
<tr><td>Томьёологдсон шалгуур үзүүлэлт</td><td colspan="2">Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх</td></tr>
<tr><td rowspan="2">Үнэлгээ</td><td>Зорилгод хүрсэн байдал</td><td>Практикт нийцэж байгаа байдал</td></tr>
<tr><td>Үнэлэх боломжгүй</td><td>Үгүй</td></tr>
</table>

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “УИХ-ын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан арга хэмжээг Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, Улсын төсөвт тусган батлуулсан.” гэж тайлагнасныг 30 хувиар үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл, үнэлэгдэх хэсгийн томьёологдсон шалгуур үзүүлэлт болох Байгнын хороод “Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх”-тэй холбоотой мэдээлэл тусгаагүй байна.

УИХ-ын 36 дугаар тогтоолоор үнэлэгдэх хэсгийн суурь түвшин, хүрэх түвшний талаар тодорхойлоогүй тул зорилгод хүрсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх боломжгүй байна.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.1 дэх хэсэгт “Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.” гэж заасан тул УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсанаас хойших хугацааны байнгын хороодын хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг https://www.parliament.mn/ цахим хуудаснаас шүүн үзэв.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсанаас хойш 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хүртэл нийт 57 удаа хуралдсан бол үүнээс 2022 оны 08 дугаар сарын 24-ны өдөр, 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр болон 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрүүдэд тус тус нийт 3 удаа тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонссон байна. Бусад байнгын хороод болох Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийг тус тус шүүн үзэхэд УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудлаар нэг ч хуралдаагүй байна.

Харин, УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллагуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, уулзалтаар тогтоолын хэрэгжилт, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар хийсэн ажлын үр дүн зэрэг асуудлуудыг хэлэлцдэг байна.

Иймд, үнэлэгдэх хэсгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг 4 байнгын хороонд даалгаснаас эрхлэх асуудлын хүрээнд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо нийт 3 удаа хэрэгжилтийн мэдээллийг сонсож хэлэлцсэн, бусад байнгын хороо нэг ч хэлэлцээгүй, хамтарсан байнгын хорооны хурлаар мөн адил хэлэлцээгүй тул шалгуур үзүүлэлтийн хүрээнд практикт нийцэхгүй байна гэж үзэж байна.

УИХ-ын 63 дугаар тогтоол

1)Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Үнэлэгдэх хэсэг	1.1.1.Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамнаас тус хуулийн төслийг боловсруулсан эсэх болон Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Үгүй

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дараах 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан.

1. Салбарын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр
2. Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэлээр
3. Үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр
4. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр.

Дээрх төлөвлөгөөнд тусгагдсанаар Монгол Улсад хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй тул 2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байхаар заажээ.
ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “Үзэл баримтлалыг ХХААХҮ-ийн сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2021 онд хамтран баталсан байна. Харин Засгийн газрын бүтэц шинээр эмхлэн байгуулагдсантай холбоотойгоор тандан судалгаа, үзэл баримтлалыг шинэчлэн дахин батлуулахаар ажиллаж байна. 2025 онд хуулийн төслийн өргөн барихаар төлөвлөсөн байна.” гэж тусгасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хуралд өргөн баригдсан хуулийн төслийг нээлттэй байршуулдаг албан ёсны цахим сан болох https://lawforum.parliament.mn/, https://d.parliament.mn/ болон хууль тогтоомжийн нэгдсэн цахим сан болох https://legalinfo.mn/mn/ зэрэг цахим санд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дээрх хуулийн төсөл, дагалдах баримт бичгүүд нийтлэгдээгүй байна.

Иймд, Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байх тул дээрх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжээгүй буюу хангалтгүй гэж дүгнэж байна.

2)Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах.

Үнэлэгдэх хэсэг	1.1.5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Сангийн яам, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамнаас тус хуулийн төслийг боловсруулсан эсэх болон 2024 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
	Үгүй	Үгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам боловсруулж, 2024 онд УИХ-д өргөн мэдүүлсэн байхаар заасан.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Мөн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан эсэх талаар тайланд тусгагдаагүй байна.” гэж тусгасан байна.

Сангийн яамнаас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д заасны дагуу Засгийн газраас татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох багц хуулийн төслийг боловсруулан цахим хуудаснаа нийтэлсэн байна.[8]

Багц хуулинд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл багтсан байх бөгөөд уг хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд хуулийн төслийг бага дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтлах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжих, бүс, орон нутаг, хүн ам, ажиллах хүч татах татварын ялгаатай бодлогыг бие даан хэрэгжүүлэх, татварын тайланг цахимаар урьдчилан боловсруулж, татвар төлөгчийн төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр боловсруулсан байна.

Түүнчлэн https://lawforum.parliament.mn/, https://d.parliament.mn/ болон https://legalinfo.mn/mn/ зэрэг цахим санд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дээрх хуулийн төсөл, дагалдах баримт бичгүүд нийтлэгдээгүй байна.

Иймд, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн

[8] https://mof.gov.mn/article/entry/tatvar

мэдүүлээгүй байх тул дээрх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжээгүй буюу хангалтгүй гэж дүгнэж байна.

3)Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах

Үнэлэгдэх хэсэг	1.1.5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Сангийн яам, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамнаас тус хуулийн төслийг боловсруулсан эсэх болон 2024 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
	Үгүй	Үгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам боловсруулж, 2024 онд УИХ-д өргөн мэдүүлсэн байхаар заасан.

Дээр дурдсанчлан ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Мөн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан эсэх талаар тайланд тусгагдаагүй байна.” гэж тусгасан байна.
Сангийн яамнаас боловсруулан нийтэлсэн багц хуулинд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл багтсан бөгөөд уг хуулийн төслийг бүс, орон нутагт ажиллах хүч, хөрөнгө оруулалт татах татварын ялгаатай бодлогыг бие даан хэрэгжүүлэх, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын татварын орчинг илүү таатай болгох чиглэлээр боловсруулсан байна.

Харин 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд “албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар." хөнгөлөх агуулга бүхий 22.5.22 дэх заалтыг нэмжээ. Гэвч энэхүү нэмэлтийг үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор нэмсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Түүнчлэн https://lawforum.parliament.mn/, https://d.parliament.mn/ болон https://legalinfo.mn/mn/ зэрэг цахим санд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дээрх хуулийн төсөл, дагалдах баримт бичгүүд нийтлэгдээгүй байна.

Иймд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байх тул дээрх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжээгүй буюу хангалтгүй гэж дүгнэж байна.

4)Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах

Үнэлэгдэх хэсэг	1.1.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Сангийн яам, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамнаас тус хуулийн төслийг боловсруулсан эсэх болон 2024 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
	Үгүй	Үгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам боловсруулж, 2024 онд УИХ-д өргөн мэдүүлсэн байхаар заасан.

Дээр дурдсанчлан ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Мөн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан эсэх талаар тайланд тусгагдаагүй байна.” гэж тусгасан.

Сангийн яамнаас боловсруулан нийтэлсэн багц хуулинд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл багтсан бөгөөд хуулийн төслийг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, тулгарч буй асуудлыг нэр мөр шийдэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох мөн татвар төлөгчдөөс ирүүлсэн нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулжээ.

Мөн https://d.parliament.mn/ цахим хуудасны боловсруулж буй төслүүд хэсэгт “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр нийтлэгдсэн байх бөгөөд хуулийн төслийг зөвхөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11

дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн“… 10 хувиар” гэснийг “ 5 хувиар” гэж өөрчлөх агуулгаар боловсруулсан байна.[9]
Түүнчлэн https://lawforum.parliament.mn/, https://d.parliament.mn/ цахим хуудсанд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дээрх хуулийн төсөл, дагалдах баримт бичгүүд өргөн мэдүүлсэн төслүүд хэсэгт эсхүл батлагдаж https://legalinfo.mn/mn/ цахим санд нийтлэгдээгүй байна.

Иймд, Нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байх тул дээрх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжээгүй буюу хангалтгүй гэж дүгнэж байна.

5) Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах

Үнэлэгдэх хэсэг	1.1.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Сангийн яам, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамнаас тус хуулийн төслийг боловсруулсан эсэх болон 2024 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Үнэлэх боломжгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам боловсруулж, 2024 онд УИХ-д өргөн мэдүүлсэн байхаар заасан.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “Заалтын хүрээнд 2024 онд Монгол Улсын гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 40.8-д Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг тухайн бүсэд хамаарах аймгийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн хамтарсан саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болно." гэж, 38.1.24 дэх заалтад “оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал." заалт нэмсэн байна. Гэвч үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.” гэжээ.

[9] https://d.parliament.mn/tusul/d3e2fdab-c8af-42a8-9995-935235aa11db

Мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.8 дахь хэсэг нь 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар нэмэгдсэн байх бөгөөд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дагалдах хуулийн төсөл байдлаар батлагдсан байна.[10]

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.24 дэх заалтын хувьд мөн адил 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нэмэгдсэн байна.[11] Мөн уг хуулийн төслийн үзэл баримтлалд[12] хуулийн төслийг боловруулах болсон хууль зүйн үндэслэл гээд “Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн 2 дугаар хавсралт, мөн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 3.3.8 Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.” (арьс ширний анхан шатны тордолтын цех, арьс ширэн жижиг эдлэлийн цех, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх, яс боловсруулах цех, сүлжмэлийн цех, эсгий, эсгий эдлэлийн цех, оёдлын цех, мод, модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох болон бусад) гэж, 3.3.10-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ” гэж 4.2.23-д “Мал, амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж заасныг тус тус ишлэжээ.

Үүнээс үзэхэд дээрх Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлтээр орсон заалтууд нь УИХ-ын 63 дугаар тогтоол батлагдсан өдөр буюу 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан байх бөгөөд, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсрүүлах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгын хүрээнд нэмэлтээр орсон гэж үзэх үндэслэлгүй байх тул УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтэд оруулан тооцох боломжгүй байна.

Харин 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төсөл батлагдаж, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд “Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайны импортын барааны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлнө.” агуулга бүхий 38.4 дэх хэсгийг нэмжээ. Энэхүү хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох баримт бичиг https://lawforum.parliament.mn/mn, https://d.parliament.mn/ цахим хуудсанд нийтлэгдээгүй байх тул шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх боломжгүй байна.

6) Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх.

[10] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141124554051&showType=1
[11] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141096067951&showType=1
[12] https://lawforum.parliament.mn/project/565/

Үнэлэгдэх хэсэг	2.4.1 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болсон эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Үнэлэх боломжгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Мал аж ахуйн болон мал эмнэлгийн нэгдсэн систем, “Хариуцлагатай нүүдэлчин цахим систем хөгжүүлсэн. Махны гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож байгаа талаар дурдаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2024-2028 оны хугацаанд “Малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгосон байх” түвшинд хүрэхээр заасан.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХХААХҮЯ-наас боловсруулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд зөвхөн тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгаж, хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний талаар мэдээлэл оруулаагүй болно.

Иймд энэхүү үнэлэгдэх хэсгийг шалгуур үзүүлэлийн хүрээнд үнэлэх боломжгүй байна.

7) Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх

Үнэлэгдэх хэсэг	2.1.1 Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх	
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Вакцины хангамжийн хувийг нэмэгдүүлэх хүрээнд арга хэмжээ авсан эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал
	Үнэлэх боломжгүй	Тийм

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн, шинэчлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь Вакцины хангамжийн хувь, 2023 оны суурь түвшин 80 хувь, хүрэх түвшин 100 хувь (Импортоор авч байгаа 7.5 сая ам.долларын вакциныг дотооддоо үйлдвэрлэнэ.) байхаар заажээ. Мөн энэхүү арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газар болон Биокомбинат ТӨХХК нар 2024-2027 оны хооронд хэрэгжүүлэхээр тусгасан.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХХААХҮЯ-наас боловсруулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд зөвхөн тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгаж, хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний талаар мэдээлэл оруулаагүй болно.

Харин ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “Био бэлдмэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх ажлын хүрээнд хонины цэцгийн вакциныг шугаман эсийн технологит шилжүүлж, дараагийн шатны эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэх ажил хийгдэж байна. Түүнчлэн 135-160 шингэн вакцины гар савлагааг бүрэн автоматжуулах ажлыг хийж дууссан байна. Вирус судлалын лабораторид мал аж ахуй эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, шугаман эсийн технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлж байна. "хэрэгжих шатанд"-зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа” гэж тусгасан.

Дээр дурдсанчлан, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХАА салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ХХААХҮЯ-наас өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа үнэлэгдэх хэсгийн хэрэгжилтийн мэдээллийг тусгаагүй, батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүрсэн түвшинг тодорхойлохтой холбоотой мэдээлэл байхгүй байх тул үнэлэх боломжгүй байна.

8) Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах

Үнэлэгдэх хэсэг	2.2.1Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээний арга нэвтрүүлэлтийн тоог нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авсан эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Үнэлэх боломжгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах” арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээний арга нэвтрүүлэлтийн тоо, 2023 оны суурь түвшин 3 бол хүрэх түвшин 8 байхаар заажээ. Мөн энэхүү арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газар болон аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрууд 2024-2028 оны хооронд хэрэгжүүлэхээр тусгасан.

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд “УМЭАЦТЛ-той хамтран 8 чиглэлийн ажлын байрны сургалт зохион байгуулж, 120 лабораторийн эмчийг хамруулж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн байна. НҮБ-ын МААЭЗЭН төслийн санхүүжилтээр МЭЭСБУЛ-д 28 нэрийн 66 ширхэг 318,0 сая төгрөг, НМЭГ-ын лабораторийн хүнсний аюулгүй байдлын шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 227,0 орчим сая төгрөгийн багаж, төхөөрөмж тус тус нийлүүлсэн байна. УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад 2024 онд мал эмнэлгийн лабораториудын оношилгооны бэлэн байдлыг хангах зорилгоор 4 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж, нийт 2,031,640,000 төгрөгийн төсөв бүхий лабораторийн оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна. Улсын хэмжээнд мал эмнэлгийн нийт 25 лабораториос 10 лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандартын лабораторийн итгэмжлэлд шинээр хамрагдсан байна. Мөн

МЭЭСБУЛ-ийн MNS ISO/IEC 17065:2013 стандартын итгэмжлэлийн гэрчилгээг 4 жилийн хугацаатай сунгасан бөгөөд итгэмжлэлд улсын төсвөөс 50, 0 сая төгрөг зарцуулсан байна. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан" гэж үнэлсэн.

Гэвч, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХХААХҮЯ-наас өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа үнэлэгдэх хэсгийн хэрэгжилтийн мэдээллийг тусгаагүй, батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүрсэн түвшинг тодорхойлохтой холбоотой мэдээлэл байхгүй байх тул үнэлэх боломжгүй байна.

9) Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо-нд тус тус даалгасугай.

Үнэлэгдэх хэсэг	4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн /, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.	
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа	
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажилласан эсэх	
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал
	Үгүй	Үгүй

УИХ-ын 63 дугаар тогтоолоор үнэлэгдэх хэсгийн суурь түвшин, хүрэх түвшний талаар тодорхойлоогүй тул зорилгод хүрсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх боломжгүй юм. Гэвч ИХ-ын 63 дугаар тогтоол батлагдсанаас хойших хугацааны байнгын хороодын хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг https://www.parliament.mn/ цахим хуудаснаас шүүн үзэхэд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хүртэл хугацаанд УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудлаар нэг ч хуралдаагүй байх тул хэрэгжээгүй гэж үзлээ.

Мөн үнэлэгдэх хэсгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг 4 байнгын хороонд даалгаснаас хэрэгжилтийн талаар нэг ч хэлэлцээгүй, хамтарсан байнгын хорооны хурлаар мөн адил хэлэлцээгүй тул шалгуур үзүүлэлтийн хүрээнд практикт нийцэхгүй байна гэж үзэж байна.

ЗГ-ын 166 дугаар тогтоол

1)Малжуулах хөтөлбөрт хамруулах

Үнэлэгдэх хэсэг	1.3.Малжуулах хөтөлбөрт хамруулах
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн түвшин Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Малжуулах хөтөлбөрт хамруулсан эсэх

Үнэлгээ	Зорилгод хүрсэн түвшин	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
	Үнэлэх боломжгүй	Үнэлэх боломжгүй

ЗГ-ын 166 дугаар тогтоолын хавсралтаар “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд уг төлөвлөгөөнд төлөвлөгөөний үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, ажлыг хариуцах байгууллага болон хамтран ажиллах байгууллага зэргийг тусгасан боловч хэрэгжүүлэх хугацааг заагаагүй байна.

Мөн ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар болон ХХААХҮЯ-наас боловсруулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд зөвхөн тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгаж, хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээний талаар мэдээлэл оруулаагүй тул үнэлэх боломжгүй байна.

2)Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх

Үнэлэгдэх хэсэг	1.4.Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлсэн эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Тийм

“Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд “Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийн хэмжээ бөгөөд суурь түвшин 59,000.0 бол хүрэх түвшин 100,000.0 байхаар заасан байна. Ажлыг хариуцах байгууллага нь ХХААХҮЯ, СЯ бол МБ, ЗБДС хамтран ажиллах байгууллагаар орсон байна.
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналтшинжилгээ, үнэлгээ хийсэн тайланд “Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын 2024 оны 5-р сарын 7-ны өдрийн А/88 тоот тушаалын дагуу Төрийн санд байршиж буй Сангийн өөрийн хөрөнгийг Арилжааны банканд байршуулах шийдвэр гарсан. Уг шийдвэрийн хүрээнд Сан өөрийн хөрөнгийг арилжааны банканд байршуулан хүүгийн орлогоор нөөц сан бүрдүүлэн ажиллав”[13] гэж тайлагнасан.

Үнэлэгдэх хэсэгт хугацаа заагаагүй тул хүрэх түвшинд хүрсэн эсэх талаар үнэлэхээс татгалзав. Харин Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлсэн гэж үзэн томьёолсон шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжсэн гэж үзлээ.

3)Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй,

[13] https://mofa.gov.mn/files/pdf-files/28wayibx3vx/67ca56e96ddbd02d08d9b872.pdf

хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.

Үнэлэгдэх хэсэг	10.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрсэн байдал
Харьцуулах хэлбэр	Байх ёстой болон одоо байгаа
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан эсэх
Үнэлгээ	Зорилгод хүрсэн байдал
	Үнэлэх боломжгүй

ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас боловсруулсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд “Тухайн заалтаар өгсөн үүргийн дагуу дүнг хагас жил тутам танилцуулсан эсэх талаар тайлагнах. Заалтын хэрэгжилт 70 хувь буюу хэрэгжих шатанд байна.” гэж үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан эсэх мэдээлэл байхгүй байх тул үнэлэх боломжгүй байна.

ГУРАВ. ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1. Монгол Улсын хөдөө, аж ахуйн салбарын хяналтын тогтолцооны талаар

Монгол Улсад хөдөө аж ахуй, хүнсний хангамж, аюулгүй байдлын хяналтын тогтолцоо нь олон төрлийн хууль тогтоомж, тэдгээрийн зохицуулалтын хүрээнд өөр өөрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг **олон байгууллагуудын хамтын ажиллагааны цогц системээс** бүрддэг. Уг салбарын хяналтын тогтолцооны үндсэн чиглэлүүдийг дараах үндсэн 4 ангилалд авч үзэж болно. Үүнд:

1. Хүнсний аюулгүй байдлын хяналт: хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, импортын болон дотоодын хүнсний бүтээгдэхүүний чанар стандартын.

2. Мал аж ахуйн хяналт: Мал эмнэлгийн хорио цээр, малын гаралтай өвчний хяналт, мах, сүүний үйлдвэрлэлийн эрүүл ахуйн стандарт, малын гаралтай бүтээгдэхүүний экспортын зохицуулалт.

3. Газар тариалан, ургамал хамгааллын хяналт: Ургамлын өвчин, хортон шавжийн тархалт, пестицид, бордооны хэрэглээ, газар тариалангийн бүтээгдэхүүний хяналт, баталгаажуулалт.

4. Экспорт, импортын хяналт: Мал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний чанарын шаардлага хангасан эсэхийг хянах, экспортын барааны эрүүл ахуйн гэрчилгээ олгох, гаалийн хяналт, лабораторийн шинжилгээ хийх.

Дээрхээс уг салбарт голлох чиг үүргийг хуулийн дагуу ХХААХҮЯ хэрэгжүүлдэг бөгөөд Монгол улсын Засгийн газрын тухай хуулиар ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах 17 чиг үүрэг хамаарч байна. Үүнд: 1) хүн амын хүнсний хангамжийн бодлого; 2) хүнсний аюулгүй байдлын асуудал; 3)мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого; 4)газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх

бодлого; 5)мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого; 6)мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал; 7)бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал; 8)мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал; 9)хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого; 10)малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого; 11)хөнгөн үйлдвэрлэлийн асуудал; 12)жижиг, дунд үйлдвэрийн асуудал; 13)дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт; 14)үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал; 15)салбарын мэргэжлийн хяналтын асуудал; 16)төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал; 17)агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал зэрэг болно.

Мөн Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд - хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах

- салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Засгийн газрын агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын хоорондын болон эдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны холбогдох байгууллагын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах зэрэг нийтлэг үүрэгтэй байдаг.

Үүнээс үзэхэд Монгол Улсын хувьд хүнсний хангамж, хөдөө аж ахуйн, тариалангийн салбарт баримтлах бодлогыг боловсруулж, ЗГ-аас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, хөдөлгөөн, аян зэрэг салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээг улс орны хэмжээнд хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналтыг хариуцах чиг үүрэг бүхий үндсэн байгууллага нь Монгол Улсад ХХААХҮЯ байна.

Түүнчлэн хүнс, хөдөө аж ахуйн салбарт ХХААХҮЯ-аас гадна эрх асуудлын хүрээнд бусад яам, тухайлбал, Эдийн засаг, хөгжлийн яам хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт боловсруулах, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт зэрэг асуудлаар, Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа, улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналтын үйл ажиллагаа, гааль, татварын бодлого, Байгаль орчин, уур амьчгалын өөрчлөлтийн яам байгалийн нөөцийн зохистой ашиглалт, нөхөн сэргээх бодлого, экологийн тэнцвэртэй байдал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого зэрэг тус бүрийн чиг үүргийнхээ хүрээнд энэ салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөр арга хэмжээнд тодорхой оролцоотой байдаг тул эдгээр төрийн захиргааны байгууллага, түүний харъяа агентлагууд тус тусын хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Үүндээр Монгол Улсын шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг Стандартчилал хэмжил зүйн газар хөдөө аж ахуй, хүнсний салбарын стандартыг тогтоох хяналт тавихад үнэмлэхүй оролцоотой байдаг.

Хүнсний аюулгүй байдлын тухай хуулиар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний эрүүл ахуйн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид СХЗГ (MASM)-н улсын MNS стандартын баталгаажуулалт хийлгэх ёстой. Стандарт, хэмжил зүйн газраас итгэмжлэл авсан байгууллагаар шалгуулж, шалгалтын үнэлгээний бичгийг хавсаргаж, СХЗГ-т өргөдөл гаргаж, гэрчилгээ авбал бараандаа MNS дугаарыг тавьж борлуулна. Энэхүү гэрчилгээг авсан хүнс үйлдвэрлэгчийг өмнө нь МХЕГ хянаж шалгах үүрэгтэй байсан бөгөөд газар дээр нь хяналт шалгалт хийж, зөрчилд шийтгэл ноогдуулах бүрэн эрхтэй, хүнсний чиглэлийн үйлдвэрлэгчдэд зориулж хүнсний аюулгүй байдлын талаарх сургалтуудыг зохион байгуулдаг байсан. Эдгээр чиг үүргүүд одоо холбогдох яам агентлагуудын харьяанд шилжсэн байна.[14]

Орон нутгийн хяналтын байгууллагуудын оролцоо – Аймаг, сумын түвшний хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт орон нутгийн түвшинд хяналт тавих байгууллагууд нь хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, мал эмнэлэг, ургамлын хорио цээр, байгаль орчны хамгаалал зэрэг тус тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улсын хэмжээний төрийн байгууллагын орон нутгийн салбар, нэгж эсхүл орон нутгийн удирдлагын түвшинд бие даан ажилладаг байгууллагууд байна.

Тухайлбал, хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, худалдаанд хяналт тавих, мал эмнэлгийн хяналт, ургамлын хорио цээр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарын шалгалт, байгаль орчин, газар ашиглалттай холбоотой хяналтыг орон нутагт төвийн байгууллагын салбар нэгж болон орон нутгийн хяналтын эрх бүхий этгээд хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ)
- Аймаг, сумын мал эмнэлгийн газар, нэгжүүд
- Аймаг, сумын ургамал хамгаалал, хорио цээрийн нэгжүүд
- Орон нутгийн худалдаа, хүнсний хяналтын албадууд
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг хамаарна.

Мөн орон нутаг дахь хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн нэгжүүд, Ургамал хамгааллын алба зэрэг чухал үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд багтана. Эдгээр байгууллагууд нь хүнсний аюулгүй байдал, мал аж ахуй, газар тариалан, байгаль орчинтой холбоотой бодлого хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд голлох үүрэгтэй.

Өмнөх зохицуулалтын хяналтын тогтолцоо

2003 оноос өмнө сайд тус бүрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байсан улсын хяналтын тогтолцоог буюу салбар тус бүрт байсан улсын хяналтын албаны 13 агентлаг, нэгжийг нэгдсэн тогтолцоонд оруулж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг байгуулсан байдаг.[15]

[14] Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл-2024
[15] Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ-Судалгааны тайлан 2021

МХЕГ-ыг татан буулгаж холбогдох яам агентлагт нэгтгэсэн Стандартыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих нь МХЕГ-ын үүрэг байв. Зах зээл дээрх гэнэтийн шалгалт, аж ахуйн нэгж байгууллагуудад газар дээр нь очиж шалгалт хийх зэргээр стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, 21 аймаг, Улаанбаатар хотын дүүргүүдэд салбар нэгжтэй, улсын хэмжээнд байцаагч нар ажилладаг байсан. 2022 оны сүүлээр МХЕГ-ыг татан буулгаж, хяналт шалгалтын чиг үүргийг нь холбогдох яамдад шилжүүлсэн. Хяналт шалгалтын хамрах хүрээ болон хяналтын чиг үүргийг шилжэн газруудыг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав. Тодруулбал, хуучнаар МХЕГ-ын МАА-н болон хүнсний хяналтын газар зах зээлд нийлүүлэгдэн худалдаалагдаж буй ХАА-н болон хүнсний бүтээгдэхүүн төдийгүй жижиглэн худалдаа, ресторан хоолны газрууд зэрэгт газар дээрх хяналт шалгалт болон тандалт хийдэг байсан. Мөн сургуулийн үдийн хоолны эрүүл ахуйн стандартын хяналтын хуудаст үндэслэн 1-2 жил тутамд шалгадаг байсан ба эдгээр чиг үүргийг ХХААХҮЯ-нд голлон шилжүүлсэн.[16]

Монгол Улсын хөдөө аж ахуйн хяналт, зохицуулалтын тогтолцоо нь үе шаттайгаар хөгжиж ирсэн. Өмнөх зохицуулалтын гол онцлог нь салбарын бодлого олон жижиг тогтоол, шийдвэрүүдээр удирдагддаг байсан явдал юм.

1. Хөдөө аж ахуйн тухай хууль (1999 он, шинэчилсэн 2016 он)
    - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын үндэс болсон.
    - Мал аж ахуй, газар тариалангийн салбарт санхүүжилт, татварын урамшуулал үзүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.
    - Гэхдээ хэрэгжилтийн хяналт сул, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний чанарын стандартыг хангах тогтолцоо бүрдээгүй.
2. Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (2012 он, шинэчилсэн 2021 он)
    - Хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, стандартын хяналтыг сайжруулах оролдлого хийсэн.
    - Гэвч хүнсний хяналтын механизмууд уялдаа султай, санхүүжилт хангалтгүй байсаар ирсэн.
3. Малын эрүүл мэндийн тухай хууль (2017 он)
    - Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, экспортын шаардлага хангах нөхцөлийг сайжруулахыг зорьсон.
    - Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн боловч санхүүжилтийн дутагдлаас болж бүрэн хэрэгжээгүй.
4. Хоршооны тухай хууль (1995 он, шинэчилсэн 2011 он, 2022 он)
    - Малчдын хоршооллын хөгжилд чиглэсэн боловч хоршоодын санхүүжилт, менежментийн асуудлыг нарийн зохицуулаагүй.
    - 2022 оны шинэчлэлт нь хоршоодын хариуцлагыг нэмэгдүүлэх, дэмжлэгийг илүү уялдуулах зорилготой байсан ч хэрэгжилтэд бэрхшээлтэй тулгарсан.

3.2. Хяналтын тогтолцоонд тулгарч буй асуудал

Монгол Улсын хөдөө аж ахуй, хүнсний хяналтын тогтолцоонд тулгарч буй сорилтуудыг олон хүчин зүйлтэй холбон авч үзэх шаардлагатай. Нийтлэг бэрхшээлүүдийн нэг нь байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, мэдээлэл солилцоо дутмаг байгаа явдал юм. Энэ нь хяналтын үйл ажиллагааны давхардал үүсгэж, оновчтой хяналт тавихад хүндрэл учруулж байна.

[16] Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл-2024

Санхүүжилтийн хомсдол болон санхүүжилтийн тогтвортой бус байдал нь салбарын хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд гол саад болж байна. Засгийн газрын санхүүжилтийн эх үүсвэр тогтворгүй, байнга өөрчлөгдөж байдаг тул урт хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг.

Хяналтын дэд бүтэц, лабораторийн хүчин чадлын сул байдал, бүс нутгийн лабораториудын чадамж хангалтгүй байх нь хүнсний бүтээгдэхүүн, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг баталгаажуулахад хүндрэл учруулдаг. Энэ нь малын өвчний эрсдэлийг нэмэгдүүлж, шүлхий, бог малын мялзан, бруцеллёз зэрэг халдварт өвчний тархалт өндөр байх шалтгаан болж байна.

Импортын хяналт сул, гаднаас орж ирж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, гарал үүслийн асуудал тодорхой бус байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр, дотоодын хяналт, хууль тогтоомжийн уялдаа муу, ил тод байдал хангалтгүй, мэдээллийн урсгал дутмаг байгаа нь асуудлыг улам хүндрүүлж, салбарын зохицуулалтын үр нөлөөг сулруулж байна.

Засаглалын түвшинд ч мөн уялдаа холбоо сул, хөдөө аж ахуйн бодлого, хүнсний аюулгүй байдал, мал аж ахуйн хөгжлийн бодлого тус тусдаа хэрэгжиж байгаа нь салбарын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс гадна, хяналтын тогтолцоо хэт олон төвтэй, олон байгууллага давхардсан чиг үүрэгтэй ажилладаг нь хариуцлагын тогтолцоог сулруулж байна.

Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхийн тулд салбар хоорондын уялдааг сайжруулж, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, хууль эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Монгол Улсын хөдөө аж ахуй, хүнсний хангамж, аюулгүй байдлын хяналтын тогтолцоо олон төрлийн хууль тогтоомж, байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурладаг. Гэхдээ лабораторийн хүчин чадал, хяналтын уялдаа холбоо, экспортын стандартын шаардлага зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Одоо байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд хяналтын тогтолцоог хэрхэн сайжруулах вэ?

Монголд Улсын ХАА-н салбарын хөгжилд олон тооны хөгжлийн түнш байгуулгууд өөр өөрийн байр суурь, зарчим, арга хэлбэрээр тусламж дэмжлэг үзүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд хөгжлийн түншүүдийн хоорондтусламжийн хамтын ажиллагааг үр ашигтай байлгахад чиглэсэн уялдаа холбоо хангалтгүй, урьдчилсан зохицуулалт сайтар хийгээгүйгээс тусламжийн үйл ажиллагаа давхцах явдал түгээмэл гарч байгааг харгалзан НҮБ-ын ХХААБ, АХБ-ын дэмжлэгээр ХХААХҮЯ, БОАЖЯ хамтран “Хүнс, ХАА-н хөгжлийн түншлэлийн бүлгийг” (Food and Agriculture Development Partner Group (FADPG) байгуулсан байна. Хүнс ХАА-н хөгжлийн төлөөх түншлэлийн бүлгийг байгуулсан зорилгыг “Хөгжлийн түншүүд хоорондын харилцаа, уялдаа холбооны чанар, давтамжийг сайжруулах, бодлогын тэргүүлэх чиглэлүүд, төслийн мониторинг, хяналт, үнэлгээний аргын талаар нэгдсэн ойлголттой болохын зэрэгцээ үйл ажиллагаа

давхардахаас зайлсхийх, мэдлэг, мэдээлэл солилцоог сайжруулж, Хүнс ХАА-н салбарын хөрөнгө оруулалт, тусламжтай холбоотой хөгжлийн түншүүд болон Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны ил тод байдал, зохицуулалт, зохицолыг сайжруулах явдал" гэж тодорхойлсон байна.

Одоогийн байдлаар Хөгжлийн түншлэлийн бүлгийн үйл ажиллагаанд оролцох нөхцөлд тодорхой хязгаарлалт байхгүй бөгөөд ХАА-н салбарт тусламж, дэмжлэг үзүүлэх сонирхолтой хоёр талт (олон талт) байгууллагууд оролцох боломжтой юм. Мөн хөгжлийн түншлэлийн бүлэг нь сонирхогч байгууллагуудаас бүрдсэн техникийн ажлын хэсэг буюу Technical Working Group (TWG) байгуулахаар төлөвлөж байна. Техник ажлын хэсэг нь Хөгжлийн төлөөх түншлэлийн бүлгийн ажлын албанд хурал зөвлөлгөөн дээр хэлэлцэх асуудал, хэрэгжүүлбэл зохих тодорхой судалгаа шинжилгээний санал бэлдэж өгөх үүрэгтэй бөгөөд хөгжлийн түншлэлийн бүлэг дээр тодорхой асуудлаар явагдах зөвлөлгөөн, хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах үйл явцад хувь нэмэр оруулах юм.[17]

Мөн сүүлийн жилүүдэд улс орнууд хяналтын байгууллагуудаа чиг үүргийн давхцлыг арилгах, хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хяналтын нэгдмэл тогтолцооны чиг хандлагаруу явж байна. Энэ нь олон төрлийн хяналтын чиг үүргийг цөөн тооны байгууллагад төвлөрүүлснээр давхардал арилж, хяналтын чанар сайжирч, үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэхэд нөлөөлөх сайн талтай.

Нэгдмэл хяналтын тогтолцооны хүрээнд байгууллагууд дотооддоо хяналтын чиглэл бүрийг хариуцсан нэгжүүдэд хуваагдан, салбар тус бүрийн хууль, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Энэ нь нэгдмэл тогтолцооны үр дүнтэй хэрэгжилтийг хангах нэг арга зам болж байна.

Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах, хөтөлбөрүүдийн уялдааг хангахын тулд салбар хоорондын мэдээллийн солилцоо, лабораторийн хяналтын тогтолцоо, гарал үүслийн бүртгэл, худалдааны төвлөрсөн зохицуулалт зэрэг гол хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Ингэснээр хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хяналтын бүхий л шатанд үр нөлөө сайжирч, хүн амын хүнсний аюулгүй байдлыг урт хугацаанд тогтвортой хангах боломж бүрдэнэ.

Цаашид ХХААХҮЯ голлон холбогдох яам агентлагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд болон бусад холбогдох олон улсын байгууллага, донорууд тай хамтран зохицуулалтыг хийж хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Холбогдох гол яам агентлагуудын хөгжлийн бодлогын чиглэлийн асуудлыг ЭЗХЯ, төсвийн зохицуулалтын асуудлыг СЯ, хандивлагч байгууллагуудын зохицуулалтыг ГХЯ, мөн БОУАӨЯ зэрэг байгууллагууд хариуцах бөгөөд дундын мэдээллийн баазыг бий болгож, үүнд бүх талын оролцогчид нэвтэрч шаардлагатай мэдээллийг авдаг болгох шаардлагатай. Энэ ажлыг дээр дурдсанчлан ХХААХҮЯ хариуцах хэрэгтэй. Тухайлбал ХХААХҮЯ, Бодлого төлөвлөлтийн газар төсөл хөтөлбөрийн ерөнхий удирдлага зохицуулалтыг хариуцаж, ГТБХЗГ, МААБХЗГ, ХөҮБХЗГ, ХүҮБХЗГ нь тус тусын салбар чиглэлийн төслүүдийг удирдан чиглүүлэх арга хэмжээг авна.

Үүний зэрэгцээ, хөтөлбөрүүдийн хяналт шалгалтыг хариуцсан төрийн байгууллага Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайланг нэгтгэн, тус газраас хөтөлбөр, хөдөлгөөний

[17] Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл-2024

хэрэгжилтийг дүгнэх аргачлалыг боловсруулах, одоо байгаа зарим аргачлалыг сайжруулах арга хэмжээг чиг үүргийн хувьд авах шаардлагатай байна.

3.3. Хяналтын тогтолцооны талаарх олон улсад баримталж байгаа баримт бичиг бусад улсын туршлага

Энэ хэсэгт хүнс, ХАА-н салбарт олон улсад баримталж байгаа үндсэн зарчим болон энэ салбарт тэргүүлэх туршлага бүхий улс орнуудыг судлан тэдргээрийн хяналт, удирдлагын тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн болно.

3.3.1. Олон улсын нийтлэг зарчмын баримт бичиг

НҮБ-ийн Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага буюу FAO (Food and Agriculture Organization) нь хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, өлсгөлөнг бууруулах чиглэлээр олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд тус байгууллагаас НҮБ-ын Хүнсний аюулгүй байдлын хороо (CFS)-той хамтран "Хөдөө аж ахуй, хүнсний тогтолцоонд хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим"-ыг 2014 онд боловсруулсан.

Энэхүү зарчмууд нь (удирдамж) улс орнууд өөрийн эдийн засаг, нийгмийн хөгжил, байгал цаг уурын онцлог зэрэгт нийцүүлэн хөдөө аж ахуйн, хүнсний нөөц, аюулгүй байдлын чиглэлээр авч хэрэгжүүлбэл зохих зөвлөмжийн чанартай баримт бичиг бөгөөд тус зарчмыг өөрийн гишүүн орнуудын ХАА хүнсний стандартад мөрдүүлэхийг дэмждэг.

“Хөдөө аж ахуй, хүнсний тогтолцоонд хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим”-д хүнс, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих, байгалийн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах, чанартай, аюулгүй, шим тэжээлтэй хүнсний хүртээмжийг хүн бүрт хүргэх, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, улс орнуудад хөдөө аж ахуй, хүнсний салбарт зохистой хууль эрх зүйн орчинг бий болгоход дэмжих зорилго бүхий 10 зарчим, түүний нийцлийн үзүүлэлтүүд байдаг.

Үүнээс чухалчлан үзэх нь дээрх чиглэлийн дагуу төрийн зүгээс улс орнууд авч хэрэгжүүлэх үүрэг ролийг тодотгон тусгасан бөгөөд багцлан үзвэл дараах төрийн оролцоо үүргийг тусгасан. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдал, хүртээмжтэй байдлаар хангагдах эрхийг баталгаажуулах олон улсын баримт бичгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, ХАА хүнсний салбарт хөрөнгө оруулалт болон аливаа бизнесийн бусад үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах зайлшгүй нөхцөлийг тусгах
- зарчмуудыг худалдаанд саад учруулах, хамгаалалт үзүүлэх бодлогыг далд хэлбэрээр дэмжих, эсвэл өөрсдийн бодлогыг бусад улсад тулгах байдлаар хэрэгжүүлэхгүй байх
- тогтвортой, урт хугацааны хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн үндэсний стратеги боловсруулж хэрэгжүүлэх
- хөдөө аж ахуй болон хүнсний салбарын ажилчид зэрэг хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах
- зарчмуудыг хэрэгжүүлэхдээ нээлттэй ил тод, тогтвортой бодлого, хууль, зохицуулалтыг бий болгох буюу сайжруулах замаар, шаардлагатай тохиолдолд хяналт, хариуцлагын механизм бүрдүүлэх замаар хэрэгжүүлэх

- Хөдөө аж ахуй болон хүнсний тогтолцооны хөрөнгө оруулалтын бодлого болон холбогдох бусад бодлого боловсруулах үйл явцад оролцогч талуудын бодит, идэвхтэй оролцоог дэмжих
- Төрийн байгууллагуудын бүх шатны уялдаа холбоог хангаж, дэмжих
- Мэдээлэл, үйлчилгээ, урамшуулал, нөөцийн болон холбогдох төрийн байгууллагуудад хандах эрхийг ялгаварлалгүй нээх
- Хөдөө аж ахуй болон хүнсний тогтолцоонд хариуцлагатай хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай нийтэд ашиг тус болох бараа үйлчилгээ, түүний дотор дэд бүтэц, эрчим хүч, байгаль орчны хамгаалалт, судалгаа хөгжүүлэлт, боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээл, нийгмийн үйлчилгээ зэрэг олон төрлийн үйлчилгээг хангах чухал үүрэгтэй. Ялангуяа хөдөө орон нутагт эдгээр үйлчилгээнд хүртээмжтэй, ялгаварлалгүй хандах боломжийг хангахыг дэмжих зэрэг багтана.

Хөдөө аж ахуй болон хүнсний системд хариуцлагатай хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төрийн дээрх үүргүүдээс гадна зарчимд дараах 3 үүргийг чухалчлан үздэг. Үүнд:

I. Жижиг болон дунд бизнес, хоршоолол, холбоод, фермерийн болон үйлдвэрлэгчдийн гэрээ байгуулах, бусад зах зээлд оролцогч талуудтай хамтран ажиллах боломжийг олгох үүднээс боловсрол, сургалт, чадвар хөгжүүлэх боломжийг сайжруулах;
II. Шинэ технологийн санаачлага, туршилтийг дэмжих, үүнд, жижиг үйлдвэрлэгчдийн өөрсдийн шинэ санаачлагыг түгээх, техникийн тусламж үзүүлэх, фермерүүдийн хооронд ур чадвар хуваалцах, мөн харилцан зөвшөөрснөөр хувь хүн, орон нутгийн, үндэсний эсвэл олон улсын талуудын хооронд технологийг шилжүүлэх;
III. Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ил тод, хүртээмжтэй бизнесийн загвар болон түншлэлийг дэмжих, үүнд төр, хувийн хэвшлийн түншлэлүүдийг хамруулах.

Дээр дурдсанчлан НҮБ-ын ХХААБ-ын гишүүн орнууд эдгээр зарчмыг чиглэл болгон ажиллахыг зөвлөдөг бөгөөд үүнд хүнс, ХАА салбарт хүний эрхийг хангаж ажиллах, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоотой, ил тод байлгах, уг салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн оролцоог бодлого боловсруулах түвшинд оролцуулах зэрэг үндсэн асуудлыг олон талаас тусгасан болно.

Түүнчлэн хүнсний аюулгүй байдал, олон улсын худалдаанд баримтлах чанарын шаардлагатай холбоотой Кодекс Алиментариус (Codex Alimentarius), ЕХ-д мөрдөгддөг “Фермээс хоолны ширээнд хүртэл стратеги” (Farm to fork strategy) зэрэг олон улсын стандарт, стратегиудыг хөгжингүй улсууд нутагшуулан хэрэгжүүлдэг. Эдгээр нь доор дурдсан улс бүрийн үйл ажиллагаанд тусгалаа олсон байдаг.

3.3.2. Бусад улс орнуудын хяналтын тогтолцоо, сайжруулалтын туршлага

АНУ

Хяналтын төвлөрсөн тогтолцоо: USDA (The United States Department of Agriculture буюу АНУ-ын Хөдөө аж ахуйн яам) нь хяналтын голлох үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, газар тариаланг хөгжүүлэх, байгалийн нөөцийг хамгаалах, хүнс тэжээлийн тусламж, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих

болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлыг төвлөрүүлэн хэрэгжүүлдэг байна. Ингэхдээ FDA (Хүнс, эмийн удирдлагын газар), SNAP (Хүнсний нэмэлт тэжээлийн тусламжийн хөтөлбөр) ,Farm Service Agency (FSA): Тариаланчдад олгож буй зээлийн хөтөлбөр, хөдөө аж ахуйн даатгалд хяналт тавьдаг, Environmental Protection Agency (EPA): Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянаж, пестицидийн хэрэглээг зохицуулах агентлаг зэрэг бусад байгууллагуудтай нягт холбоотой ажилладаг байна.

АНУ-ын Хөдөө аж ахуйн судалгаа, боловсрол, эдийн засгийн зөвлөл (NAREEEAB) нь хөдөө аж ахуйн судалгааны бодлогыг хянадаг бие даасан байгууллаг бөгөөд үндсэн үүрэг нь хөдөө аж ахуйн судалгаа, инновацийг үнэлэх, бодлогын зөвлөмж гаргах, Хөдөө аж ахуйн яам (USDA)-ын боловсруулсан хөтөлбөрүүдийг үнэлж, үр нөлөөтэй эсэхийг дүгнэх, хүнсний аюулгүй байдал, байгаль орчны нөлөөллийг судладаг бөгөөд зөвлөл нь бүрэн эрхийнхээ дагуу АНУ-ын Конгрессын хөдөө аж ахуйн холбогдох хороодод тайлан, зөвлөмж өгдөг.[18]

Мөн санхүүжилтийн хяналт, зөрчлийг илрүүлэх чиглэлээр ажилладаг аудитын хяналтын тогтолцоог Ерөнхий инспекторын газар (OIG) хариуцдаг.

Европын Холбоо (ЕХ)

Нэгдсэн/цогц хяналтын тогтолцоотой. Европын Хүнсний Аюулгүй Байдлын Газар (EFSA) нь Европын Холбооны (ЕХ) хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналтыг хангах үүрэгтэй тусгай байгууллага юм. Энэ байгууллага 2002 онд байгуулагдсан бөгөөд түүний үндсэн зорилго нь европын хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, хүнс болон хоол тэжээлтэй холбоотой эрсдэлийг үнэлэх, судалгаа хийх, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй төвлөрсөн удирдлагын байгууллага юм. Үйл ажиллагаа нь дараах чиглэлээр хэрэгждэг.

- Хүнсний аю9улгүй байдлыг үнэлэх: Хүнсний бүтээгдэхүүнүүдийн аюулгүй байдлыг судалж, эрсдэлтэй холбоотой зөвлөмж гаргадаг.
- Шинжлэх ухааны судалгаа хийх: Хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн талаархи шинжлэх ухааны судалгааг хийж, дүн шинжилгээ гаргана.
- Зөвлөмж гаргах: Европын Комисст болон бусад хууль тогтоогчид, гишүүн орнуудад хүнсний аюулгүй байдлын талаар зөвлөмж, мэдээлэл өгөх.
- Эрсдэлийг үнэлэх: Хүнс болон хүнс үйлдвэрлэлийн процесст гарч болох эрсдэлүүдийг үнэлж, түүнийг бууруулах арга хэмжээг санал болгодог.

EFSA нь Европын Холбооны улс орнуудын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын салбарт чухал үүрэг гүйцэтгэж, нийгэм, эдийн засагт гарч болох эрсдлээс хамгаалахын тулд үндэсний болон олон улсын хэмжээнд

[18] https://nareeeab.ree.usda.gov/about-nareeeab

хамтран ажилладаг. Мөн ЕХ-д дижитал хяналтын систем нэвтрүүлсэн бөгөөд үүгээр мал, хүнсний гарал үүсэл, чанарын баталгааг бүртгэдэг. Тухайлбал, хүнсний мөшгөх систем (Traceability System)-ээр дамжуулж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарал үүсэл, үйлдвэрлэлийн бүх үе шатанд хяналт тавьдаг.

Түүнчлэн, Европын Холбооны Аудитын шүүхийн Хөдөө аж ахуйн аудит (European Court of Auditors (ECA) – Agriculture Sector Audit) нь хөдөө аж ахуйн санхүүжилт, төсөл хөтөлбөрийг бие даан хянах чиг үүрэгтэй байдаг бөгөөд ЕХ-ны хөдөө аж ахуйн нийтлэг бодлого (хүнсний аюулгүй байдлыг хангасан фермийн үйлдвэрлэлд GAP standart Good Agricultural Practices CAP)-ын хэрэгжилийг үнэлэх, төсвийн зохистой зарцуулалтыг шалгаж, Европын Парламент болон олон нийтэд жил бүр тайланн гаргадаг.[19]

Австрали ба Шинэ Зеланд

Нэгдсэн ба Хамтарсан хяналтын тогтолцоо: Австрали, Шинэ Зеланд улсуудын хүнсний хяналтын тогтолцоог хамтарсан байдлаар Food Standards Australia New Zealand (FSANZ) байгууллага хяналт тавьдаг. Тус байгууллага нь 1991 онд байгуулагдсан бөгөөд түүний үндсэн зорилго нь хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, хэрэглэгчдэд аюулгүй хүнс нийлүүлэхтэй холбоотой стандарт шаардлагыг тавьж ажилдаг.

Үндсэн үүрэг нь: Хоол хүнсний стандарт боловсруулах: FSANZ нь Австрали болон Шинэ Зеландын хүнсний аюулгүй байдлын стандартуудыг боловсруулах, шинэчлэн батлах үүрэгтэй. Энэ нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, шошгололт, хүнсэд ашиглах нэмэлт бодисуудын талаархи шаардлагуудыг багтаадаг.

Энэ хамтарсан хяналтын дундын байгууллагаас гадна хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тус тусын байгууллагууд ажилладаг.Тухайлбал, Австралийн Хөдөө Аж Ахуйн Хяналтын Агентлаг (DAFF), Австрали: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдлыг хянахад Australian Pesticides and Veterinary Medicines Authority (APVMA), Australian Competition and Consumer Commission (ACCC) зэрэг байгууллагууд ажилладаг.

Австрали Улсад Австралийн Хөдөө аж ахуйн хороо (SCA) нь байгын ажиллагаатайгаар тус улсын парламентын харьяанд бие даасан “зөвлөл” байдаг бөгөөд Засгийн газрын хөдөө аж ахуйн бодлого, төсөл хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдэг. УИХ-ын байгын хороодоос ялгаатай нь уг хороонд парламент, ЗГ-ын төлөөллөөс гадна Засгийн газрын бус бусад байгууллагын төлөөлөл багтдаг. Энэ хороо нь төсөл хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээс гадна хүнсний аюулгүй байдал, нөөцийн менежмент, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой стратеги

[19] https://www.eca.europa.eu/en/agriculture-rural-development

боловсруулдаг бөгөөд жил бүр парламент болон олон нийтэд тайлан гаргадаг.[20]

Харин Шинэ Зеланд улсад Ministry for Primary Industries (MPI) нь мал, газар тариалан, экспортын бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянадаг бөгөөд дээр нь хөдөө аж ахуйн салбар дахь ЗГ-ынхаа бодогын хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий парламентийн Үндсэн үйлдвэрлэлийн хороо (Primary Production Select Committee)-г ажилладаг. Энэ хороо нь хөдөө аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнсний хангамж, мал аж ахуй, газар тариалангийн салбарын бодлогын үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хэлбэр, үйл ажиллагааны чиглэлийн хувьд манай улсын УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө ахуйн байнгын хороотой төстэй. Дан парламентийн гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Япон

Төвлөрсөн бус хяналтын тогтолцоо: Японд хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналтыг хэд хэдэн байгууллага хуваан гүйцэтгэдэг бөгөөд төвлөрсөн буюу нэгдмэл хяналтын тогтолцоо бус, харин чиг үүргийн тус тусдаа салбарын хяналт бүхий бүтэцтэй. Гэвч Япон нь хяналт, стандартчилал, зохицуулалтын нарийн зохицуулалттай бөгөөд олон улсын түвшинд тэргүүлэгчийн тоонд зүй ёсоор багтана. Япон улс хүнсний аюулгүй байдлын олон талт тогтолцоог бий болгож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон хүнсний сүлжээг бүхэлд нь зохицуулдаг бөгөөд энэ нь хүнсний аюулгүй байдлыг хангах, экологийн тэнцвэрийг хадгалах, хэрэглэгчдэд аюулгүй, чанартай хүнсийг хүргэх зорилготой. Түүнчлэн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, гарал үүслийг хянах Japan Agricultural Standards (JAS) системийг хөгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн талаарх ЗГ-ын бодлого үйл ажиллагааны хэрэгжилтэд Японы парламентын Дээд болон Доод танхим тус бүр дэх Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуйн хороо хяналт тавин ажилладаг.

БНСУ

Төвлөрсөн бус хяналтын тогтолцоо: Солонгос Улсад хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн чиглэлээр нарийн зохион байгуулалттай, олон шатлалт хяналтын тогтолцоотой. Япон улстай адилаар хяналтын нэгдмэл бус буюу салбарын тусдаа хяналтын тогтолцоо бүхий улс. Энэ тогтолцоо нь хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, борлуулалтын бүхий л үе шатанд өндөр шаардлага тавьж, хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх зорилготой.

Түүнчлэн, бусад улс орнуудтай төстэй байдлаар БНСУ-ын Үндэсний Ассамблейн Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн хэрэг, далай, загасны аж ахуйн хороо (Agriculture, Food, Rural Affairs, Oceans and Fisheries Committee) хороо нь Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн хэрэг, далай, загасны

[20] https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House/Agriculture/Role_of_the_Committee

аж ахуйн яамны (MAFRA) болон холбогдох бусад агентлагуудын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд хяналт тавьдаг байна.

Улсын хэмжээнд дээрх MFDS, MAFRA, APQA, NFIS зэрэг байгууллагууд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдал, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтыг олон шатлалт тогтолцоогоор явуулдаг.

Дээр дурдсанчлан БНСУ-ын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналтын тогтолцоо нэгдмэл бус (салбарласан) хяналтын тогтолцоотой бөгөөд зарим тохиолдолд хяналтын давхцал гардаг.

Хятад

Төвлөрсөн хяналтын тогтолцоо: Хяналтын тогтолцоо өндөр төвлөрсөн хэлбэртэй бөгөөд Ministry of Agriculture and Rural Affairs (MARA) гол зохицуулагч агентлаг юм Хяналтын хувьд салбарласан бүтэцтэй хэдий ч төвлөрсөн байдлаар яам дээр бодлого, хэрэгжилтээ хянадаг. MARA нь Хятад улсын хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй, стандарт, экспорт, хөдөө орон нутгийн хөгжил зэрэг өргөн хүрээний бодлогыг удирддаг үндсэн зохицуулагч байгууллага юм. Тус яамнаас холбогдох бүх агентлагуудын бодлогын уялдааг хангадаг. Түүнчлэн импортын хатуу хяналттай.

Дэлхийн Банк хөдөө аж ахуйн хөгжлийн хөтөлбөрүүдийн хүрээнд хяналтын тогтолцооны сайжруулалт, санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зөвлөмж өгдөг.

ОУВС хөдөө аж ахуйн салбар дахь санхүүгийн сахилга бат, зээлийн тогтвортой байдлыг хангахад анхаардаг.

Улс орнуудын хяналтын тогтолцооны талаарх дүгнэлт

Дэлхийн улс орнуудын хяналт шалгалтын байгууллагын тогтолцоог нэгдмэл болон нэгдмэл бус гэж хоёр ангилж болно.

Нэгдмэл хяналтын тогтолцооны давуу талууд:
- Хяналтын чиг үүргийн давхардал үүсэхээс сэргийлнэ.
- Төсөв, нөөцийг оновчтой зарцуулах боломжтой.
- Хяналт шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгж, иргэдэд санхүүгийн болон ажлын ачаалал үүсгэхгүй.

Сул талууд:
- Хяналтын байгууллагын удирдлага хэт төвлөрөх эрсдэлтэй.
- Ачааллын жигд бус хуваарилалт нь хяналтын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Сүүлийн жилүүдэд улс орнууд хяналтын байгууллагуудаа чиг үүргийн давхцлыг арилгах, хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор нэгтгэх тал ажиглагдаж байгаа хэдий ч энэ нь тухайн улсын өөрийн онцлог, хүн ам, эдийн засаг гээд олон шалтгаанаас хамаарч уг хандлагыг авах эсэх нь хамаарч байна. Олон төрлийн хяналтын чиг үүргийг цөөн тооны байгууллагад төвлөрүүлснээр давхардал арилж, хяналтын чанар сайжирч, үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж байна гэж үздэг. Нэгдмэл хяналтын

тогтолцооны хүрээнд байгууллагууд дотооддоо хяналтын чиглэл бүрийг хариуцсан нэгжүүдэд хуваагдан, салбар тус бүрийн хууль, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Энэ нь нэгдмэл тогтолцооны үр дүнтэй хэрэгжилтийг хангах нэг арга зам болж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Монгол Улсын хөдөө аж ахуйн бодлогын хэрэгжилт сайжирч байгаа ч уялдаа холбоогүй байдал, давхардсан зохицуулалт, хяналтын сул тогтолцоо нь бодлогын үр дүнг бууруулах эрсдэлтэй байна. Олон улсын туршлагыг судлан, илүү төвлөрсөн, ил тод, үр дүнтэй хяналтын тогтолцоо бүрдүүлэх нь салбарын хөгжлийг дэмжих гол арга зам болохыг энэ тайлан харуулж байна.

Мөн сүүлийн жилүүдэд улс орнууд хяналтын байгууллагуудын чиг үүргийг оновчтой зохион байгуулах, давхардлыг арилгах, хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор нэгдмэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлд түлхүү анхаарч байна. Энэ тогтолцооны гол зорилго нь олон төрлийн хяналтын чиг үүргийг цөөн тооны байгууллагад төвлөрүүлж, хяналтын уялдаа холбоог сайжруулах, нөөцийн үр ашигтай байдал, зохицуулалтын чанарыг дээшлүүлэхэд оршдог бөгөөд дараах давуу талтай. Үүнд:

1. Хяналтын давхардлыг арилгах: Энэ нь хяналтын шалгалтын гол зарчмын нэг бөгөөд Төрийн хяналт шалгалтын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх.” гэж заасан байдаг. Энэ нэг талаас хяналтын чиг үүрэг тодорхой болж, хяналтын чанар, уялдаа сайжруулах, нөгөө талаас хяналтад хамрагдах этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилготой.
2. Үр нөлөө, үр ашгийг нэмэгдүүлэх: Хяналтын байгууллагуудын бүтэц, чиг үүрэг оновчтой байснаар илүү мэргэшсэн, хариуцлагатай, үр дүнтэй хяналтын тогтолцоо бүрдэнэ. Энэ нь хууль, дүрэм журмын хэрэгжилтэд илүү нарийвчилсан, бодитой хяналт тавих нөхцөлийг бүрдүүлнэ.
3. Хяналтын нэгжүүдийн мэргэшлийг нэмэгдүүлэх: Нэгдмэл тогтолцооны хүрээнд байгууллагууд дотооддоо хяналтын чиглэл бүрийг хариуцсан мэргэшсэн нэгжүүдэд хуваагдан ажилласнаар тухайн салбарын онцлогт тохирсон нарийвчилсан хяналт тавих боломж бүрдэнэ.
4. нэгдмэл байдал: Хяналтын байгууллагуудын уялдааг хангаж, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй.

Иймд, нэгдмэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь хяналтын байгууллагын бүтцийг оновчтой зохион байгуулж, үр дүнтэй, хариуцлагатай хяналтын механизм бүрдүүлэх чухал арга зам болж байна.

Зөвлөмж

Энэ тайланд судлагдсан тогтоолуудын хэрэгжилтээс дүгнэн үзэхэд Төрөөс хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг үр дүнтэй, шуурхай, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, цаашдын тогтвортой байдлыг хангахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар судлах, анхаарах шаардлагатай байна.

1. Хөтөлбөр, арга хэмжээний хяналтын тогтолцоог өөрчлөх буюу нэгдсэн хяналтын тогтолцоо бий болгох

Өмнөх хэсгүүдэд дурдсанчлан, Монгол Улсад хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогыг тодорхойлж, зохицуулалт хийдэг гол байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) юм. Яам нь бодлогын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаас гадна тухайн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг давхар хэрэгжүүлдэг. Энэ нь салбарын онцлог, мэргэжлийн шинж чанарыг хадгалах давуу талтай боловч бодлого боловсруулагч байгууллага өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөхөд хамааралтай дүгнэлт (bias) гаргах эрсдэл бүхий сул талтай.

Иймээс бие даасан хяналтын тогтолцоо байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Дэлхийн зарим улс оронд бодлого боловсруулдаг байгууллага нь хяналтын чиг үүргийг давхар хэрэгжүүлэхээс сэргийлэхийн тулд бие даасан хяналтын хороо байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Жишээлбэл, Австрали, Англи[21], АНУ, ЕХ болон Шинэ Зеланд зэрэг орнууд байгаа ба улс тус бүрийн жишээг олон улсын хяналтын тогтолцоог сайжруулсан туршлагын тайлангийн талаарх өмнөх хэсэгт дурдсан тул энд дахиж оруулаагүй болно.

Эдгээр орнуудын хувьд бүгд өндөр хөгжилтэй орнууд бөгөөд Монгол Улстай харьцуулах нь учир дутагдалтай хэдий ч хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын стандартыг тогтоож байгаа тэргүүлэх орнууд юм. Түүнчлэн хөгжиж буй орнуудын хувьд Хөдөө аж ахуй, хүнсний хяналтын бие даасан хороо байгуулсан туршлага элбэг бус байна.

Ийм бүтэц нь бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг хөндлөнгийн, хараат бус байдлаар үнэлэх боломжийг бүрдүүлж, төрийн шийдвэрийн ил тод байдал, үр дүнтэй байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, хамгийн гол нь тухайн хөтөлбөр, төлөвлөгөөг бодитой хэрэгжилтэд дэмжлэг болох чухал ач холбогдолтой.

Монгол Улсад тухайлсан асуудлыг эрхэлсэн Үндэсний хороог хууль тогтоомжийн дагуу байгуулан ажиллуулж байгаа сайн туршлага бий. Тухайлбал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохион байгуулалтын тухай хуулийн дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу байгуулагдсан Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо зэрэг хороод байгуулагдан ажиллаж байна. Эдгээрээс чиг үүргийн хувьд Хяналт, үнэлгээний үндэсний хороо нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг эрхлэх сайдын хувьд хамаарах боловч хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тухайлсан хяналт тавих, уялдаа холбоог хангуулан ажиллах асуудлыг УИХ-ын холбогдох Байнгын хорооны төлөөлөл, оролцоотой байгуулж хууль тогтоох байгууллагаас ЗГ-ын хөтөлбөрт хяналт тавих эрхийг хангуулах

[21] Их Британид Хөдөө аж ахуй, тариалалтын хөгжлийн зөвлөл (AHDB) нь хөдөө аж ахуйн салбарын бие даасан хяналт, судалгааны байгууллага байдаг. Үндсэн үүрэг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, өрсөлдөх чадварын үнэлгээ хийх, фермерүүдийн сургалт, зөвлөгөө, инновацийг дэмжих, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, дэмжлэгийн үр нөлөөг хянах, үнэлэх (эх сурвалж: https://ahdb.org.uk/about-ahdb)

боломжтой юм. Энэ нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан дэд хороо байгуулах зохицуулалтын хүрээнд болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалтын[22] хүрээнд хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Иймээс 3Г-аас хэрэгжүүлж байгаа үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хянах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөтөлбөр хоорондын уялдааг сайжруулах, цаашид хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд бие даасан Үндэсний хороо эсхүл Хүнс, хөдөө аж ахуйн салбарын Үндэсний дэд хороо (цаашид “Хороо” гэх-г байгуулах боломжтой байна.

Хорооны үндсэн чиг үүрэг:

- Улсын хэмжээнд хэрэгжиж буй хүнс, хөдөө аж ахуйн хөтөлбөр, төсөл, стратегийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар тогтмол тайлан гаргаж, ил тод мэдээлэх;
- Засгийн газар, УИХ-д тогтсон хугацаанд хяналт-шинжилгээний үр дүнг тайлагнах;
- Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог хангах;
- Төрийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн хяналт, оролцоог сайжруулах.

Хорооны зохион байгуулалт

Үндэсний дэд хорооны бүтцэд:

- Салбар хороод – тодорхой хөтөлбөр, бодлогын хэрэгжилтэд чиглэсэн тусгай чиг үүрэгтэй нэгжүүд (жишээ нь Хүнсний хувьсгал Дэд хороо, Цагаан алт Дэд хороо, Шинэ хоршоо Дэд хороо г.м);
- Шинжээчдийн зөвлөл – судалгаа, үнэлгээ хийх мэргэжлийн баг ажиллуулах боломжтой.

Хорооны үйл ажиллагааны тогтвортой байдал, санхүүжилт

Хороо нь УИХ-аас байгуулагдаж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим болох хараат бус, бодитой, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах, (4.2.1."хараат бус, бодитой, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах зарчим" гэж Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газар болон олон улсын байгууллагаас хараат бус мэдээллийн эх үүсвэрт тулгуурлаж, нягтлан үзсэний үндсэн дээр хууль ёсны, бодитой, иж бүрэн тооцоо, судалгаа, мэдээлэл, дүгнэлтийг үндэслэхийг;) ил тод байх зарчмын (4.2.3."ил тод байх зарчим" гэж хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл явц, холбогдох мэдээлэл, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэхийг.) хүрээнд ажиллах бөгөөд Хорооны үйл ажиллагааг тогтвортой, хараат бус байлгахын тулд:

[22] 3.1.3.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой байдал, харилцан уялдааг хангуулах; 3.1.4.төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх шатанд хяналт тавих, төсвийн сахилга батыг хангуулах;

- Тусгайлан баталсан төсөвтэй байх;
- Тухайн салбарын хөгжлийн сангуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгууллагууд, түншүүдээс техникийн болон санхүүгийн дэмжлэгийг татах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэхүү Үндэсний дэд хороог байгуулах нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, төрийн үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах чухал шинэчлэл болох боломжтой гэж үзэж байна. Мөн энэхүү хороо нь бие даасан, хараат бус, өөрийн шийдвэрийн хэрэгжилтийн хангуулах эрх зүйн чадамжтай байх шаардлагатай бөгөөд улсын хэмжээний томоохон хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шинэ хяналтын тогтолцооны загвар болох боломжтой юм.

Хорооны бүтэцийн дээрх схем, чиг үүргийг дараах зурагт үзүүлэв.



2. Тогтоолуудын уялдааг сайжруулах

- УИХ болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийг боловсруулахдаа хэрэгжүүлэх үйл ажиллагааны салбарыг хариуцсан төрийн захиргааны байгууллагаас нэгдсэн удирдлага, бодлогоор хангах нь чухал. Мөн бусад холбогдох байгууллагын оролцоо, саналыг хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн журмыг чанд мөрдөн тусгах нь тогтоол хоорондын уялдаа холбоог сайжруулж, бодлогын залгамж чанарыг хангах үндэс болно.
- Цахим мэдээллийн санг салбар тус бүрээр, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, түүний санхүүжилтг, хариуцаж байгаа байгууллага, хуулийн этгээд зэргийг хялбар хайлтаар хандан авах боломжтой байдлаар ашиглах боломжийг нэвтрүүлэх.
- Бодлого боловсруулах шатанд орон нутгийн захиргаа, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх.
- Шинээр гаргах шийдвэр, тогтоол бүрийг өмнөх бодлоготой хэрхэн уялдаж буйг нарийвчлан судлах.
- Impact Assessment (Нөлөөллийн үнэлгээ) буюу бодлогын үр дагаврын шинжилгээ хийхийг хуульчлах.
- “Төлөвлөгөө-Гүйцэтгэл-Шалгалт-Сайжруулалт” (PDCA)[23] зарчмыг баримтлан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд нэвтрүүлэх.

[23]PDCA мөчлөг (Plan-Do-Check-Act)

3. Санхүүжилтийн менежментийг сайжруулах

Санхүүжилтийн давхардлыг арилгаж, нэгдсэн удирдлагатай, үр ашигтай санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх.

- Хүнсний болон хөдөө аж ахуйн салбарт бусад түншлэгч байгууллагуудын дэмжлэг, оролцоог татах нь чухал боловч эх үүсвэр, нөөцийн зарцуулалтыг оновчтой болгохын тулд мэдээллийн нэгдсэн дата төвийг байгуулах шаардлагатай. Энэхүү төв нь мэдээллийг нээлттэй, ил тод байдлаар хуваалцаж, сонирхсон хувь хүн, хуулийн этгээд мэдээлэлд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлэх ёстой.
- Хөдөө аж ахуйн үр ашиггүй, давхардсан төсөл, хөтөлбөрүүдийг цэгцлэх.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчимд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулах.
- Хөдөө аж ахуйн зээл, тусламж, татаасыг үр дүнтэй, зорилтот бүлэгт чиглүүлэх ил тод механизм бий болгох.
- Салбарын аж ахуйн нэгжүүдийг хөрөнгө оруулалт, инновац, даатгалд хамруулах боломжийг нэмэгдүүлэх.

4. Хяналтын механизмыг сайжруулах

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах
- Бодлогын хэрэгжилт, төсвийн зарцуулалтад хяналт тавих нэгтгэсэн үнэлгээний механизм, стандартыг бий болгох.
- Төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийг нэгтгэх тоон мэдээллийн сан байгуулж, дата дээр суурилсан бодлого боловсруулах.
- “Төлөвлөгөө-Гүйцэтгэл-Шалгалт-Сайжруулалт” (PDCA) зарчмыг баримтлан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд нэвтрүүлэх.
- Цахимжуулалтыг нэвтрүүлж, малын бүртгэл болон хүнсний хяналтын үр дүнтэй ажиллагааг цахим системээр сайжруулах. Гарал үүслээс эхлээд нийлүүлэгч, худалдан авагчдын бүрэн мэдээллийг интернэттэй болон интернэтгүй үед системд нэгтгэх бөгөөд оролцогч талуудын мэдээллийн давхардлыг арилгах, аливаа хамтрал, хоршооны мэдээллийг нэгтгэх, механик алдааг бууруулах, нийлүүлэлтийн сүлжээний мэдээллийг бүрэн нэгтгэх.
- Орон нутгийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор сум, баг, хоршооны түвшинд хяналтын тогтолцоог бэхжүүлэх.
- Малчдын хариуцлагыг дээшлүүлэхийн тулд бэлчээрийн ашиглалтад хувийн өмчийн зохицуулалт нэвтрүүлэх, өрхийн түвшний хяналтын механизмыг хөгжүүлэх.

5. Орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх

- Хөдөө аж ахуйн бодлогыг нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг бүрдүүлэх.
- Орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах сургалт, техникийн дэмжлэг үзүүлэх.

6. Шуурхай, үр ашигтай зохицуулалт бий болгох

- Цахим засаглал, ухаалаг технологи ашиглах
- Хөдөө аж ахуйн салбарт төрийн үйлчилгээ, дэмжлэгийг цахим хэлбэрт шилжүүлж, зөвшөөрөл, бүртгэл, тайланг онлайн хэлбэрээр хүлээн авах.
- Газар тариалан, мал аж ахуйн бүртгэлийг сайжруулах, цахим хяналтын систем хөгжүүлэх.

7. Хувийн хэвшил, төрийн түншлэлийг нэмэгдүүлэх

- Төр-хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийг хөгжүүлж, дэд бүтэц, ложистик, хүнсний сүлжээг сайжруулах.
- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрүүдийг дэмжиж, нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэх.
- Төрийн дэмжлэг, зээлийн хүртээмжийг зөвхөн томоохон аж ахуйн нэгжүүдэд бус, жижиг, дунд фермерүүд, өрхийн аж ахуй эрхлэгчдэд тэгш хүртээх.
- Малчид, тариаланчид, боловсруулах үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх.
- Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй иргэдийн ур чадвар, боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

8. Ногоон, тогтвортой хөгжлийг дэмжих

- Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тогтвортой байдлыг харгалзан үзэж бодлого боловсруулах.
- Усны хэмнэлттэй технологи, нөхөн сэргээгдэх эрчим хүчийг хөдөө аж ахуйн салбарт өргөнөөр нэвтрүүлэх.

9. Олон улсын туршлагаас суралцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Хөгжингүй орнуудын шилдэг туршлагыг нутагшуулах, Европын холбоо (EU), АНУ, Япон, Солонгос зэрэг орнуудын хөдөө аж ахуйн бодлого, технологийн шинэчлэлээс суралцах
- FAO, OECD, WTO зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөмж, судалгаанд үндэслэн бодлогоо боловсронгуй болгох.

10. Экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлэх

- Гадаад зах зээлд өрсөлдөхүйц хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах.
- Олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Зах зээлийн судалгаа хийх: Монголын хүнсний бүтээгдэхүүн аль улс, бүс нутагт илүү эрэлттэй байгааг тогтоож, экспортын стратегиа оновчтой тодорхойлох.
- Гол экспортын бүтээгдэхүүнийг тодорхойлох: Мах, сүүн бүтээгдэхүүн, зөгийн бал, органик бүтээгдэхүүн зэрэг дэлхийд өрсөлдөхүйцэкспортын бүтээгдэхүүнийг то
- Гарал үүслийн бүртгэл, баталгаажуулалтыг сайжруулах
- Бүс нутгийн тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэх

___o0o___

Ашигласан эх сурвалж

1. Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2023 он, Үндэсний статистикийн хороо, https://www.1212.mn/mn;
2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол болон мал аж ахуйн салбарын зарим хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2024 он, Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб ТББ;
3. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” Үндэсний хөтөлбөрийн үр дүнгийн тайлан. Монголбанк, 2025 он
4. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмж. Монголбанк, 2025 он
5. Principles for responsible investment in agriculture and food systems. FAO 2014
6. Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл-2024
7. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” https://legalinfo.mn/mn/detail/15584
8. УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311
9. УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759684400981
10. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч газраас 2025 оны 4 дүгээр сарын ...-ны өдөр ирүүлсэн УИХ-ын 36, 63, ЗГ-ын 166 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;
11. ЗГ-аас 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр өргөн барьсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан” болон “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан” https://d.parliament.mn/tusul/b9631f9b-c2cf-46b4-af62-3108224f146c
12. Сангийн яамнаас 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр нийтэлсэн “Засгийн газраас татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох багц хуулийн төсөл” https://mof.gov.mn/article/entry/tatvar
13. ХХААХҮЯ-наас боловсруулсан 2022 оны жилийн эцсийн, 2023 оны хагас жилийн, 2024 оны хагас жилийн байдлаарх “Хүнс, хөдөө аж ахуй̆, хөнгөн үйлдвэрий̆н салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол ший̆двэрий̆н хэрэгжилтий̆н явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хий̆сэн тай̆лан”, https://mofa.gov.mn/activity/assessment
14. ХХААХҮЯ-наас боловсруулсан “Хүнс, хөдөө аж ахуй̆, хөнгөн үйлдвэрий̆н яамны 2022 оны үйл ажиллагааны үнэлгээний̆ тай̆лан” https://mofa.gov.mn/activity/assessment
15. ХХААХҮЯ-наас боловсруулсан “Хүнс, хөдөө аж ахуй̆, хөнгөн үйлдвэрий̆н салбарын стратеги төлөвлөгөө”-ний̆ 2021-2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хий̆сэн тухай̆” https://mofa.gov.mn/activity/assessment
16. “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, “Байгал орчин болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө”, 2024 он https://lcp.mn/page/detail/9

МОНГОЛ УЛСАД ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ ХАНГАМЖ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН БҮХИЙ ГОЛЛОХ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)

Яам нь Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг төлөвлөх, төсөл боловсруулах, хуульд заасны дагуу хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлого, нэгдсэн чиглэл, удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, тэдгээрийн харилцан уялдааг зохицуулах ба хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.[24]

ХХААХҮЯ-ны Эрхэм зорилго.

“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх

Стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үндсэн зорилт, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр нөлөөг нэмэгдүүлж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, хүн амын хүнсний аюулгүй байдал, хангамж, чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, мэдээ, мэдээлэл, дэмжлэг, салбарын төсөв, улсын болон орон нутгийн өмчийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, шуурхай байлгахад оршино.

[24] ЗГ-ын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 43 тогтоол “Тогтоолд өөрчлөлт оруулах, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”

Тус яам нь доорх зурагт харуулсанчлан 10 газар, 3 хэлтэстэй. 2022 оны эцсээр МХЕГ (Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар) татан буугдсанаар ХХААХҮ-ийн салбарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ба Салбарын хяналтын газар шинээр байгуулагдсан байна.



Эх сурвалж: ХХААХҮЯ-ны цахим хуудас

2. Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)

ЭЗХЯ-ны Эрхэм зорилго

Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь шинжлэх ухааны нотолгоонд суурилан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, инновац, технологи, хувийн хэвшилд суурилсан төрөлжсөн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн чадавхыг сайжруулж, хүртээмжтэй болгох, бизнесийн эрх чөлөөг тогтвортой хангахад оршино.
Тус яамны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хувьд- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах; Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, ногоон санхүүжилтийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх; Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, зэрэг ажлууд багтдаг байна.[25]

ЭЗХЯ нь хуучин ҮХГ-ын болон (Үндэсний Хөгжлийн Газар) Сангийн Яамны зарим чиг үүргийг нэгтгэснээр 2022 оны 1 сард байгуулагдсан. Нийт 9 газар 18 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна.

[25] https://med.gov.mn/goals



Эх сурвалж: ЭЗХЯ-ны цахим хуудас

3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) нь Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг хариуцдаг төв байгууллага юм.

Эрхэм зорилго: БОУАӨЯ-ны эрхэм зорилго нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлүүд:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх
- Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх стратеги боловсруулах, хэрэгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицох арга хэмжээ авах
- Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах

БОУАӨЯ нь олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

4. Стандартчлал, хэмжил зүйн газар (СХЗГ)

СХЗГ-ны Эрхэм зорилго

Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэмжил зүй, стандартчилал, сорьцын хяналт, тохирлын үнэлгээний бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг

үзүүлж, чанартай төрийн үйлчилгээг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөд тулгуурлан хэрэглэгчдээ хүргэхэд оршино.


Тус газар эрхэм зорилгынхоо хүрээнд Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх явдлыг стратегийн зорилго болгон ажилладаг байна.[26]

Шийдвэр гаргах байгууллага нь СХЗГ-ын Үндэсний Зөвлөл бөгөөд зөвлөл нь яам агентлагууд, ТББ, шинжилгээ судалгааны байгууллагуудын төлөөллөөс бүрддэг. СХЗГ нь Монгол Улсын стандартын хэрэгжилтийг хянах, нийгмийн янз бүрийн үйл
ажиллагааг стандартад нийцүүлэхэд удирдан чиглүүлэх байгууллага бөгөөд, төрийн болон шинжилгээний байгууллагууд, гадна дотны олон нийтийн байгууллагууд, хувийн хэвшлийн ААН-үүдэд чиглэж өргөн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг.[27]

Тухайлбал, тус газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд Хэмжил зүйн тухай хууль, эрх зүйн орчинг олон улсын жишиг, улс орны нийгэм эдийн засгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох санал боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, хэмжлийн эталоныг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх ажилтны чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх олгох, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг хөтлөх, улсын эталон, стандартчилсан загварыг бий болгох, зохион бүтээх, хадгалах, харьцуулан дүйлгэж баталгаажуулах, хэмжил зүйн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт хийх, улсын эталоны нэгж дамжуулалтыг олон улсад болон үндэсний хэмжээнд хангах, өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх, хэмжил, шалгалт тохируулгын чадавхыг Жин, хэмжүүрийн олон улсын байгууллагын мэдээллийн санд бүртгүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулах, боловсронгуй болгох, хэмжлийн нэгжийн эталоны ашиглалт, хөтлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг эталоны нэгдсэн лаборатори, секторын тогтолцоонд үндэслэн хийх, хэмжил зүйн олон улсын байгууллага, хэлэлцээрт нэгдэн орох, тэдгээртэй хамтран ажиллах чиг үүрэг хэрэгжүүлэх зэрэг стандарт хэмжил зүйн өргөн хүрээний үйл ажиллагаа хамаардаг.

[26] https://www.masm.gov.mn/website/page.aspx?mm_id=9&id=25

[27] Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл-2024



5. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл (ХАБҮЗ)

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Энэхүү зөвлөлийн үйл ажиллагааг Засгийн газрын 2013 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм" зохицуулдаг. Энэхүү зөвлөл нь Ерөнхий сайдын харьяанд байдаг бөгөөд Үндэсний зөвлөлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Зөвлөлийн дарга Монгол Улсын Шадар сайд, Орлогч дарга: Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, гишүүд: Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл багтдаг бөгөөд орон тооны нарийн бичгийн даргатай. Өмнө нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /МХЕГ/ тус зөвлөлд багтаж, яам агентлагуудын тогтолцоонд үндэслэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байсан бөгөөд одоо татан буугдсан байна. Хяналтын чиг үүргийн нэгжүүд холбогдох яамдын бүтцэд шилжин орж, ХАА-н салбарын хяналтын чиг үүрэг мөн ХХААХҮЯ-ны харьяанд шилжиж, Салбарын хяналтын газар хариуцах болсон. ЭМЯ-ны Салбарын хяналтын газар нь хүнсний бизнес эрхлэгчдийн дагаж мөрдөх ёстой GMP, GHP-ийг хариуцаж, ЗГХЭГ-ын даргын дэргэд ЗГ-ын дотоод хяналт шалгалтын агентлагийг байгуулж, хяналт зохицуулалтыг хийж эхлээд байна. Мөн аймаг бүрт ажиллаж байсан МХЕГ-ын байцаагч нарыг холбогдох газруудад шилжүүлсэн.

Үндэсний зөвлөлийн гол чиг үүрэг:

- Хүнсний хангамж, үнийн өсөлт, хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт зэрэгтэй холбоотой судалгаа хийлгэж, дүнг хэлэлцэн зөвлөмж гаргах,
- Хүнсний аюулгүй байдалд эрсдэл үүссэн тохиолдолд холбогдох байгууллагуудад чиглэл өгөх, хот, суурин газрын ойролцоо хөгжүүлэх эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хүнс, хоол үйлдвэрлэлийн газрын ойролцоо хөгжүүлэх асуудлаар зөвлөмж гаргах,
- Хүнснээс шалтгаалах өвчин, хүнсний бохирдолтой холбоотой судалгаа хийлгэж, дүнг хэлэлцэн зөвлөмж гаргах,

- Тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаар санал хэлэлцэж, зөвлөмж гаргах.

2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хуралдаан болж дараах асуудлаар зөвлөмж гаргасан.

1. Бүх төрлийн малын махны экспорт, импортод 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байх;
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Цагааннуур, Боршоо, Арцсуурь боомтоор улаанбуудайн баяжуулсан болон баяжуулаагүй гурилыг, бусад боомтоор улаанбуудайн баяжуулсан гурилыг тус тус импортлох
3. Мах, махан бүтээгдэхүүний экспортын зах зээлийг тэлэх зорилгоор худалдааны түнш орнуудтай дотор мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох үеийн мал эмнэлэг, хорио цээр, ариун цэврийн шаардлагын тухай протокол тохирох ажлыг эрчимжүүлэх талаар зөвлөмж гаргаж, холбогдох сайд, агентлагийн дарга нарт хүргүүлжээ [28]

Эх сурвалж: Хүнсний хувьсгал цахим хуудас

[28] https://hunsniihuvisgal.mn/post/97701

Хавсралт 2

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэгч газрын тайлан

Улсын Их Хурлын 2022-06-17-ны өдрийн 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" (2024 оны жилийн эцэс)

№	Заалтын дугаар	Заалтын агуулга	Тайлагнах байгууллага	Заалтын биелэлт	ЗГХХГ-ийн үнэлгээ
1	1/а	хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Сангийн яам, Монголбанк, ХХААХҮЯам хооронд байгуулсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу 2024 онд нийт 449.3 тэрбум төгрөгийн зээл олгохоос 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар банкуудад 400.5 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр батлагдаж, үүнээс 377.0 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Үүнээс 193.2 тэрбум төг нь эргэлтийн хөрөнгийн чиглэлээр, 183.9 тэрбум төг нь хөрөнгө оруулалтын чиглэлээр олгосон байна. Үүнд: - Газар тариалангийн чиглэлээр 936 иргэн, аж ахуйн нэгжид 148.0 тэрбум төгрөг, - Мал аж ахуйн чиглэлээр 25 иргэн, аж ахуйн нэгжид 45.0 тэрбум төгрөг, - Хүнсний боловсруулах болон сав баглаа боодлын үйлдвэрлэлийн чиглэлээр 204 аж ахуйн нэгжид 183.0 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгоод байна.	70.0
2	1/б	энэ тогтоолын хавсралтад заасан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн 6 хуулийн төслийг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахаар тусагасан хэдий ч 2024 онд 1 хууль шинэчлэн батлуулсан байна.	0.0
3	1/в	тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхээр “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” улсын их хурлын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төсөл, холбогдол судалгааг боловсруулсан. Тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотой уг тогтоолын үзэл баримтлалын төслийг дахин батлахаар ажиллаж байна.	30.0
4	1/г	хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2022-2023 онд хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байхаар заасан ч тогтоосон хугацаанд хэрэгжээгүй байна. Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгохтой холбоотой асуудлыг зохицуулахаар хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл болон дагалдан гарах хууль тогтоомжийн төслийг Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран боловсруулж, үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар ажиллаж байна. Үзэл баримтлалын төсөлд хүнсний хангамжийг оновчтой зохион байгуулах, сургуулийн хоолны норматив зардлыг бусад эх үүсвэрээр нэмэгдүүлэх, туслах аж ахуйгаас бэлтгэсэн хүнсийг сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой орон нутгийн шийдвэр гаргах эрхийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хамруулан боловсруулсан.	0.0

5	1/д	хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг шинэчилж, шинээр батлах; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Стандарт, хэмжил зүйн газар	Тайлант хугацаанд 28143 дээжид 157180 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1544 байгаа нь нийт үзүүлэлтийн 0,98 хувийг эзэлж байна. Мөн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн С/07 дугаартай тушаалаар дараах олон улсын стандартыг баталсан. Үүнд: -“MNS CAC RCP 61:2023, Хүнсээр дамждаг бичил биетний тэсвэржилтийг хамгийн доод түвшинд хүртэл бууруулах, хязгаарлах дадлын дүрэм” Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн С/53 дугаартай тушаалаар дараах стандартыг баталсан. Үүнд: -MNS CAC GL 71:2023, Хүнсний зориулалтын мал амьтанд малын эм бэлдмэл хэрэглэхтэй холбоотой хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах үндэсний хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх удирдамж -MNS CAC RCP 1:2023, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн С/11 дугаартай тушаалаар дараах стандартыг баталсан. Үүнд: -MNS CAC GL 63:2024, Микробиологийн эрсдэлийн менежментийн зарчим, удирдамж -MNS CAC RCP 54:2024, Мал, амьтны тэжээл, тэжээллэгийн зохистой дадлын дүрэм.	70.0
6			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	"Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/165 дугаар тушаалаар баталсан.	
7	1/е	мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг малчны хотноос эхлээд эцсийн хэрэглэгчийн гар дээр тавих хүртэл алхам бүрд хийгдсэн үйл ажиллагааг мэдээлэл технологид суурилсан баталгаажуулалтад үндэслэн бэлчээрийн төлөв байдал, малын тавлаг байдал, эрүүл мэнд, малын гаралтай түүхий эдийн чанар зэрэг үзүүлэлтүүдийг харуулсан, малчдаас авах түүхий эдийн тогтвортой, хариуцлагатай байдлыг стандартчилснаар малчид, БАХ-үүд бэлчээрийн тогтвортой байдал, бэлчээрийн менежментийн дадлуудыг нэвтрүүлж, хамгийн сайн чанарын малын гаралтай түүхий эдийг (сарлагийн хөөвөр, торомны ноос, ноолуур, арьс, шир, мах) бий болгож, улмаар эдийн засгийн урамшуулал хүртдэг “Хариуцлагатай малчин”-г бий болгох "Хариуцлагатай нүүдэлчид" системийг нэвтрүүлсэн. Энэ системийг хамтран хэрэгжүүлэхээр “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд” MNS 6891:2020 стандартын хүрээнд тохирлын үнэлгээний ажлыг гүйцэтгэх, хэрэгжилтэд хяналт тавих хамтран ажиллах гэрээг Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой байгуулахаар гэрээний төслийг боловсруулсан. “Хариуцлагатай нүүдэлчид”- Малын гаралтай бүтээгдхүүний мөшгих тогтолцооны стандарт, холбогдох журмыг боловсруулахад санал өгч ажилласан. "Хариуцлагатай нүүдэлчид" системд нийт 18 аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо, 156 сумын бэлчээр ашиглагчдын холбоо, 1445 БАХ-ийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Мөн 82 түүхий эдийн анхан шатны хоршоо, 6 дундын хоршоо, 20 хадгаламж зээлийн хоршоодын мэдээлэл бүртгэгдсэн байна.	30.0
8	1/ж	хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг боловсруулан батлах; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	"Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам"-ын төслийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Журам батлах тухай" 344 дүгээр тогтоолыг батлуулсан.	100.0

9	1/ж	хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Ерөнхийлөгчийн тамгын газрын дэргэдэх эрдэмтэдийн зөвлөлийн ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжүүлэх ажлын 39 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан Улсын Их Хурал, ЕТГ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ЭМЯ-ны төлөөллийг оролцуулсан үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгээс гарсан төлөвлөгөө, зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж, зөвлөмж, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Монгол улсын Ерөнхий сайдын 2024 оны 136 дугаар захирамжаар батлуулсан. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/182 дугаар тушаалаар "Малын эмийн үлдэгдэлийг хяналтын хөтөлбөр", А/141 дүгээр тушаалаар "Жорор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журам" боловсруулах ажлын хэсгийг байгуулж, хөтөлбөр, журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт MNS CAC 193:2007 стандартад заасны дагуу хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металийн агууламжийг лабораторийн шинжилгээгээр тогтоож байна.	70.0
10	1/и	хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Азийн хөгжлийн банкны бүцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Ковид-19 цар тахлын дараах орчинд Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” ТА-10099 техник туслалцаа (ТТ)-ны төслийн хүрээнд хийгдэх Хүнсний баталгаат байдлын мэдээлэл, хариу арга хэмжээний нэгдсэн системийг боловсруулахад хамтран ажиллах, тус систем ашиглалтад орсны дараа хариуцан ажиллах үүрэг бүхий Техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус бүрээс гарах шаардлагатай тайлан мэдээллийн талаар 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцэж, санал солилцсон. Азийн хөгжлийн банкны Хүнсний баталгаат байдлын мэдээлэл, хариу арга хэмжээний нэгдсэн систем (IFSIRS)- хүрээнд Хөрөнгө оруулалтын мэдээллийн сан байгуулах ажлын хэсэгт холбогдох мэдээллийг боловсруулж хүргүүлсэн.	30.0
11	1/к	хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын татаас, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт бүрэн тусгаж, хэрэгжүүлж байх. (1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгож байгаа урамшууллыг цахимжуулж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн “Төсвийн урамшууллын систем”-ийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг хийж, Газар тариалангийн болон МАА системтэй холбон, малчид, тариаланчид урамшуулалд хамрагдах хүсэлтэй и-баримт, гарал үүслийн гэрчилгээг үндэслэн цахимаар хүсэлт гаргах нөхцлийг бүрдүүлэн 2023 оноос нэвтрүүлж эхлээд байна. Хоршооны гишүүн малчинд олгосон зээлийн хүүгийн дэмжлэгт 25,090.87 сая төгрөг, Зудын гамшигт нэрвэгдсэн малчдын зээлийн хүүгийн дэмжлэгт 74,732,.85 сая төгрөгийг тус тус холбогдох тушаал шийдвэрийн дагуу санхүүжүүлсэн.	70.0
12	2/а	"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг урт хугацаатай, хүү багатай эх үүсвэрээс санхүүжүүлэх, улсын болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Сангийн яам, Монголбанк, ХХААХҮЯам хоорондбайгуулсан “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу 2024 онд нийт 449,3 тэрбум төгрөгийн зээл олгохоор арилжааны 10 банктай эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулсан ба 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар банкуудад 400.5 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр батлагдаж, үүнээс 377.0 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.	70.0

13	2/б	"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Засгийн газраас батлан улс орон даяар "Эх орны эрүүл хүнс" уриан доор хэрэгжүүлж байгаа "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-тай уялдуулан хэрэгжүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Газар тариалангийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцан ажиллаж, нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулан хэрэгжилтийг дгнэж ажиллаж байна. Тариалангийн үйлдвэрлэлд олсон амжилтыг тогтворжуулан баталгаажуулах, шинээр дэвшилтэт технологи, туршлагыг судлан нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, тариалнчдыг урамшуулах, олон нийтэд амжилтыг сурталчлахад удирдлагын манлайллыг чиглүүлдэг ажлын ололт амжилтыг дүгнэсэн Ургацын баярыг тэмдэглэж ололт амжилт сургамжийг дүгнэсэн. Тариалалт, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангахын тулд технологийн зөвлөгөөн зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлсэн. Атар 4 газар тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хоёрдахь үеийг эхлүүлэхээр төлөвлөгөөний төслийг гарган танилцуулсан. Эхний үе шат 2020-2026 он хүртэл үргэлжилж байна. Улаанбуудайгаар дотоодын хэрэгцээг бүрэн, төмсөөр 120 хувь, хүнсний ногоогоор 96 хувь хангаж байна.	30.0
14	2/в	хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсанаас хойш буюу 2022 онд 2 судалгааны ажлыг 310 сая, 2023 онд 1 ажлыг 180 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Үүнээс үзвэл, салбарын эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсөв 2017 онтой харьцуулбал 6 дахин буурсан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнд бий болсон инновацын бүтээгдэхүүн үйлчилгээг салбарт хөрөнгө оруулж, бизнес эрхэлж буй үйлдвэрлэгчид, хувийн хэвшлийн төлөөллүүдэд танилцуулах, хамтын ажиллагааны боломж бий болгож, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад зориулагдсан “Инновацын 7 хоног-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд "Agri show" арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Орхон аймгийн ЗДТГ-ын А.Амарын танхимд зохион байгуулав.Тайлант үеийн байдлаар тус хуудсанд 10 гаруй контент оруулж нийт 10,500 гаруй хүний хандалт авсан байна. Цаашид энэ хуудсыг тогтмол хөтөлж хөдөө аж ахуйн салбарын инновац, хөрөнгө оруулалт, бизнесийн мэдээ мэдээллийг оруулж байх нь зүйтэй гэж үзсэн. Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 206 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хүнсний судалгаа инновацын нээлттэй төвийг түшиглэн "Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн"-г байгуулахаар шийдвэрлэсэн.	70.0

15	2/г	мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 206 дугаар тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хүнсний судалгаа инновацын нээлттэй төвийг түшиглэн "Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн"-г байгуулахаар шийдвэрлэсэн. “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ-ын Баталгаажуулалтын алба нь 2024 онд нийт 5 хоршооноос тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлт авсан байна. Эдгээр 5 хоршоотой тохирлын үнэлгээ хийх гэрээ байгуулан, 3 хоршоонд хөндлөнгийн үнэлгээ баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж 3 хоршооны үнэлгээний тайланг баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2 хоршоонд тохирлын гэрчилгээ олгосон. 2 хоршооны үнэлгээний үйл явц үргэлжлэн хийгдэж байна. Нийт 20 сумын 20 хоршооны 700 малчин өрх баталгаажуулалтад хамрагдаад байна. Төрийн үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлэх Засгийн газрын 2022 оны 340 дугээр тогтоолын дагуу Газар тариалангийн үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэгдсэн ЭС ЭФ СИ ЭС ХХК, Хүнсний аюулгүй байдал ХАА-н зохистой дадал ТББ-ууд хүн, хуулийн этгээдэд тодорхой төлбөрийн нөхцөлтэйгээр үйлчилгээ үзүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А-166, А/251 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар зохистой дадал нэвтрүүлэх зааврыг баталж Газар тариалангийн үйлдвэрлэлд зохистой дадлыг нэвтрүүлж ажилласан 2019-2024 оны хооронд нийт 89 аж ахуйн нэгжид зохистой дадал нэвтрүүлсэн гэрчилгээ олгосон тус яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.	70.0
16	2/д	хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт орж хяналт хүнсний үйлдвэрлэл, худалдааны хяналт шалгалтын чиг үүрэг ХХААХҮЯ-нд шилжин ирснээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн бодлоготой уялдуулан хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Цаашид экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл олгох ажлыг Гаалийн байгууллагаас шилжүүлэн авах ажил хийгдэж байгаа бөгөөд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн дотоод, гадаад худалдаа, үйлдвэрлэлийг цогцоор хянах тогтолцоо ХХААХҮЯ-д төвлөрч нэгдсэн бодлоготойгоор хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна /ажлын хэсгийн тушаал хавсаргав/. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад тавих хяналтыг сайжруулах зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2024 оны А/149 дүгээр тушаалаар “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээг 03-06-р сард хэрэгжүүлж, хяналт шалгалтын үр дүн, сэрэмжлүүлэг мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан /нэгдсэн тайланг хавсаргав/.	30.0
17	2/е	хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрийн өмчит их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, сургалтын чанарыг сайжруулах, эдгээр салбарт тэргүүлэх чиглэлээр суралцагчид сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, мэргэшсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан жил бүрийн намрын ургац хураалтын үйл ажиллагаанд оюутан залуусын оролцоог идэвхжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуульд хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөнд тодорхой кредит цагийг тусгах замаар шийдвэрлэх саналыг БШУЯ, ХААИС-д Сайдын "Хамтран ажиллах тухай" 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1382 тоот албан бичгээр хүргүүлэв. Их, дээд сургуулийн бүтэц, орон тоогт шинэчлэх асуудал нь Боловсролын яамны чиг үүрэгт хамаарна. Хасах санал: хяналтаас хасуулах манай яамны чиг үүрэгт хамааралгүй	30.0

18			Боловсролын яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрийн өмчит их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор (1) Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургуулийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль болон (2) Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийг нэгтгэн зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор (1) Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг нэгтгэн Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехникийн коллеж, (2) Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг нэгтгэн Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж, (3) Төв аймгийн Заамар сум дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Төв аймаг дахь Политехник коллеж болгон өөрчлөн зохион байгуулсан.Мэргэжлийн болон техникийн боловсролын 69 сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд нийт 40,906 суралцагч суралцаж байна. Үүнээс 5,211 буюу 12,7 хувь нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын нийт 17 хөтөлбөрөөр суралцаж байна.	
19	2/ж	хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Эрчим хүчний яам	Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэрээс хангах талаар хангагч байгууллагуудад үүрэг даалгаврыг өгч ажиллаж байгаа бөгөөд хүсэлт гаргасан хүлэмжийн аж ахуй бүрийг шаардлагатай эрчим хүч, уур, дулаанаар ханган ажиллаж байна. Мөн 2023 онд эрчим хүчний сайдын 2023 оны А/33 дугаар тушаалаар өвлийн хүлэмжийн аж ахуйн цахилгааны хөнгөлөлтийн санхүүжилтэд 550 сая төгрөгийг баталсан бөгөөд санхүүжилтийг хуваарийн дагуу олгосон. 2024 онд өвлийн хүлэмжийн аж ахуйн цахилгааны хөнгөлөлтийн санхүүжилтэд 728 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэл гарах хугацаа болоогүй байна. Хасах санал: Дотоод хяналтад авч тогтмолжсон арга хэмжээ тул хяналтаас хасуулах саналтай байна.	100.0
20			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	"Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолд "Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын 2 дахь заалтын "11 дүгээр сарын 1-нээс" гэснийг "10 дугаар сарын 15-наас" гэж, "22:00 цагаас" гэснийг "18:00 цагаас" гэж тус тус өөрчилсөн тул хөнгөлөлтэд хамрагдах эрх зүйн үндэслэл үүссэн. Үүнтэй холбогдуулан 2023 онд шинээр өвлийн хүлэмж байгуулсан 93 иргэн, аж ахуйн нэгжийн 26.2 га талбай бүхий хүлэмжийг цахилгааны хөнгөлтөд хамруулахаар Эрчим хүчний яаманд уламжилсан.	

21	2/з	монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1.“Монгол зоог, ундааг тогтвортой хөгжүүлэх нь” арга хэмжээг Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв ГҮТББ-тай хамтран 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр UG Palace-д зохион байгуулав. 2.Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжиж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн хүрээнд малын дотор махны үнэт чанарыг таниулах, хэрэглээний уламжлалыг хадгалах, нөөцийн ашиглалтыг сайжруулан үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг хийж байна. “Малын мах, дотор мах: Хэрэглээний уламжлал ба шинэчлэл” болон цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор дотор махан хоолны цэс бүхий номыг гарган цэцэрлэг, сургуулийн тогооч нарт сургалт явуулж байна. 3.ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцын Засгийн газар хоорондын хорооны 14 дүгээр ээлжит чуулганаар “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэх шийдвэрийг гаргаж, Монгол Улсаас тус өвийн жагсаалтад бүртгүүлсэн 15 дахь өв болсон. 4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас уг арга хэмжээг дэмжин, хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр хэрэглэгчдэд хүргэх зорилгоор “Айраг фестиваль - 2024” 15 дахь удаагийн арга хэмжээний хүрээнд айраг, сүү, цагаан идээний сав суулганы үзэсгэлэн худалдааг Монголын Сав Баглаа Боодол Үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгууллаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв нь уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох инкубаторт бойжигч компаниудтай инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан	100.0
22	2/и	хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэхээр нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжид татварын болон бусад дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Төмс, хүнсний ногоо тариалах, фермерийн аж ахй хөгжүүлэхэд тариалангийн газар олгох, үрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж бөгөөд аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд оруулсан. ЖДҮХСанд зээлийн эргэн төлөлт болон орон нутгийн төсвөөр батлагдсан эх үүсвэрт төсөл хүлээн авахад Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Орхон аймагтай хамтран ажиллах гэрээний дагуу орон нутгийн төсвийн 5,8 тэрбум төгрөгийг Завхан аймагт 1,5 тэрбум төгрөгийн 13 төсөл, Өмнөговь аймагт 2,0 тэрбум төгрөгийн 13 төсөл, Сүхбаатар аймагт 1,6 тэрбум төгрөгийн 12 төсөл Орхон аймагт 0,6 тэрбум төгрөгийн 4 төсөл дэд хорооны шатанд тэнцэж, 155 ажлын байрыг хадгалж, 223 ажлын байрыг шинээр нэмэгдүүлснээс гадна орон нутагт шилжин суурьшсан 11 ААНБ-д 1,2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн “шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай Засгийн Газрын 166 дугаар тогтоол батлагдан 21 аймаг 330 сумдад хоршооны сургагч багш бэлтгэн ажлуулж 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар шинээр 2500 орчим хоршоо шинээр байгуулагдаж 3681 хоршоо байгуулахаар нэрээ авсан бөгөөд улсын хэмжээнд 25900 гаруй малчин хоршооны гишүүнээр элсээд байна. 256 хоршооны зээл арилжууны банкуудад судлагдаж байгаагын 157 хоршооны зээлийн шийдвэр гарч 21.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон байна.	70.0

23	2/к	Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх; (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	“Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” аяны хүрээнд 3 байгууллагаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлсэн. Аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжэээнүүд: - 2024.06.12-06.16-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд үзэсгэлэн худалдаа болон Брендинг, орон нутгийн бренд хэрхэн бий болгох, хөгжүүлэх сэдэвт сургалтыг зохион байгуулсан. - Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний танилцуулга бэлтгэн хэвлүүлэв. - 21 аймгийн онцлох бүтээгдэхүүний цахим каталогийн зураг авалтад нийт аймгийн 100 гаруй ААН-ыг хамруулж олон нийтэд сурталчлах ажлыг гүйцэтгэсэн байна.Жижиг дунд бизнесийн хөгжил ба санхүүжилтийн боломж сэдэвт сургалтыг Архангай аймагт зохион байгуулж, ЖДҮЭрхлэгч 100 гаруй бизнес эрхлэгч хамрагдаж Монголбанк, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Жижиг дунд үйлдвэрийн газар мэдээлэл, зөвлөгөө өгч оролцсон. - Тэгш эрх зөв хэмнэл” НҮТББ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газартай байгуулсан гэрээний үүргийн хүрээнд Бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн өдөрт зориулсан үзэсгэлэн худалдаа, “Нэг суурин- Нэг бүтээгдэхүүн” аяныг олон нийтэд сурталчлан мэдээ, сайтад сурвалжилга, ярилцлага, тодруулга мэдээ, видео рийл зэргийг бэлтгэн тодорхой давтамжтай, олон нийтэд түгээсэн байна. - Цахим экспо ХХК-тай хамтран 2024 оны Цагаан сарын баярыг тохиолдуулан үндэсний үйлдвэрлэгч, үндэсний брендүүдийг нэг дор байршуулан борлуулалтыг нэмэгдүүлэх, маркетинг сурталчилгааны дэмжлэг үзүүлэх зорилгоор ждүү эрхлэгч 10 ХХК-ийн бараа бүтээгдэхүүний үнэ ханш, зураг, тайлбар мэдээллийг Expo.mn платформ дээр байршуулан ажилласан.	70.0
24	2/л	хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хүрээлэнгээр захиалгат судалгаа, туршилтын ажил хийлгэх хөрөнгийг нэмэгдүүлэх. (2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:)	Эдийн засаг, хөгжлийн яам	Хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, ШУТИС-ийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, ШУА-ийн Хими, Химийн технологийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудын гүйцэтгэж буй ХХААХҮЯ-ны захиалгат шинжлэх ухаан, технологийн 4 төсөл хэрэгжиж байна. Эдгээр төслүүдэд нийт 670.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	70.0
25			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнд бий болсон инновацын бүтээгдэхүүн үйлчилгээг салбарт хөрөнгө оруулж, бизнес эрхэлж буй үйлдвэрлэгчид, хувийн хэвшлийн төлөөллүүдэд танилцуулах, хамтын ажиллагааны боломж бий болгож, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад зориулагдсан “Инновацын 7 хоног-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд "Agri show" арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Орхон аймгийн ЗДТГ-ын А.Амарын танхимд зохион байгуулав. Тус арга хэмжээний мэдээллийг салбарынхан болон олон нийтэд хүргэх, нэгдсэн мэдээллээр хангах зорилгоор ХХААХҮ-н салбар дахь Инновац ба Хөрөнгө оруулалт фэйсбүүк хуудсыг нээж 1 сарын турш хөтөлж, мэдээ мэдээлэл оруулсан. Тайлант үеийн байдлаар тус хуудсанд 10 гаруй контент оруулж нийт 10,500 гаруй хүний хандалт авсан байна. Цаашид энэ хуудсыг тогтмол хөтөлж хөдөө аж ахуйн салбарын инновац, хөрөнгө оруулалт, бизнесийн мэдээ мэдээллийг оруулж байх нь зүйтэй гэж үзсэн.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн эрдэмтэн, судлаач мэргэжилтнүүд 2018-2023 он хүртэл хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн 14 төсөлд зохих шаардлагын дагуу үнэлгээ хийж, үнэлгээний нэгтгэлийг ХХААХҮЯ-ны хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллахын зэрэгцээ төслийн хамгаалалтын хурлыг зохион байгуулж ажилласан.	

26	3/а	тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 5000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Тариаланд ашиглах боломжтой атар болон атаршиж орхигдсон газрын судпалгааг 2023 онд Төв, Булган аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар Төв аймгийн нийт 10 сумын хэмжээнд нийт 27942.27 га атаршсан талбайд 71 цэгт 0-20 см, 20-40 см гүнд дээж авч хөрсний химийн болон, хөрсний механик бүрэлдэхүүнийг шинжлүүлсэн. Хөрсний хими-физик шинж чанарын үнэлгээгээр Төв аймгийн хэмжээнд 12778.11 га талбай тохиромжтой, 15164.16 га талбай хязгаарлагдмал тохиромжтой байна. Булган аймгийн нийт 5 сумын хэмжээнд нийт 16476.57 га атаршсан талбайд 27 цэгт 0-20 см, 20-40 см гүнд дээж авч хөрсний химийн болон, хөрсний механик бүрэлдэхүүнийг шинжлүүлсэн. Хөрсний хими-физик шинж чанарын үнэлгээгээр 117.61 га талбай нэн тохиромжтой, 88277.77 га талбай тохиромжтой, 8081.19 га талбай хязгаарлагдмал тохиромжтой байна. Дээрх судалгааг жил бүр 2-3 тариалан бүхий аймгуудад хийх бөгөөд судалгааг үндэслэн атар болон атаршсан газрын бүсчлэлийн схем боловсруулна.	0.0
27			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Булган, Төв аймгийн хэмжээнд тариаланд ашиглах боомжтой атар болон атаршиж орхигдсон газрын судалгааг Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд хийж гүйцэтгэв. Төв аймгийн нийт 10 сумын хэмжээнд нийт 27942.27 га атаршсан талбайд 71 цэгт 0-20 см, 20-40 см гүнд дээж авч хөрсний химийн болон, хөрсний механик бүрэлдэхүүнийг шинжлүүллээ. Хөрсний хими-физик шинж чанарын үнэлгээгээр Төв аймгийн хэмжээнд 12778.11 га талбай тохиромжтой, 15164.16 га талбай хязгаарлагдмал тохиромжтой байна. Төв аймгийн хэмжээнд Баянхангай сумын Шанд уул, Баянцагаан сумын Тариат, Лүн сумын Энхийн аманд усалгаатай тариалан эрхлэх боломж байна. Булган аймгийн нийт 5 сумын хэмжээнд нийт 16476.57 га атаршсан талбайд 27 цэгт 0-20 см, 20- 40 см гүнд дээж авч хөрсний химийн болон, хөрсний механик бүрэлдэхүүнийг шинжлүүллээ. Хөрсний хими-физик шинж чанарын үнэлгээгээр Булган аймгийн хэмжээнд 117.61 га талбай нэн тохиромжтой, 8277.77 га талбай тохиромжтой, 8081.19 га талбай хязгаарлагдмал тохиромжтой байна. Булган аймгийн хэмжээнд Баян-Агт сумын Цахиурын ам, Бүрэгхангай сумын Гол дагуух талбайнууд, Гурванбулаг сумын Бэрхийн ард байрлах талбайд усалгаатай тариалан эрхлэх боломж байна. Гэвч бидний судалгааны үед голууд татарч хуурай сайр болсон байв. Эдгээр талбайд усалгаатай тариалан эрхлэхийн тулд гидрогеологийн судалгаа хийлгэх, голуудын олон жилийн дундаж зэргийг нарийн тооцох нь чухал юм. Дээрх судалгааны тайланг Аймгуудын ХХААГ-т хүргүүлсэн бөгөөд бид жил бүр 2-3 аймаг сонгож атар болон атаршсан газрын судалгааг хийлгүүлж тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	
28	3/б	ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд тулгуурлан улсын хэмжээнд улаан буудайн 4, тэжээлийн 2, хүнсний ногооны 5, төмсний 4, нийт 15 үрийн аж ахуйг байгуулах, сорт сорилтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024 онд төмсний 7, хүнсний ногооны 2, улаанбуудайн 3, тосны ургамлын 5, арвай 2, малын тэжээлийн 16, цагаан будааны 6 нийт 41 шинэ сортыг шинээр дэвшүүлж, туршилт судалгааны зориулалтаар тариалж байна.	30.0
29	3/в	"Монгол Улсад газар тариалан эрхлэх систем" технологийн баримт бичгийг мөрдлөг болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах, сайжруулах, зохистой ээлжлэн тариалалт бүхий дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнд нийцсэн техник, технологийн шинэчлэл хийх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх хөрс хамгаалах, цулгуй уриншийн хэмжээг бууруулах сэлгээнд буурцагт тэжээлийн таримлыг оруулж эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйг хослон хөгжүүлэхээр тэжээл хураах комбайн, тэжээлийн таримлын зориулалттай үрлүүр, дарш бэлтгэх, зөөвөрлөх, тараах техник тоног төхөөрөмж нийлүүлэхэд дилер аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах ажлыг эхлүүллээ. Эрчимжсэн мах, сүүний 117.0 мянган толгой үхэр байгаа тул шаардлагатй тэжээлийн нөөц бүрдүүлэх техникийн шинэчлэлийг хийх боломж бүрдсэн.	30.0

30	3/г	тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйд шаардагдах дотоодын хэрэгцээт тэжээлийн хангамжийг 1.9 сая тоннд хүргэхэд зохион байгуулалт болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээлийн үйлдвэрлэл эрхэлж буй 3 компани "Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд мал аж ахуйн эрсдэлийг бууруулах малын тэжээл үйлдвэрлэл нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авахад зориулан 5 аж ахуйн нэгжид 3.0 тэрбум төгрөгийн хөнгөлттөө зээл олгов. Зээлийн үр дүнд малын холимог тэжээлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч холимог тэжээлийн үйлдвэрлэл 25-30 хувиар нэмэгдсэн. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн Малын тэжээлийн үйлдвэрлэлийн зангилаа төв байгуулах дэд төслийн хүрээнд 4.4 тэрбум төгрөгөөр Төв аймгийн Борнуур, Эрдэнэсант сум, Завхан аймгийн Тэс, Ховд аймгийн Жаргалант суманд аймаг дундын үйлчлэх тэжээлийн үйлдвэр байгуулах 4 төсөлтэй тус тус хэлцэл хийж гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.	70.0
31	3/д	хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 270 гектар хүртэл нэмэгдүүлэн хөгжүүлж, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, дулааны хангамж, дэд бүтэц бүхий бүс нутгуудад 50 гектар өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 12,9 тэрбум төгрөгөөр 2606 ширхэг хүлэмжийг худалдан авч, зуны хүлэмжийн тариалалтыг 12,4 га, өвлийн хүлэмжийн тариалалтыг 0,3 га талбайгаар нэмэгдүүлсэн. Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2023-2024 онд 26 иргэн, аж ахуйн нэгжид 14,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг олгосон. 2024 онд 39,1 га талбай бүхий өвлийн хүлэмж, 115,4 га талбай бүхий зуны хүлэмжинд нарийн ногооны тариалалт хийсэн. НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Дархан-Уул, Төв аймгуудад тус бүр 1000 мкв талбай бүхий дэвшилтэт технологийн өвлийн хүлэмж байгуулагдаж байгаа бөгөөд гүйцэтгэл 80 хувьтай байна. Азийн хөгжлийн банкны 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Улаанбаатар хотод 800 м2 дэвшилтэт технологийн хүлэмжийг байгуулж байгаа бөгөөд гүйцэтгэл 95 хувьтай байна. БНХАУ-ын Гансу мужийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт 800 мкв талбай бүхий өвлийн 2 хүлэмж шинээр ашиглалтанд орсон. “Өвлийн хүлэмжийн аж ахуйд цахилгааны хөнгөлөлт үзүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоол, “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 118 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2024 онд шинээр өвлийн хүлэмж байгуулсан 38 иргэн, аж ахуйн нэгжийн 4,2 га талбай бүхий хүлэмжийг цахилгааны хөнгөлтөд хамруулахаар Эрчим хүчний яаманд уламжилж шийдвэрлүүлсэн.	70.0
32	3/е	хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр уул уурхайн үйлдвэрийг түшиглэн азот, фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн фосфорын бордооны үйлдвэр, Дорноговь аймгийн Алтанширээгийн уурхайг түшиглэн азотын үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах төсвийг 2024 оны төсвийн төсөлд 400,0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан боловч хасагдсан. 2024 онд төсвийн төслөөс хасагдсан хэдий ч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлээд байна. 2024 оны байдлаар Импортын үрийн чанар, зохион байгуулалттай холбоотой үүссэн маргаан гараагүй байна.	Х.Б

33	3/ж	бүх төрлийн будаа, чихрийн манжин, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, шаардлагатай санхүүжилт, зээл олголтын оновчтой тогтолцоог бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Тогтоолын хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд чихрийн манжин, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, шаардлагатай санхүүжилт, зээл олголтын оновчтой тогтолцоог бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2023 оны "Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зориологоор бүх төрлийн будаа, чихрийн манжин тариалах инженерийн хийцтэй услалтын систем байгуулахад 27.1 тэрбум, өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад 50.0 тэрбум, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө сайжруулах зээлд 90.0 тэрбум, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийн сайжруулах зээлд 30.0 тэрбум төгрөгийг тус тус арилжаан банкны эх үүсвэрээр олгохоор шийдвэрлэн жилийн 5-6 хувийн хүүтэй, 24-60 сарын хугацаатай олгох зээлийн гэрээг арилжааны 10 банктай байгуулж зээл олголтыг хийсэн. 2024 онд 891 иргэн аж ахуйн нэгжид 111.9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 44 иргэн аж ахуйн нэгжид 36 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг тус тус олгосон.	70.0
34	3/з	стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорины багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах тухай Улсын Их хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн асуудлыг шийдвэрлэн 2023-2024 онд зоорь агуулах барих чиглэлээр хөрөнгө оруулалтын зээлийг нийт 69 иргэн, аж ахуй нэгжид 63,7 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон бөгөөд үүний үр дүнд 33 мянган тонноор агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлэх боломж бүрдээд байна. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 10 мянган тонны багтаамжтай үр тариа хадгалах элеваторын суурь байгуулах газарт инженер геологи, хөрсний судалгаа хийх, элеваторын зураг төсөл, төсвийг зохион магадлал хийлгэх, батлуулах, элеваторын суурь байгуулах ажлыг Дорнод аймгийн Хэрлэн сум, Увс аймгийн Баруунтуруун суманд гүйцэтгэхээр Тэмээн.ХХК-тай 220923/05/558, 221108/05-653 тоот гэрээг байгуулан ажиллалаа. Үүний дагуу 2024 оны 9, 10 дугаар сард 3 удаагийн давтамжтай гүйцэтгэгч Тэмээн.ХХК-тай уулзалт, тайлан мэдээтэй танилцах үйл ажиллагааг зохион байгуулсан. Захиалагчийн хяналтын тайлан хүлээн авч, 2024 оны гүйцэтгэлийг дүгнэж байна. Улмаар "Гэрээнд өөрчлөлт оруулах тухай " ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/527, А/529 дугаар тушаалуудыг батлуулан гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах тухай гэрээг тус тус байгуулаад байна. Өнөөдрийн байдлаар гэрээний дагуу 2 элеваторын суурийн ажил бүрэн дууссан.	70.0
35	3/и	байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах зорилгоор экологид ээлтэй, усыг зөв зохистой ашиглах усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах, шинэчлэх, усан сан бүхий ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, дэмжлэг үзүүлэх; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Төр, хувийн хэвшлийн хөрөнгөр оруулалтын хүрээнд инженерийн болон энгийн хийцтэй услалтын систем барьж 2024 онд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 68.0 мянган га талбайд хүрээд байна. Мөн тариалангийн талбайн ус хангамжийг сайжруулах, зорилгоор Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 4.7 мянган га талбайн услах хүчин чадал бүхий услалтын систем шинээр барих, шинэчлэн сэргээн засварлах барилгын ажил гүйцэтгүүлж байна. Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийн хүрээнд сэргээн засвараж, шинэчлэх 10 услалтын системийг барьж байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллав. Мөн Улсын Төсвийн 2,5 тэрбум төгрөгөөр 600 га талбай услах хүчин чадал бүхий Увс аймгийн Улаангом сумын "Арсай услалтын систем", Улсын төсвийн 2,9 тэрбум төгрөгөөр 700 га талбай услах хүчин чадал бүхий Булган аймгийн Баяннуур сумын "Борбулан" услалтын системийн барилгын ажлыг тус тус гүйцэтгэж 2024 онд ашиглалтад оруулав. Дээрх услалтын системүүд ашиглалт оруулснаар усалгаатай ашиглах тариалангийн талбайн 68.0 мянган га талбайд хүрэх боломж бүрдэнэ. Улсын Төсвийн 17,5 тэрбум төгргийн хөрөнгө оруулалтаар Увс, Булган, Ховд аймагт 7,3 мянган га талбайг услах хүчин чадал бүхий 3 услалтын системийг 2025-2026 онд ашиглалтанд оруулна.	100.0

36	3/к	үйлдвэр, фермер, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн кластерыг бий болгоход чиглэсэн хөдөө аж ахуйн агро парк байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Бүс нутагт тохирсон, стандартын шаардлага хангасан дотоодын суулгацын нэр төрөл, хангамжийг сайжруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Дундговь, Баянхонгор аймагт жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төв, Сэлэнгэ аймагт агропарк байгуулсан. Дээрх 6 аймгийн агропаркын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.	100.0
37	3/л	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвд 30 гектар, сумын төвд 10 гектар агро ойн аж ахуйг тус тус байгуулах, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах; (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Агро ойн аж ахуй шинээр байгуулах ажлын хүрээнд нийт 200 га талбайд байгуулахаас Дархан-Уул аймгийн Орхон суманд 50 га талбайд 33750 ширхэг гүйцэтгэгчээр "Агро форест" ХХК, Говь-Алтай аймгийн Бигэр суманд 50 га талбайд 33750 ширхэг гүйцэтгэгчээр "Бага монгол импекс" ХХК, Дунд говь аймгийн Сайнцагаан суманд 40 га талбайд 27000 ширхэг гүйцэтгэгчээр "Их хайрханы хаялага" ХХК нар ажиллаж мод тарьж, хашаажуулах, худаг ус, усалгааны систем суурилуулах ажлуудыг бүрэн хийгээд байна. Үүнд нэмэлтээр Дархан -Уул аймгийн Хонгор суманд Тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулах ажлыг 41 км газарт 42100 ширхэг суулгацыг тарьж шинээр байгуулсан.	70.0
38			Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Улсын төсвийн 978,0 сая төгрөгөөр Увс, Хэнтий, Төв аймаг болон Нийслэлийн Баянзүрх дүүрэгт тус бүр 3 га талбайд 6-8 төрлийн жимс жимсгэний 1500 ширхэг суулгац бүхий нутагшсан сортын жимс жимсгэний суулгац үржүүлгийн төв байгуулж, орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Мөн хүйтэнд тэсвэртэй жимс жимсгэнийг усалгаатай нөхцөлд туршиж нутагшуулах ажлын хүрээнд Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй гэрээ байгуулж, Дархан-Уул аймгийн Дархан суманд жимсний 5 төрлийн 32 сортын 960 ширхэг суулгацыг тарилаж туршиж байна.Таван толгой ХК Өмнөговь аймгийн Булган сумын 400 га талбайд ойн зурвас, Монголросцветмент ХХК Увс аймгийн Наранбулаг сум болон тээлийн боомтод 250 км ойн зурвас байгуулж байна.	
39	3/м	жил бүрийн намрын ургацаас стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.0 мянгаас доошгүй тонн хүнсний улаан буудайг худалдан авах нөөц бүрдүүлэх. (3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024 оны намрын ургац хураалтаас стратегийн нөөцөд “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК 46.3 мянган тонн, гурилын үйлдвэрүүд 160.8 мянган тонныг тус тус худалдан авсанаар 207.1 мянган тонн улаанбуудай гурил үйлдвэрлэлийн зориулалттай нийлүүлэгдээд байна. Түүнчлэн спиртийн үйлдвэрт 15.6 мянган тонн, малын тэжээлд 56.0 мянган тонн, тонн нийлүүлэгдсэн. Тариалан бүхий аж ахуйн нэгжүүд дараа оны тариалалтад зориулж 40.2 мянган тонн үрийн буудай нөөцөлсөн байна. Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК нь 2024 оны намрын ургацаас нийт 49.000 тонн хүнсний улаанбуудай татан авсан ба өмнөх оны 22,000 тоннн хүнсний улаанбуудайтай нийт 71,000 тонн хүнсний улаанбуудайн нөөц бүрдүүлэн ажиллаж байна.	100.0

40	4/а	бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулах, малчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хамтран ажиллах; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Малын тоог бэлчээрийн даацад тохируулах, сүргийн зохистой бүтцийг бий болгох, малыг чанаржуулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малчдын хээлтэгч малд ангилалт хийж тухайн орон нутагт дасан зохицсон батлагдсан үүлдэр, омгийн гарал үүсэл нь тодорхой стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч малыг үржилд ашиглах чиглэл өгөн ажиллаж байна. Малчид орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран малын үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж малынхаа чанарыг сайжруулж байна. Мөн малын удмын сангийн үндэсний төвийн техникчид Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дорнод, Хэнтий аймгуудын мах, сүүний, мах-сүүний хосолмол ашиг шимт үхэр үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийн 5500 толгой үнээнд улсын төсвийн хөрөнгөөр өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. Мөн Баянхонгор, Хэнтий, Дорнод, Төв аймгуудын малчид, фермер эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн захиалгын дагуу 3709 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийв. Мал амьтныг олноор нь өвчлүүлж, улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг, олон улсын худалдааны хорио цээрт 15 өвчнийг ДМАЭМБ-аас гоц халдварт өвчин гэсэн ангилалд багтаадаг. 2023 оны 01-р сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Монгол улсад мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг зэрэг нийт 3 төрлийн гоц халдварт өвчний гаралт бүртгэгдсэн.Мал, амьтны гоц халдварт өвчнүүдийн /4 өвчин/ голомтын тоо 2022 оноос 3 дахин, өвчилсөн мал, амьтны тоо 93 хувиар буурсан байна.	100.0
41	4/б	мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж,бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, шинэчлэх, хоршоолох хөдөлгөөнийг бүх талаар дэмжих; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай засгийн газрын 166 дугаар тогтоол батлагдсан. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний 4.2.1-т заасан хөрөнгө болон Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 104/03-706/49 дугаартай “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн зээлийн үлдэгдэл хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу орон нутагт түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 4,200,000,000 төгрөгийг хөдөө аж ахуйн загвар хоршооны үндсэн хөрөнгө оруулалтад зориулж жилийн 5 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, эхний жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй “Хөдөө аж ахуйн Загвар хоршооны зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” ХХААХҮСайдын А/26 тоот тушаалыг батлуулав. Хоршооны шинэчилсэн бүртгэлийг 2023 УБЕГ-тай хамтран хийж үйл ажиллагаа явуулаагүй хоршоодын бүртгэл зохион байгуулсан Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 6599 хоршоо шинээр байгуулагдаж, нийт 11,046 хоршоо улсын бүртгэлд бүртгэлтэй байна. Засгийн газрын 2024 "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 1.0 их наяд төгрөгийн “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн гэрээг Сангийн яам, Монголбанк, Арилжааны 8 банктай байгуулж нийт 5117 хоршооны 18195 малчинд 616.3 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.	100.0

42	4/в	хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Улсын төсвийн хөрөнгөөр баталгаажсан үүлдэр, омгийн 325,0 мянган бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг намрын технологит хугацаанд хэрэгжүүлэн орон нутагт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Үүний үр дүнд улсын хэмжээнд 97.5 мянган толгой сүүний үхэр, 28.6 мянган толгой махны үхэр, 8.2 мянган толгой хонь, 23.8 ноосны чиглэлийн хонь, 30,3 мянган толгой мах-өөхний гахай, 1.1 сая толгой мах-өндөгний тахиаг тус тус өсгөн үржүүлж байна. махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрийн аргаар бэлтгэсэн 88.0 мянган тн мах, Иран болон бусад булангийн орнуудруу халал аргаар бэлтгэсэн 52.0 мянган толгой хонины мах, мөн БНХАУлсруу 128.3 мянган толгой бог малыг хүнсний зориулалтаар экспортод гаргасан байна. Мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор гадаадаас сайжруулагчаар махны чиглэлийн мах-сүүний чиглэлийн Монтебеллярьд, махны чиглэлийн хар ангус зэрэг цэвэр үүлдрийн 164 толгой үхэр, махны чиглэлийн Эдельбайев үүлдрийн 220 толгой хээлтүүлэгчийг тус тус импортлон авч, мөн хар тарлан үүлдрийн 1000 тун, Алатау үүлдрийн 2750 тун, Симменталь 1000 тун, Ангус үүлдрийн 1000 тун, Герефорд үүлдрийн 2000 тун Монбельярд 1000 тун нийт 8750 тун гүн хөлдөөсөн үрийг худалдан авч генийн санд баяжилт хийж Малын удмын сангийн үндэсний төв нь 25 үржүүлгийн техникчтэй гэрээ байгуулан Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг, Нийслэлийн 2 дүүрэг нийт 15 сумын 2200 толгой үнээнд зохиомол хээлтүүлэгт хийх ажлыг зохион байгуулав. Төвийн бүсэд 12 үүлдрийн 41.8 мянган үхрийг цэврээр, 76.6 мянган үхрийг эрлийзжүүлсэн хэлбэрээр өгсөн үржүүлж байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн олон нь байна Эдгээр цэвэр үүлдрийн үхрийн дийлэнх нь буюу 19.6 мянга нь Сэлэнгэ аймагт байгаа бөгөөд үүлдрээр авч үзэхэд 8.0 мянга нь Сэлэнгэ, 6.2 мянга нь Ангус, 1.9 мянга нь Халимаг үхэр байна.	70.0
43	4/г	гахай, тахианы болон өсвөр хонь, үхэр бордох аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулахад аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, урт хугацаатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор махны үхрийн аж ахуй эрхэлж буй 5 компани 6.74, тахианы аж ахуй эрхэлж буй 6 компани 24.97 нийт 31,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттөө зээлийн дэмжлэг аваад байна. Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авсан аж ахуйн нэгжүүд нь сүүлийн үеийн дэвшилтэд техник, тоног төхөөрөмж, мал худалдан авч, барилга байгууламжийг шинээр барьж байгуулан, 5-10 хүний ажлын байрыг шинээр бий болгож үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлээд байна. Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авсны үр дүнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл 30-50 хувиар нэмэгдээд байна. Махны цэвэр үүлдрийн үхэр 574 толгойгоор, мах үйлдвэрлэл 140 тн-оор нэмэгдэх боломж бүрдсэн. Гахайн аж ахуйг дэмжих чиглэлээр 8 иргэн, аж ахуйн нэгжид 380.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгох ажлыг зохион байгуулсан. Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” 3 төслийн хүрээнд "Хаш хур" ХХК-ийн хамтран түншлэгч байгууллагуудын "Нялх бог мал шахан бордох" төслийн багтай хэлцэл хийж, төслийг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянгол, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Уянга, Хархорин, Хужирт сумын 320 өрхийн 32000 хургыг бордох 8 аж ахуй байгуулаад байна. Махыг "Монголиан лэмб" ХХК-иар дамжуулан олон улсад экспортлох ажлыг үе шаттай зохион байгуулав. Төслийн бүтээмжит түншлэлийн төслийн хүрээнд "Түмэн шувуут" ХК-тай хэлцэл хийж "Монгол хонины махан ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үүлдэр хоорондын гетерозисийг ашиглаж үр дүнг нотлох" төсөлд хэлцэл хийж, 1,263.0 сая төгрөг гэрээ байгуулж, хурга бордох төслийг Төв, Увсад аймагт эхлүүлэв. Мөн төслийн хүрээнд "Стандарт мах" ХХК-ийн "Үхрийн мах, мал бэлтгэх нэгдсэн тогтолцооны түншлэл" төслийн багтай хэлцэл хийж, төслийг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд 6 бүлгийн 150 малчин өрхийг хамруулан, "Өсвөр үхрийг эрчимтэй шахан бордож" үхрийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүхий эд бэлтгэлийн хэмжээг 30 хувь нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв.	100.0

44	4/д	зөгийн аж ахуйг хоршоолсон хэлбэрээр хөгжүүлэх, түүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх; (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	ХХААХҮЯ-ны дэмжлэгтэйгээр "Монголын Зөгийчдийн Холбоодын дээд зөвлөл" ТББ 2023 онд зөгийн бал үйлдвэрлэлийн кластерийн судалгааг хийж газар зүйн байршлаар Ерөө голын ай сав 3 аймгийн 14 сум, Халх голын ай сав 2 аймгийн 3 сумыг хамруулан Сэлэнгэ аймаг Шаамар, Дархан-Уул аймаг Орхон, Хэнтийн Биндэр, Улаанбаатар гэсэн 4 дэд кластер нэгдэн худалдааны нэгдсэн “Апикластер”-ийг байгуулсан. Кластер зохион байгуулах бүс нутагт төвийн бүсэд үйлдвэрлэлийн дэд кластерт 170 зөгийчин 2000 гаруй бүл зөгийн 100 гаруй тонн зөгийн бал, зүүн бүсэд 38 зөгийчин 1400 гаруй бүл зөгийн 20 гаруй тонн зөгийн бал үйлдвэрлэж байна. Манай орны нийт боломжит зөгийн бэлчээрийн хэмжээ 34,286,000 га, өнөөгийн байдал 14,000 (0.25%), бэлчээрлэх боломжит зөгийн бүлийн тоо 2.0 сая, үүнээс 14,000 (0.7%), нийт хураан авах балны хэмжээ жилд 40.0 сая кг, одоо байдал 204,000 кг (0.51%), балнаас олох орлого 1.2 их наяд, одоогоор 5,916 тэрбум (0.493%), боломжит зөгийчний тоо 20,000 өрх, одоо 667 өрх (3.3%), өрхийн дундаж орлого 60.0 сая төгрөг, одоо 8.8 сая (14.8%) байна.	0.0
45	4/е	/мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах. (4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах ажлын хүрээнд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин 11,6 тэрбум төгрөгөөр 10.5 сая тун, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакциныг 2.8 тэрбум төгрөгөөр 18.2 сая тун, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакциныг 2.4 тэрбум төгрөгөөр 2.2 сая тун, хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакциныг дотоодоос 1.3 тэрбум төгрөгөөр 9.5 сая тун тус тус худалдан авалтыг хийж вакцины нөөцийг бүрдүүлсэн. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар нийт 17.441.488 толгой мал хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар 23.209.600 толгой мал хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтанд 4.280.800 толгой мал, намрын нэгдсэн дархлаажуулалт 2.6 сая толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг Дорнод аймгийн эрсдэл бүхий Чулуунхороот, Халх гол сумдын нутаг дэвсгэрт байгаа мэдрэмтгий үхэр сүрэгт 34,650 тун вакцин хуваарилан дархлаажуулсан. Вакцины хөргүүр буюу хүйтэн хэлхээний хувьд 331 сум, 9 дүүргийн МЭТ-т шилэн хаалгатай хөргүүр 88ш, 21 аймгийн Мал эмнэлгийн газарт тус бүрт нэг нэг хөргүүр, 1027 ААН-д зөөврийн хөргүүр 298ш байна. Цаашид зөөврийн хөргүүр 700ш, шилэн хаалгатай хөргүүр 252 шаардлагатай байна. Булган (2) Говь-Алтай (2) Дорноговь (1), Дорнод (1), Дундговь (2)8 Сүхбаатар (1) Увс (2), Өмнөговь (1)8 Улаанбаатар (1) Нийт 9 аймаг, нийслэлийн 13 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 1.1 тэрбум төгрөгийн зээл авсан байна.	100.0

46	5/а	мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хураалдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын хаврын чуулганы хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн ба техникийн ажлын хэсэг байгуулсан. Энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт: “Органик бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэг, урамшуулал” гэсэн 2 зүйл тусгагдсан. 2. Органик бүтээгдэхүүний тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан дагалдан гарах мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх, гэрчлэх тэмдэг хэрэглэх журмын төслийг эцэслэн боловсруулж "Журам шинэчлэн батлах тухай" ХХААХҮСайдын А/545 дугаар тушаалыг батлав. ХЗДХЯ-нд хүргүүлж, 6927 дугаараар бүртгүүлж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулав 3. Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 130 дугаар тогтоолоор сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан. Мөн Засгийн газрын 2023 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 363 дугаар тогтоолоор дараах өөрчлөлт оруулсан. Үүнд: - бүх төрлийн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, -Хэрэгжилтийн хугацааг 2026.12.31-ний өдрийг хүртэл, -Түүхий сүүний 1 литр тутамд 500.0 төгрөгөөр урамшууллыг нэмэгдүүлсэн, - Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт тушаасан сүүнд урамшуулал олгох - Тухайн жилийн малын тоо толгойн албан татварыг төлсөн малчинд сүүний урамшуулал олгох,	70.0
47	5/б	хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. 2023 онд Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулахад нийт 9 аж ахуйн нэгж (Дархан-уул 1, Увс 2, Улаанбаатар 6)-д 11.57 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. 2024 онд: Монголбанкнаас ирүүлсэн 2024 оны 10 дугаар 31-ний өдрийн мэдээллээр 2 аж ахуйн нэгжид 3.25 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. 2. Еден ХХК хоногт 5-6 тн хүүхдийн хоол тэжээл, жимс жимсгэний нухаш боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна 3. Газар шим ХХК 6 нэр төрлийн 20 гаруй шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2025 он гэхэд 2400 тн багтаамжтай иж бүрэн механикжсан агуулах, ногооны зоорь, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хагас боловсруулах, хэрчин гүн хөлдөөх үйлдвэрийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. (2023-2024 онд олгогдсон хөнгөлөлттэй зээлийн хяналтын гэрээ 4-5 жилийн хугацаатай байдаг тул хараахан үр дүн гарахааргүй байна.)	100.0

48	5/в	цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 төгрөгөөр тус тус тогтоож, хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцуулах асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасан. 2. Засгийн газрын 2024 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 4000 төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 5100 төгрөгөөр тус тус тогтоож, нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлын 1000 төгрөгийг хуульд заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцуулах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт даалгасан. Тус тогтоолын үйлчэл Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур амьжиргаатай өрхийн хүүхэд, мөн хуулийн 20.2.1-20.2.5-д заасан хүүхэд, уртасгасан цагийн зохицуулалттай 24 цагийн цэцэрлэгийн бүлэг болон цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхэд, нэг өрхөөс 3 болон түүнээс дээш хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байгаа тохиолдолд (3 дахь хүүхдээс эхлэн) хамаарахгүй байна.	70.0
49			Боловсролын яам	Засгийн газрын 2024 оны 237-р тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 500 төгрөгөөр нэмэгдүүлж, 3000 төгрөг, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны зардлыг 4100 төгрөгөөр шинэчлэн тогтоосонтой холбогдуулан 2024 оны төсвийн тодотголд шаардагдах зардлыг тусган батлуулсан. Мөн нийслэлийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлж, эцэг эх хариуцах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 2024.09.11-ний өдрийн "Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны ттүүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73-р тогтоол батлагдсан. Боловсролын сайдын 2024.09.12-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцах хоолны түүхий эдийн зардлын тодорхой хэсгийг төвлөрүүлэх, зарцуулах аргачлал”-ыг баталсан. Хүүхдийн хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг эх, харгалзан дэмжигчээс төвлөрүүлэх, зарцуулалтад тавих хяналтыг хувийн хэвшлийн 4 цахим системээр дамжуулан хэрэгжүүлж байна. Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, эцэг эхийн хяналт, оролцоог хангаснаар хүүхдийн цэцэрлэгийн хоол, хүнснээс авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийн хэмжээ 20 хувиар нэмэгдсэн. 2025 оны улсын төсөвт бага ангийн нэг сурагчийн үдийн хоолны зардлыг 1000 төгрөгөөр, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоолны зардлыг 2000 төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг тусган хүргүүлж, УИХ-ын чуулганаар ирэх оны төсвийг батлаад байна.	
50	5/г	хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихрийн боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. 2023 онд хоногт 15.0 тонн хүнсний давс боловсруулах үйлдвэр байгуулах дэмжлэг үзүүлэхэд 4 ААН-д 929.7 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна. 2024 онд Монголбанкнаас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн мэдээллээр 1 аж ахуйн нэгжид 0.10 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. 2. Завхан аймаг: Баялаг органик ХХК шинээр тоног төхөөрөмж худалдан авч үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлсэн.	30.0

51	5/д	хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр /автомашин, вагон, онгоц/ тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. Зам, тээврийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхтэй холбоотой 3 удаагийн албан бичгээр саналыг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй. 2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” А/222 дүгээр тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, банк хооронд “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын 240201/07-61 дүгээр санхүүжилтийн гэрээ”, тус гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 020419/03-299 дүгээр гэрээг тус тус байгуулсан. 3. Монголбанкнаас ирүүлсэн 10 дугаар сарын 31-ний өдрийн мэдээллээр 62.89 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод байна	70.0
52			Зам, тээврийн яам	Улаанбаатар төмөр замын хэмжээнд 2024 онд ургац болон хүнсний ачааны тээвэрт 206 бүтүү вагон ашиглаж байна. 2024 онд экспорт, орон нутгийн үр тариа, гурил 2101 вагон, хүнсний ачаа 2493 вагонд ачсан. Импорт Наушки-Сүхбаатар хүлээн авсан хүнсний ачаа 1833 вагон, үр тариа 1225 вагон, Эрээн-Замын-үүд 5033 хүнсний ачаа вагон хүлээн авсан байна.	
53	5/е	хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1.Импортын барааны гаалийн албан татварыг хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг Засгийн газрын 2023 оны "Жагсаалт батлах тухай" 107 дугаар тогтоолоор баталсан. 2. Уг тогтоолд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 22 нэр төрөл, Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр 23 нэр төрөл, Ундааны үйлдвэр 13 нэр төрөл, Давсны үйлдвэр 11, Мал төхөөрөх болон махны үйлдвэр 73, Хиам, консервын үйлдвэр 29, Кетчуп, майонез, ургамлын тосны үйлдвэр 17, Төрөл бүрийн хүнсний ногоо нөөшлөх үйлдвэр 15, Гурилын үйлдвэр 18, Талх, нарийн боовны үйлдвэр 27, Сав, баглаа боодол хийх, савлах үйлдвэр 28, нийт 276 нэр төрлийн тоног төхөөрөмж багтсан. 3.2024 оны 10 дугаар сарын байдлаар 116 аж ахуйн нэгжид 124.8 тэрбум төгрөгийн импортын бараанд 6.0 тэрбум төгрөгийн импортын гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр байна.	0.0

54	5/ж	хүнсний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний амт чанар, сав, баглаа боодлыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэн экспортын зориулалтын брэндийг хөгжүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуульд Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 100 хувь хөнгөлөхөөр тусгагдсан. Хуульд заасны дагуу хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай 426 нэр төрлийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 107 дугаар тогтоолоор батлагдсан. Тус жагсаалтад сав, баглаа боодол, савлах үйлдвэрийн 28 нэр төрлийн тоног төхөөрөмж багтсан. Тогтоолын хүрээнд 2023-2024 оны 9 дүгээр сарын байдлаар 224 аж ахуйн нэгж 166.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг импортлон 7.6 тэрбум төгрөгийн татварын буцаан олголт эдэлсэн байна. Тоног төхөөрөмж худалдан авалтын 52 хувийг үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмж, 5.2 хувийг тусгай тээврийн хэрэгсэл эзэлж байна. 2. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, тус улсын Гаалийн ерөнхий газрын цахим системд адууны мах экспортлох 2, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох 6 үйлдвэрийг шинээр бүртгүүлсэн. Монгол Улс 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ба Дэлхийн нийтийн хамарсан Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ дунджаар 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 онд 16.0 мян.тн, 2023 онд 80.4 мян.тн /түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 120.0 мян.тн/, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 63.8 мян.тн /ястай түүхий маханд шилжүүлэн тооцвол 87.2 мян.тн/ мах, махан бүтээгдэхүүнийг 260.0 сая ам долларoор тус тус экспортолсон. 3.Монголбанкнаас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн мэдээллээр 78.35 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.	70.0
55	5/з	хүнсний нэмэлт, биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг дэмжих; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/515 дугаар тушаалаар батлагдсан “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам батлах тухай” журмын дагуу бүртгэлийг хийж байна. Одоогоор хүнсний нэмэлт-199, Өсгөврийн хөрөнгө-85, Баяжуулагч бэлдмэл:15 /үүнээс албан журмаар-1 / улсын бүртгэлд бүртгэж, цахим сайтад байршуулсан байна.	30.0
56	5/и	улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 68 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Бүтээгдэхүүнээс дээж авах, түүнийг хадгалах, тээвэрлэх журам"-ын дагуу дотоодын болон экспорт, импортын бүтээгдэхүүнээс дээж авах, лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна /68-р тушаал хавсаргав/. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулинд өөрчлөлт орж амьтан, ургамлын экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдлийг гаалийн байгууллагаас ХХААХҮЯ-д шилжүүлэн авсан. Экспортын гэрчилгээ, мэдэгдлийг шилжүүлэн авснаар ачилтын өмнөх шинжилгээ, хяналт шалгалт болон бусад холбогдох мэдээллийн нэгдсэн сан үүсгэх боломж бүрдэнэ /ажлын хэсгийн тушаалыг хавсаргав/. Лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх зорилгоор МЭХ, УМЭАЦТЛ, ХАБУЛ, НМЭГ-ын МЭАЦЛ зэргийг олон улсын ур чадварын сорилд хамруулах, хамтарсан уулзалт хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулах, лабораторийн шинжилгээний итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70.0

57			Сангийн яам	Хорио цээрийн газар, хороодын 2024 оны 1-11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээг нэгтгэхэд нийт 6,6 мян.тн, 364.429.846 ширхэг, 54 хайрцаг бараа бүтээгдэхүүнээс 23651 удаа 50,3 тн бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа, бүтээгдэхүүнээс 119299 үзүүлэлтээр шаардлага хангаж, 218 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. Лабораторийн шинжилгээний төлбөр болох 936,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн ба Улсын Мал эмнэлгийн лабораторид шинжилгээнд хамруулсан барааны төлбөр ороогүй болно. Лабораторийн шинжилгээт хяналтад нийт хамрагдсан бүтээгдэхүүний /6,6 мян.тн буюу 50,3тн/ 0,7 хувь дээжийг шинжилсэнээс 119299 үзүүлэлт буюу 99.8 хувь шаардлага хангаж, 218 үзүүлэлт буюу 0.2 хувь нь шаардлага хангахгүй дүнтэй гарсан. ЗҮГГ, СЭГГ, БӨГГ, ХоГГын гаалийн салбар лабораторид хүнсний бэтээгдэхүүнд эрүүл ахуй, чанар аюулгүйн үзүүлэлтүүд болох нян судлал, хими хор судлал, ургамал хорио цээрийн нийт 17'008 нэр төрлийн дээжид магадлан шинжилгээ хийгдсэн. ЧХОУНБГГ-ын ГСЛ-ийн барилгын засвар бүрэн дуусаагүй. 2024.01 сараас 5 Шинжээч-ГУБ-г томилуулан, химийн, хорио цээрийн шинжилгээний 30 төхөөрөмжийн тохиргоо хийж, хэвийн ажиллагаанд оруулсан.ЗҮГГ-ын салбар лаборатори нь хүнсний бэтээгдэхүүнд эрүүл ахуй, чанар аюулгүйн үзүүлэлтүүдийн магадлан шинжилгээгээр Үндэсний итгэмжлэлл хамрагдсан. СЭГГ, БӨГГ, ХоГГын салбар лабораториуд нь итгэмжлэлийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
58	5/к	хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах. (5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	УИХ-ын “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд “Монгол зоог, ундааг тогтвортой хөгжүүлэх нь” арга хэмжээг Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв ГҮТББ-тай хамтран 4 дүгээр сарын 5-ны өдөр UG Palace-д зохион байгуулав. Арга хэмжээнд нийт 400 гаруй хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын төлөөлөл оролцож Монгол зоог, идээ ундааны өнөөгийн байдал, цаашид хөгжүүлэх талаар санал солилцов. 2. “Бүх нийтийн хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих агуулга бүхий мэдээлэл боловсруулж, контент бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах” ажлыг 49,5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Ти Би Дайтус” ХХК-тай 240607/07-479 тоот гэрээг байгуулсан. Ажлын үр дүнд “Эрүүл байх амархан” уриан дор нийт 18 контент рийлс, 28 постер бүтээж, олон нийтэд түгээсэн. Нийт 493300 хүнд хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулан, эрүүл хооллолтын талаар мэдлэг боловсролыг дэмжин ажилласан байна. 3. "Монголын уламжлалт таван өнгийн идээ ундааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан таниулах, контент бэлтгэх” ажлыг 17.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Шүрэн соёмбот ХХК-тай 240404/07-252 гэрээг байгуулсан. Гэрээт ажлын гүйцэтгэлээр нийт 11 сэдвийн хүрээнд хэвлэлийн мэдээ видео хийсэн бөгөөд нийт контентийг 35.0 мянга орчим хүнд хүрсэн байна. 4.“Иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлж, олон нийтэд сурталчлах” ажлыг 10.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Монголын цахилгаан мэдээ ХХК-тай 240229/07-127 гэрээг байгуулсан. Гэрээт ажлын гүйцэтгэлээр нийт 20 сэдвийн хүрээнд хэвлэлийн мэдээ видео хийсэн бөгөөд нийт контентийг 30.0 мянга орчим хүнд хүрсэн байна.	100.0

59	3	Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	УИХ-ын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан арга хэмжээг Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, Улсын төсөвт тусган батлуулсан.	30.0
Биелэлтийн дундаж					**61.2**

"МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ 63 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Актын №	Актын нэр	Батлагдсан огноо	Заалтын №	Заалт	Нэгдсэн биелэлт	Нэгдсэн үнэлгээ
2024_63	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай	2024-06-05	2.1.а	а/хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Үзэл баримтлалыг ХХААХҮ-ийн сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2021 онд хамтран баталсан байна. Харин Засгийн газрын бүтэц шинээр эмхлэн байгуулагдсантай холбоотойгоор тандан судалгаа, үзэл баримтлалыг шинэчлэн дахин батлуулахаар ажиллаж байна. 2025 онд хуулийн төслийн өргөн барихаар төлөвлөсөн байна. Үр дүнтэй ажил зохион байгуулаагүй тул үнэлгээг буруулав.	0.0
			2.1.б	б/үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Заалтын хүрээнд 2024 онд Монгол Улсын гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 40.8.Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг тухайн бүсэд хамаарах аймгийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн хамтарсан саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болно.", 38.1.24.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал." заалт нэмсэн байна. Гэвч үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх хууль эрох зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Мөн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан эсэх талаар тайланд тусгагдаагүй байна. тухайн заалтыг хэрэгжээгүй гэж дүгнэв.	0.0
			2.1.в	в/малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;	Засгийн газрын 2024 оны 11 сарын 27-ны “Цагаан алт” хөдөлгөөний талаар авах зарим арга хэмжээний тухай 190 дугаар тогтоол батлуулсан хэдий ч тогтоолын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан талаар тайланд тусгагдаагүй тул үнэлгээг буруулав.	70.0
			2.1.г	г/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан, Улсын Их хурлын байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлалын хүрээнд бусад хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөө аж ахуйн биржийн тухай” шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэй байхаар боловсруулсан байна. “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо”-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэсэн байна. Засгийн газрын бүтэц шинээр эмхлэн байгуулагдсантай холбоотойгоор үзэл баримтлал батлагдаагүй. Хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийгдээгүй байна, тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа тул үнэлгээг буруулав.	0.0

			2.1.д	д/малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж байгаа урамшууллыг дүгнэж, үр дүнд суурилсан, зах зээлийн зарчимд нийцүүлэхэд чиглүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолд Улсын Их Хурлын 2023 оны 87 дугаар тогтоолоор "1/малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж, үндэсний боловсруулах үйлдвэрт тушааж, татварын цахим төлберийн баримтын системд бүртгэгдэж баталгаажсан хонины ноосны килограмм тутамд 1000 төгрөг, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөг, сарлагийн хөөврийн килограмм тутамд 10000 төгрөгийн урамшуулал олгох;" тухай өөрчлөлт оруулсан байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960607409331 Түүхий эд бэлтгэлийн https://fiber.mofa.gov.mn системийг хөгжүүлэн 2024 оноос эхлэн урамшуулалттай бэлтгэж буй хонь, тэмээний ноос, сарлагийн хөөврийг бүртгэн авч, малчдын урамшууллыг цахимжуулж эхэлсэн байна. https://fiber.mofa.gov.mn/reports/farmers	100.0
			2.1.е	е/дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахад шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх.	Заалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” батлагдсан байна. Тус техникийн зохицуулалтыг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 66 дугаар тогтоолоор дээрх техникийн зохицуулалтын 3 дахь заалтад (“Техникийн зохицуулалт батлах тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 380 дугаар тогтоолын 3 дахь заалтын “2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс гэснийг 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс” гэж өөрчилсүгэй.) өөрчлөлт орсон байна. Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 66 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж хэрэгжих хугацааг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс гэсэн өөрчлөлт орсон. Тогтоолын үйлчлэх хугацааг дахин нэг жилээр хойшлуулах тухай Засгийн газрын 2024 оны “Мал аж ахуйн салбарт авах зарим арга хэмжээний тухай” 211 дугаартай тогтоол гарсан.Текстилийн стандартчиллын техникийн хорооны ТХ16-ны 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хурлаар дараах 2 стандарт хэлэлцэж батлахыг дэмжсэн. - MNS 5306:2024, Ноолууран ээрмэл. Техникийн шаардлага - MNS …:2024, Ээрмэл бүтээгдэхүүн. Тэмээний ноосон ээрмэл. Техникийн шаардлага.	70.0
			2.2.а	а/малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах ажлын хүрээнд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин 11,6 тэрбум төгрөгөөр 10.5 сая тун, бог малын мялзан өвчнөөс сэргийлэх вакциныг 2.8 тэрбум төгрөгөөр 18.2 сая тун, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакциныг 2.4 тэрбум төгрөгөөр 2.2 сая тун, хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакциныг дотоодоос 1.3 тэрбум төгрөгөөр 9.5 сая тун тус тус худалдан авалтыг хийж вакцины нөөцийг бүрдүүлж 2024 онд урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар нийт 17.441.488 толгой мал хамруулахаар төлөвлөсөн ба яаралтай дархлаажуулалтын гүйцэтгэл 95.6%, нэгдсэн дархлаажуулалт 97.4% гүйцэтгэлтэй дууссан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон нэгдсэн дархлаажуулалтаар 23.209.600 толгой мал хамруулахаар төлөвлөсөн ба яаралтай дархлаажуулалтын гүйцэтгэл 91.7%, нэгдсэн дархлаажуулалт 95% гүйцэтгэлтэй хийгдэж дууссан. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтанд 4.280.800 толгой мал хамруулахаар төлөвлөж 92.1% гүйцэтгэлтэй дууссан. Намрын нэгдсэн дархлаажуулалт 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн А/399 дүгээр тушаалаар 2.6 сая толгой мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 82,1% явагдаж байна. Мөн Био бэлдмэлийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Биокомбинат ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх ажлын хүрээнд хонины цэцгийн вакциныг шугаман эсийн технологит шилжүүлж, дараагийн шатны эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэх ажил хийгдэж байна.Түүнчлэн 135-160 шингэн вакцины гар савлагааг бүрэн автоматжуулах ажлыг хийж дууссан байна. Вирус судлалын лабораторид мал аж ахуй эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, шугаман эсийн технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлж байна. "хэрэгжих шатанд"-зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа	70.0

			2.2.б	б/улс, аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лаборатори байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах;	1.УМЭАЦТЛ-той хамтран 8 чиглэлийн ажлын байрны сургалт зохион байгуулж, 120 лабораторийн эмчийг хамруулж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн байна. НҮБ-ын МААЭЗЭН төслийн санхүүжилтээр МЭЭСБУЛ-д 28 нэрийн 66 ширхэг 318,0 сая төгрөг, НМЭГ-ын лабораторийн хүнсний аюулгүй байдлын шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 227,0 орчим сая төгрөгийн багаж, төхөөрөмж тус тус нийлүүлсэн байна. УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудад 2024 онд мал эмнэлгийн лабораториудын оношилгооны бэлэн байдлыг хангах зорилгоор 4 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж, нийт 2,031,640,000 төгрөгийн төсөв бүхий лабораторийн оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна. Улсын хэмжээнд мал эмнэлгийн нийт 25 лабораториос 10 лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандартын лабораторийн итгэмжлэлд шинээр хамрагдсан байна. Мөн МЭЭСБУЛ-ийн MNS ISO/IEC 17065:2013 стандартын итгэмжлэлийн гэрчилгээг 4 жилийн хугацаатай сунгасан бөгөөд итгэмжлэлд улсын төсвөөс 50, 0 сая төгрөг зарцуулсан байна.АХБ-ны "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төслөөр 2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сэлэнгэ аймагт “Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори” баригдаж, 100%-ийн гүйцэтгэлтэй .НҮБ-ын МААЭЗЭН төслөөс 2023 онд Өвөрхангай аймагт “Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори”-ийн барилгын ажилд 340,000,000 төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж, БХТ-өөр зураг төслийг батлуулан 2024 онд барилгын ажил хийгдэж, 90%-ийн гүйцэтгэлтэй байна. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан	100.0
			2.2.в	в/бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан хөдөө аж ахуйн тэргүүлэх бүсүүдэд дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтийг тогтоож, тогтвортой хадгалах;	1. 2024 онд МЭЕГ, НҮБ-ын ХХААБ-ын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мал төхөөрөх үйлдвэрт суурилсан 5 төрлийн тандалт шинжилгээнд шаардлага хангасан сорьц, дээж цуглуулах, шинжилгээнд хамруулах, зарим төрлийн өвчнөөс эрүүлийг баталгаажуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулав. 2. Монгол улсыг үхрийн цээж өвчний байгалийн халдваргүй, тайван статусыг хадгалах стратегийн хэрэгжилт, баталгаажуулах тайланг ДМАЭМБ-д хүргүүлэх ажлын хүрээнд Мал эмнэлгийн хүрээлэнтэй 22024/10 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан орон нутгаас дээж авах, оношлуур хэрэглэгдэхүүний худалдан авалтыг Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулан ажилласан байна. Тандалт шинжилгээний үр дүнгийн тайлан 2024 оны 11 дүгээр 29-ний өдөр Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-д батлагдсан зааврын дагуу майл болон тусгай мэдээллийн системээр илгээсэн байна. 3. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн гүйцэтгэлд үнэлгээ хийж, тайланг 2024 оны 10 дугаар сард ДМАЭМБ-д хүргүүлсэн. 4. ХХААХҮ-ийн сайдын 2024 оны өдөр А/249 тушаалаар “Хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах хяналт тавих” журмыг батлуулсан. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй	30.0
			2.2.г	г/малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/80 дугаар тушаалаар “Амьд малын төвлөрсөн цэгийг боломжит бүсэд байгуулах судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу гадаад улс орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаарх судалгаа, Амьд мал болон мах худалдаалах зах зээлийн суурь судалгаа, Малын төвлөрсөн цэг байгуулах боломжит бүс, байршлын талаархи судалгаа, Мал, махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагыг төрөөс дэмжиж буй урамшуулал, дэмжлэгийн талаар, Малын тэжээлийн норм норматив, махны стандарт, үйл ажилллагаанд мөрдөж буй стандартуудын талаар тус тус судалгааны ажлуудыг хийн нэгтгэсэн. - 10 га газар амьд малын захын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг, төсвийн үнийн саналыг “зураг төслийн ажлын жишиг үнэ” БД 81-16-20-ийн дагуу тооцож боловсруулан аж ахуйн нэгжүүдээс холбогдох саналыг авсан. Хэнтий аймгийн Баян-Овоо суманд "Баялаг гүрэм" загвар хоршоог байгуулсан байна. Цаашид малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгох, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүсчилсэн	30.0

					хөгжлийн зорилттой уялдуулан тооцоо судалгаа хийх нь зүйтэй байна. Хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэв.	
			2.2.д	д/түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлохыг дэмжих;	Түүхий эд бэлтгэлийн https://fiber.mofa.gov.mn системийг хөгжүүлэн 2024 оноос эхлэн урамшуулалттай бэлтгэж буй хонь, тэмээний ноос, сарлагийн хөөврийг бүртгэн авч, малчдын урамшууллыг цахимжуулж эхэлсэн байна. Гэхдээ түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлэлт, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эд, бүтээгдэхүүний тоо хэмжээ, тэдгээрээс дотоодын болон экспортлосон байдлын талаар тайланд тодорхой тусгай байх тул үнэлгээг бууруулав.	70.0
			2.2.е	е/түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах, мэргэшүүлэх.	1) “АРЬС ШИРЭН ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛИЙН СУРГАЛТ – 2024” цахим сургалт 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Баянхонгор аймгаас эхэллээ. Сургалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ЦАГААН АЛТ” хөдөлгөөн, Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал, Арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, чанар хамгаалалтын аргууд, Арьс ширэн түүхий эдийн чанарыг сайжруулах арга зам зэрэг илтгэл, хичээлүүд орлоо. Сургалтад Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, арьс шир боловсруулах Булигаар ХК, Баянхонгор аймгийн түүхий эд бэлтгэлийн төлөөлөгчид, хоршоод, салбар хариуцсан мэргэжилтнүүд оролцов (Хавсралт 1.1-1.3). 2) ХХААХҮЯ, ХААБ, Хэнтий аймгийн ХААГ, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоотой хамтран “АРЬС ШИРЭН ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛИЙН СУРГАЛТ – 2024” сургалтыг 11 дүгээр сарын 14-нд Хэнтий аймагт зохион байгуулав (Хавсралт 2).	100.0
			2.3.а	а/түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татвар, зээлийн хүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;	Зорилтын хүрээнд ноос, ноолуур, арьс ширний салбарын үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгжүүдээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах судалгааг авсан байна. Мөн Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын хуралдаанаар ""Цагаан алт” хөдөлгөөний талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг боловсруулж 190 дүгээр тогтоолоор батлуулсан байна. Тогтоолын төсөл батлагдсантай холбоотой “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-ийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ерөнхий гэрээг боловсруулж арилжааны банкнаас саналыг авахаар цахимаар хүргүүлсэн байна. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй гэж дүгнэв.	30.0

			2.3.б	б/олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг бүсийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад чиглүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Заалтын хэрэгжилтийг 2 байгууллага тайлагнасан, хэрэгжилтийн дундаж 85%тай байна. Заалтыг хэрэгжүүлэх хүрээнд “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлэхэд хууль эрх зүй, бодлого боловсруулах орчныг бий болгох, төр болон хувийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн тогтвортой менежментийг өргөжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд өртөж буй иргэдийн чадавхыг бэхжүүлэх, олон талт оролцогч талуудын платформыг ажиллагаанд оруулах чиглэлээр хамтран ажиллахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2024 оны 12 сарын 06-ны өдөр байгуулсан байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний төлөвлөгөөнд Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/ дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2020-2024 онд 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 609.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээс батлуулсан байна. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.	70.0
			2.3.в	в/эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж, үндэсний үйлдвэрүүдийг олон улсын томоохон үзэсгэлэнд тогтмол оролцоход дэмжлэг үзүүлэх;	Заалтын хүрээнд Францын Парис хотноо 2024.7.2-4-ны өдрүүдийн хооронд зохион байгуулагдсан “Premiere Vision” үзэсгэлэнд Монголын Хаан Ширхэгт бүтээгдэхүүний чанарын, Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцооны стандартыг эзэмшигч Кашмир Холдинг, Ханбогд Кашмир, Сноу филдс, Говь-Эрдэнэ компаниуд оролцсон байна. Үзэсгэлэн нь 51 дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд 50 гаруй орны 1,400 орчим оролцогчид өөрсдийн бараа, бүтээгдэхүүнээ танилцуулж 120 гаруй орны текстилийн салбарын мэргэжилтнүүд, сонирхогчид цугларан санал солилцон, туршлага хуваалцаж, эко, тогтвортой, инновацлаг, дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжсэн арга хэмжээ болсон байна. Уг үзэсгэлэн нь ХХААХҮЯ-ны санхүүжилтээр Монголын ноос ноолуурын холбоо 3 дахь удаагаа амжилттай зохион байгуулж оролцосон байна. (Зураг 1-11). Мөн Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол- Вьетнамын Засгийн газар хоорондын 19-р хуралдаан 2024.11.19-23-ны өдрүүдэд БНСВУ нийслэл Ханой хотноо болж, БНСВУ дахь бизнесийн төлөөллийг ЭСЯ-ны байранд хүлээн авч уулзсан бөгөөд уулзалтаар арьс шир, ноос ноолуур, мах махан бүтээгдэхүүний экспорт, цагаан будаа болон бусад бүтээгдэхүүний импорт, тээвэрлэлт, хоёр орны бизнесийн орчинд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн байна. удаагийн худалдааны үзэсгэлэн яармаг 2024.11.20-23-ны өдрүүдэд болов. Мөн БНСВУ-ын Хөдөө аж ахуйн худалдааг дэмжих төвөөс “Агро Вьет–2024” Хөдөө аж ахуйн олон улсын 24 дэх удаагийн худалдааны үзэсгэлэн яармаг 2024.11.20-23-ны өдрүүдэд зохион байгуулж Монгол Улсаас нийт 20 гаруй үндэсний үйлдвэрлэгчид бараа, бүтээгдэхүүнээ танилцуулсан байна. (Зураг 13-15). Токио хотод 2025.03.11-03.14-ний өдрүүдэд зохион байгуулагдах "FOODEX JAPAN 2025" 50 дахь удаагийн олон улсын хүнсний үзэсгэлэн худалдаанд Монгол улсаас оролцох 8 ААНБ-уудын мэдээллийг үзэсгэлэнгийн цахим хуудаст байршуулах ажлыг гүйцэтгэж байна. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан гэж дүгнэв.	100.0
			2.3.г	г/байгаль орчин, мал амьтанд ээлтэй, тохирлын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;	Цагаан алт үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тул "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй". гэж дүгнэв.	Х.Б

			2.3.д	д/нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчинд эерэг нөлөөтэй, зохистой дадал, стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ногоон санхүүжилтэд хамруулах, арга туршлагыг нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах;	Заалтын хүрээнд жил бүр уламжлал болгож эрдэм, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний инновацын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн “Монголын Инновацын 7 хоног” өдөрлөг арга хэмжээг 2024.04.22-04.27-ны өдрүүдэд Улаанбаатар, Орхон аймагт зохион байгуулсан байна. Мөн "МОНГОЛЫН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН НЭГДСЭН ЧУУЛГАН-Х"-ийг “ТЕХНОЛОГИ ХӨГЖИЛ” уриан дор “их дээд сургуулиудын хөгжүүлж байгаа гарааны бизнес, инновацийн төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж, энтрепренерүүдийн хамтын ажиллагаа, технологийг хөгжүүлэх чиглэлд оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улс дах энтрепренершипийн болон гарааны бизнесийн тогтвортой хөгжлийн төлөө, өрсөлдөх чадвар бүхий бизнесүүдийг бий болгох, орон нутгийн жижиг бизнес загварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2024.11.28-ны өдөр Дархан хотод зохион байгуулсан байна. Төвийн бүсийн хөгжлийн чуулганаар бүсийн хөгжлийг дэмжих, гарааны бизнес, инновацын төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлд эрдэмтэн, судлаачдын шийдлийг сонсож, амжилттай хэрэгжүүлж буй гарааны бизнесийн туршлагуудыг танилцуулсан байна. Тайланд нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжсэн эсэх, зохистой дадал, стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ногоон санхүүжилтэд хамруулсан эсэх зэрэг асуудлын талаар тайланд тусгагдаагүй тул үнэлгээг бууруулав. Цаашид заалтын хэрэгжилтийг бүрэн тайлагнаж хэвших нь зүйтэй байна.	30.0
			2.3.е	е/үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй тогтолцооны болон зохистой дадлын стандартын хэрэгжүүлэлт, баталгаажуулалт зэрэг үйлдвэрлэлийн хөгжил, дэвшлийн талаарх мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;	Зорилтын хүрээнд "Марис трейд ХХК" /Монгол шевро ХК/ нь БНЧУ-ын Хаанзаа ХХК-иар үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг суурилуулсан бөгөөд туршилт тохируулгын ажилтай танилцаж, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг Малчин ТВ, Монгол малчин сэтгүүлийн албаны төлөөллүүдээр видео контент, ярилцлага бэлтгэн зохион байгуулсан байна. Мөн үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааг таниулан сурталчлах зөвлөх үйлчилгээг эхлүүлэх уулзалтад оролцож, Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх кампанит ажлын стратеги, арга зүйг боловсруулах, контент бүтээх, стратеги аргачлалын дагуу түгээх ажлын төлөвлөгөөнд холбогдох саналуудыг боловсруулж, санал зөвлөмжийг танилцуулсан байна. /2024.11.29/ Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд олгох хөнгөлөлттэй зээлийн арилжааны банкуудтай хийх гэрээг үзэглэх арга хэмжээг нэгдсэн байдлаар Дархан -Уул аймагт зохион байгуулаар төлөвлөн ажиллаж байна. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа гэж дүгнэв.	70.0
			2.3.ж	ж/"Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийг түүхий эдийн нөөцийн зохистой харьцааг хангасан, нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх;	Хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийг түүхий эдийн нөөцийн зохистой харьцааг хангасан, нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх ажлын хүрээнд арьс ширний анхан шатны боловсруулалт хийх, ноос ноолуурын ээрэхээс дээш боловсруулалт хийх тоног төхөөрөмж худалдан авахад зорилж зээлийн хүүг 1 хувиар бага байхаар гэрээнд тусгасан байна. "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тул үнэлээгүй.	Х.Б
			2.3.з	з/малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зах зээлийг тэлэх зорилготой PlayStore болон AppStore-д байршуулсан. Олон нийтэд зориулагдсан үндэсний бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн ЖДҮ аппликейшнд 2024 онд хийгдэх хөгжүүлэлтийн ажлыг “МАЙНД СИМБОЛ” ХХК -тай Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2024.04.09-ний өдрийн А/50 тушаалын дагуу 2024 оны №39 дугаартай гэрээг байгуулан аппликейшнд эх орондоо бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэж тэдний бараа бүтээгдэхүүнийг байршуулсан байна. 2023 онд 800 ААН-ийг байршуулсан бол ЖДҮ аппликейшн, вэб хувилбараа 21 аймгийн мэргэжилтнүүдэд вэбэд бүртгүүлэх зааврыг танилцуулга видео хэлбэрээр бэлтгэж заавар зөвлөгөө хүргэн ажилласнаар 2024 онд 1440 ААНБ-ын бараа бүтээгдэхүүнийг байршуулж ажилласан байна. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан	100.0

			2.4.а	а/үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт /YAMAT-08/ болон сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;	Монгол Улсад экспортын баримжаатай ноолуурын салбарт олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, суурь зарчимд нийцсэн цалин хөлсний нэгдсэн системийг нэвтрүүлэх зорилгоор МННХ, Монголын хөнгөн үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбоо, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сан хамтран “Тарифын хэлэлцээр” төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд 230 гаруй ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, цалингийн итгэлцүүрийг тогтоон, ноолуурын салбарын жишиг цалин хөлсний тарифын сүлжээг боловсруулан ажил олгогч нарт хүргүүлсэн. Монголд анх удаа олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн тарифт цалингийн хамтын хэлэлцээрийг байгуулж, салбарын түвшинд зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нэгдсэн цалин хөлсний системтэй болох, хөдөлмөрийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих зэрэг эерэг үр нөлөөтэй. Хэрэгжих шатанд бүрэн хүрээгүй ч зохион байгуулалтын арга хэмжээг авч, холбогдох байгууллагын шийдвэр гарсан гэж дүгнэв.	70.0
			2.4.б	б/гадаадын өндөр хөгжилтэй оронд инженер, техникийн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" хөтөлбөрт хамруулах;	Гадаадын өндөр хөгжилтэй оронд инженер, техникийн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" хөтөлбөрт ХААХҮ-н салбараас хамрагдаагүй тул үнэлээгүй .	Х.Б
			2.4.в	в/бүсийн үйлдвэрлэлийн чиглэлтэй уялдуулан салбарын хүний нөөцийг коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сургах, нарийн мэргэжлийн ажилтнуудыг дотоод, гадаадын их, дээд сургууль, коллежид суралцахад дэмжлэг үзүүлэх;	Тус заалтыг хэрэгжүүлэхийн тулд тодорхой ажлуудыг зохион байгуулсан боловч цаашид бодтой дэмжлэг үзүүлэх, ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.	30.0
			2.4.г	г/Улаанбаатар хотоос орон нутгийн хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллахаар шилжин суурьших иргэдийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах;	Тус заалтыг хэрэгжүүлэх үүднээс ЖДҮС-с ААНБ-д зээл олгосон, дэмжсэн ажлууд хийсэн ч хөнгөн үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт буюу зээл олгосон нь харагдахгүй мөн цаашид хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллахаар шилжин суурьших иргэдэд чиглэсэн ажлыг бодитой зохион байгуулахад анхаарах шаардлагатай.	70.0
			2.4.д	д/үндэсний ажил мэргэжлийн стандарт ба цалин хөлсний бодлогыг боловсруулах, ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, хүн төвтэй зохистой хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх Тарифын хэлэлцээр боловсруулж, хэрэгжүүлэх.	Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтод нийцүүлэн, ажил мэргэжил бүрт тавигдах мэдлэг, ур чадварын шаардлага, хүчин чармайлт, хариуцлага, хөдөлмөрийн нөхцөл зэрэг шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн бүлэглэж, цалингийн итгэлцүүрийг тогтоон, ажил мэргэжлийг үнэлэх аргачлал, ноолуурын салбарын жишиг цалин хөлсний тарифын сүлжээг боловсруулан ажил олгогч нарт ноос ноолуурын холбооноос хүргүүлсэн гэсэн боловч тус тарифын баталсан эрх зүйн баримт бичиг дурдаагүй, нотлох баримт хангалгүй тайлагнасан байна. Цаашид эх сурвалжтай, нотлох баримтыг хавсаргаж тайлагнах.	70.0
			3	3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй уялдуулан ажиллах гэсэн заалтын дагуу ажил хийсэн талаар тайлагнаагүй тул үнэлгээг бууруулж, хэрэгжээгүй гэж үнэлсэн.	0.0

			4	4.Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган, хэрэгжилт, үр дүнг Монгол Улсын Их Хуралд жил бүр танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.	Тус зааltын хэрэгжилтийг эрчимжүүлэх, Улсын хөгжлийн жилийн төлөвлгөөнд тусгах ажлыг зохион байгуулах.	30.0

"ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН" ӨРНҮҮЛЭХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 166 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Актын №	Актын нэр	Батлагдсан огноо	Заалтын №	Заалт	Нэгдсэн биелэлт	Нэгдсэн үнэлгээ
2024_166	“Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай	2024-04-24	3	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.	Тухайн заалтаар өгсөн үүргийн дагуу аймаг сумдууд малчин иргэд, сум орон нутгийнхандаа Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулж, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна. Заалтын хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн бөгөөд хяналтаас хасах Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	100%
			4	“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, оролцогчдыг уялдаа, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-т хариуцуулж, шаардагдах нэмэлт зардлыг Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Шинэ хоршоо хөдөлгөөн” мэдээллийн сайт, хоршооны лавлах үйлчилгээний 1800-2024 дуудлагын утсыг тогтмол ажиллуулж, 06 дугаар сарын 10-нийг хүртэлх хугацаанд “Хоршоо-1600” цахим сургалтыг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригт 11.00-12.30 цагийн хооронд зохион байгуулж, нэг дор 1000 хүн нэвтрэх боломжтой холбоосыг үүсгэн сонирхсон иргэд, малчид, хоршоологчдод мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд ЗГХЭГ-аас 2024 оны 5-р сарын 2-ны өдрийн ХЭГ/900 тоот албан бичгээр тогтоолын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоог ирүүлсний дагуу Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэсэн байна. Заалтын хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн байна. /Хяналтаас хасах/ Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	100%
			5	Төлөвлөгөөнд тусгагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээ, бүсийн уулзалт, хэлэлцүүлэг, сургагч багш бэлтгэх сургалт, сургагч багш нарын орон нутагт ажиллах томилолт, замын зардал, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээний (showroom) арга хэмжээнд шаардагдах зардлыг Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар гүйцэтгэлээр тооцож санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.	ЗГХЭГ-аас 2024 оны 5-р сарын 2-ны өдрийн ХЭГ/900 тоот албан бичгээр тогтоолын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоог ирүүлсний дагуу Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэсэн байна. Хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн. /Хяналтаас хасах/ Хасах санал: Бүрэн хэрэгжсэн	100%
			6	Төлөвлөгөөний хүрээнд банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хоршооны гишүүн малчинд олгох зээлийг.эхний зээлжинд 3 жил хүртэл хугацаагаар олгож, шаардлагатай бол нийт зээлийн хугацаа 5 жилээс хэтрэхгүй байхаар сунгах, хоршооны гишүүн малчинд олгох зээлийн 6 (зургаа) нэгж хувийн хүүгээс давсан хүүгийн төлбөрийг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тооцож Засгийн газраас хариуцан төлөхөд Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар, 2025-2029 онуудад шаардагдах эх үүсвэрийг тухайн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт даалгасугай.	Заалтын хүрээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар 518 тэрбум төгрөгийн зээлийг нийт 15.1 мянган малчинд олгож, энэ хүрээнд 4026 хоршоонд санхүүжилт олгосон байна. 2024 онд нийт 500 тэрбумын зээл олгохоор төлөвлөж банкуудтай гэрээ байгуулсан. Энэ оны эхний 8 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнд хүрсэн тул гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж тус гэрээний хүрээнд 2025 оныг дуустал хугацаанд 1 их наяд төгрөгийн зээлийг нэмж олгохоор өөрчлөлт оруулаад байна. Заалтын хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн.	100%
			7	Малчдын хоршооны хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах чиглэлээр аймгийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.	Чиг үүрэгт хамааралгүй тул хяналтаас хасах Хасах санал: Чиг үүрэгт хамааралгүй	Х.Б

			8	Төлөвлөгөөний хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас хоршооны гишүүн малчинд гаргах зээлийн батлан даалтыг тус сангийн санхүүгийн чадавхыг сайжруулах зорилгоор коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын үед нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгөөр хангуулж, зохих журмын дагуу батлан даалт гаргахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөл (Т.Жамбалцэрэн)-д зөвшөөрсүгэй.	Заалтын хүрээнд шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас хоршооны гишүүн малчны зээлд гаргах батлан даалтын эрэлт их байгааг харгалзан сангийн бүтцийг хууль, журамд нийцүүлэн оновчтой болгох зорилгоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай” Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/401 дугаар тушаалыг батлуулсан бөгөөд журмын хэрэгжилтийн талаар танилцуулаагүй тул оноог бууруулав. Заалтын хэрэгжилт 70 хувь буюу хэрэгжих шатанд байна.	70%
			9	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад арга хэмжээний холбогдох шийдвэрийн төслийг тухай бүрд боловсруулан Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	Тухайн заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад арга хэмжээний холбогдох шийдвэрийн төслийг тухай бүрд боловсруулан Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж ажилласан байна. Заалтын хэрэгжилтийн 3 байгууллага тайлагнасан бөгөөд хэрэгжилтийн дундаж 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн байна.	100%
			10	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгасугай.	Тухайн заалтаар өгсөн үүргийн дагуу дүнг хагас жил тутам танилцуулсан эсэх талаар тайлагнах. Заалтын хэрэгжилт 70 хувь буюу хэрэгжих шатанд байна.	70%